

АНАГААХ УХААН

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

●
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

●
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ЛЕКЦ, ТОЙМ

●
ТУРШЛАГА СОЛИЛЦЬЁ

●
ХОВОР ТОХИОЛДОЛ

●
ЭРДЭМТДИЙН ДУГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

●
ГАДААД ОРНУУДАД

3

1987

АНАГААХ УХААН

БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яам, Эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн эрдэм шинжилгээ-практикийн улирал тутмын сэтгүүл

18 дахь жилдээ

№ 3 (63)

1987 он

АГУУЛГА

| | |
|--|----|
| ЗХУ-ын эрүүлийг хамгаалахын хөгжил, туршлага, сургамж | 3 |
| ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | |
| Б. Дэмбэрэл—Хүн амьт бүх нийтээр шатлан диспансерлахын онолын үндэс, практикийн ач холбогдол | 9 |
| III. Жигжидсүрэн, Ц. Мухар—Эмчийн сэтгэлгээ, орчин үе | 15 |
| СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ | |
| Б. Ганбаатар—Улаан бурхан өвчин тэй тэмцэх стратеги, тактик | 19 |
| Ц. Цэрэгмаа, А. А. Подколзин, В. А. Помилец—Эсэд цагирагт аденоzin монофосфат (Ц—АМФ)-ыг ихэсгэгч бодисыг хэрэглэн дархалын үл хариулах чанар үүсгэх нь | 24 |
| Д. Баасанжав, Г. Цагаанхүү—Мэдрэлийн өвчтонд үзүүлж байгаа стационарны тусламжийн байдал, түүнийг цаашид сайжруулах нь | 27 |
| З. Мэндсайхан, С. Балгансүрэн, В. В. Митин, Р. Цэвэлмаа—Залуу насны эрэгтэйчүүдийн дунд тохиолдож байгаа зүрх судасны эмгэгийн тархалтыг олноор флюор зураг авах шинжилгээгээр судалсан нь | 30 |
| Е. Думаа, Ш. Чадраавал, Д. Эржэн—Зүрхний цус тасалдах өвчтэй хүмүүсийн липидийн солилцоонд эмчилгээний хоол нөлөөлөх нь | 33 |
| Г. Энхдолгор, П. Мартасек, В. Кордак—Элэгний шинж тэмдгийн порфирия өвчин бүхий гэр бүл | 38 |
| Л. Оюунцэцэг, Т. Гомбосүрэн—В гепатитын эпидемиологийн зарим асуудал | 40 |
| М. Дарьсүрэн, Т. Варламова, Д. Дамдин, Ц. Готов—Дендронизид эмийн клиник туршилт | 41 |

СОДЕРЖАНИЕ

Развитие советского здравоохранения и его опыты, уроки 3

ОРГАНИЗАЦИЯ ЗДРАВООХРАНЕНИЯ

| | |
|--|----|
| Б. Дэмбэрэл—Теоретические основы всеобщей этапной диспансеризации населения и ее практическое значение | 9 |
| Ш. Жигжидсүрэн, Ц. Мухар—Врачебное мышление и современность | 15 |

ОРИГИНАЛЬНЫЕ СТАТЬИ

| | |
|--|----|
| Б. Ганбатар—Стратегия и тактика борьбы с корью | 19 |
| Ц. Цэрэгмаа, А. А. Подколзин, В. А. Помилец—Индукция иммунологической толерантности веществами, увеличивающими уровень внутриклеточного ц—АМФ | 24 |
| Д. Басанжав Г. Цагаанхүү—Состояние стационарной помощи неврологическим больным в МНР и пути ее улучшения | 27 |
| З. Мэндсайхан, С. Балгансүрэн, В. В. Митин, Р. Цэвэлмаа—Результаты предварительного изучения распространенности сердечной патологии среди молодых мужчин по данным массового флюорографического обследования | 30 |
| Е. Дума, Ш. Чадраавал, Д. Эржэн—Влияние диетотерапии на липидный обмен больных ишемической болезнью сердца | 33 |
| Г. Энхдолгор, П. Мартасек, В. Кордак—Семейные случаи симптоматической печеночной порfirии | 38 |
| Л. Оюунцэцэг, Т. Гомбосүрэн—Некоторые вопросы эпидемиологии гепатита В | 40 |
| М. Дарьсүрэн, Т. Варламова, Д. Дамдин, Ц. Готов—Клинические испытания Дендронизида | 41 |

ЛЕКЦ, ТОЙМ, ЗӨВЛӨГӨӨ

| | |
|--|----|
| Б. Жав—Эх барихуйн практик дахь геморрагийн шок | 44 |
| Т. Дэлгэр, Н. Жанцан, Б. Байгаль— Вируст гепатит | 47 |
| Ш. Бат-Эрдэнэ— Зүрхний цус тасалдах өвчиний эмийн сорилоор оношлох | 52 |
| Х. Рагчасурэн, Г. Тогтох— Түйлшируулагч холимгийг зүрх судалын практикт хэрэглэх нь | 54 |
| О. Батсүх, Г. Пүрэвсүрэн— Хэрлэгийн гаралтай зүрхний гажигтай жирэмсэн эмэгтэйчүүдийн хоол | 56 |
| Г. Навчсан, Г. Оросоо, Д. Энэбши— Төмөр, зэсийн ач холбогдол | 58 |
| Ш. Баяртготох— Хэрлэг өвчин дахиахаас урьдчилан сэргийлэх | 61 |
| АУГАА ИХ ОКТЯБРИЙН ХУВЬСГАЛЫН 70 ЖИЛИЙН ОИД | |
| Н. Цэнд— Урьдчилан сэргийлэх талаар В. И. Лениний үзэл санаа | 67 |
| — Өөрчлөн байгуулалт, зөвлөлтийн эрүүлийг хамгаалах салбарт | 69 |
| ТУРШЛАГА СОЛИЛЦЬЕ | |
| Ж. Тумбааш, Ж. Баасанхүү— Хөдөлмөрийг бригадаар зохион байгуулах аргыг эмнэлэгт нэвтрүүлсэн нь | 72 |
| ХОВОР ТОХИОЛДОЛ | |
| Б. Чултэмсүрэн— Бөөрний бэтэг | 74 |
| ЭРДЭМТДИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ | |
| Ц. Содномшил— БНМАУ-ын Эрүүлийг хамгаалахын удирдах байгууллагуудын ажлын зохион байгуулалт түүнийг боловсрон гүй болгох арга зам | 76 |
| М. Сүхбаатар— Хүүхдийн уушгини цочмог үрэвслийн янз бүрийн хэлбэрийн үе дэх цус бүлэг нэлт, ялтан эсийн байдал | 77 |
| МЭДЭЭ | |

ОБЗОРЫ, ЛЕКЦИИ, КОНСУЛЬТАЦИИ

| | |
|--|----|
| Б. Жав— Геморрагический шок в акушерском практике | 44 |
| Т. Дэлгэр, Н. Жанцан, Б. Байгаль— Вирусный гепатит | 47 |
| Ш. Бат-Эрдэнэ— Лекарственная тестовая диагностика | 52 |
| Х. Рагчасурэн, Г. Тогтох— Применение поляризующей смеси в кардиологической практике | 54 |
| О. Батсүх, Г. Пүрэвсүрэн— Питание беременных женщин с пороком сердца ревматического происхождения | 56 |
| Г. Навчсан, Г. Оросоо, Д. Энэбши— Значение железы и меди в организме | 58 |
| Ш. Баяртготох— Профилактика рецидива ревматизма | 61 |
| К 70 ЛЕТИЮ ВЕЛИКОГО ОКТЯБРЯ | |
| Н. Цэнд— Идей В. И. Ленина по профилактике заболевания | 67 |
| — Перестройка в советском здравоохранении | 69 |
| ОБМЕН ОПЫТОМ | |
| Ж. Тумбааш, Ж. Баасанхүү— Внедрение бригадной формы организации труда в больничном учреждении | 72 |
| РЕДКИЙ СЛУЧАЙ | |
| Б. Чултэмсүрэн— Почечный эхинококк | 74 |
| ДИССЕРТАЦИОННЫЕ ВЫВОДЫ И РЕКОМЕНДАЦИИ УЧЕНЫХ | |
| Ц Содномшил— Организация работы органов управления здравоохранением МНР и пути ее совершенствования | 76 |
| М. Сүхэбатор— Состояние тромбопатарно-коагуляционного гемостаза при различных формах острой пневмонии у детей | 77 |
| ХРОНИКА | |

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ш. Жигжидсүрэн (эрхлэгч), **[Ш. Ванчаарай** (Хариуцлагатай нарийн бичгийн дарга) **Б. Геош, Г. Даашэвэг, Б. Дэмбэрэл, Б. Жав, Л. Лхагва, Э. Лувсандагва, П. Нямдаваа, Д. Ням-Осор, Д. Самбуупүрэв, Г. Цагаанхүү, Б. Цэрэндаш**

Техник редактор **Б. Болат**

Хянаагч **М. Лхамсүрэн, Г. Ханджав**

Өрөлтөнд 1987 оны 6 сарын 23 ид орж 2794 ш хэвлэв.

Цаасны хэмжээ 70×108 1/16 хэвлэлийн хуудас 5

Зах. № С—113. Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинатад хэвлэв.

Д. Сүхбаатарын талбай 6

МАНАЙ ХАЯГ:

Улаанбаатар 48, Карл Марксын гудамж—4, Эрүүлийг хамгаалах Яам, Эмнэлгийн хэвлэлийн нэгдсэн редакци Утас 22430

ЗХУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ХӨГЖИЛ, ТУРШЛАГА, СУРГАМЖ

Түүхэн хөгжлийн хугацаанд ЗХУ-ын эрүүлийг хамгаалах салбар олон зорилтыг дэвшүүлэн шийдвэрлэхийн зэрэгцээ бэрхшээл саадыг даван өнөөгийн хөгжлийн түвшинд хүрсэн түүхтэй. 1986 оны байдлаар ЗХУ-д эмнэлгийн 3,3 сая ор, 1,2 сая их эмч, 3,2 сая дунд мэргэжилтэн ажиллах болсон нь 10,000 хүн амд 129,7 ор, 42 их эмч, 114,5 дунд мэргэжилтэн ногдох болжээ. Энэ нь эмнэлгийн тусlamжийн хүрэлцээний хувьд дэлхийн улс орны дээд хэмжээ юм.

Үүний хамт ЗХУ-ын эрүүлийг хамгаалахын хөгжилт олон улсын чухал ач холбогдолтой түүхэн туршлага болсон бөгөөд болсоор байна. Үүний бодит баримт тодорхой жишээний нэг нь ЗХУ-ын интернационалч тусlamжаар феодализмаас капитализмыг алгасаж социалистийнгэмд шилжин хөгжсөн манай орны социалист эрүүлийг хамгаалахын хөгжил юм.

«...Зөвлөлтийн хүмүүсийн эрүүл мэндийг бэхжүүлэх, хот, хөдөөгийн хүн амыг эмнэлгийн өндөр мэргэшлийн бүх төрлийн үйлчилгээгээр үйлчлэх хэрэгцээг газар сайгүй бурэн хангаж, эмнэлгийн үйлчилгээний чанарыг үндсээр нь сайжруулах зорилтыг нам дэвшүүлж байна. Энэ зорилгоор хүн амыг бүх нийтээр нь диспансерчлах системийг нэвтрүүлэх, эх нялхсэн эрүүл мэндийг хамгаалах байгууллага, нэгдсэн эмнэлэг, больница, сувиллын газруудыг цаашид хөгжүүлэх, тэдгээрийг орчин үеийн эмнэлгийн аппарат, төхөөрөмжөөр тоноглэх, эмчилгээний зүйл, ариун цэвэр-эрүүл ахуйн хэрэгслэлээр булох, эм, эмчилгээний зүйл, ариун цэвэр-эрүүл ахуйн хэрэгслэлээр буян хангахаар төлөвлөж байна.

Хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, бие хүнийг уvtэгши хөгжүүлэх, залуучуудыг хөдөлмөрт сургах болон эх орноо хамгаалахад бэлтгэхэд биений тамир, спорт түүнийг өдөр тутмын амьдралд нэвтрүүлэхийн ач холбогдол нэмэгдсээр байна. Иймд хүн бурийг бага залуугаас нь эхлэн бие бялдраа цог жавхаа төгс болгох талаар санаа тавьдаг, ариун цэврийн болон эмнэлгийн тусlamжийн зохих мэдлэгтэйгээр зөв сайхан аж төрдөг байхаар уг ажлыг зохион байгуулбал зохино» гэж ЗХУКН-ын ХХVII их хурлаар баталж шинэчлэн боловсруулсан III программд заажээ.

ЗХУКН-ын ХХVII их хурал дээр ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев тавьсан илтгэлдээ:

«...Хүн бурийн хувьд, нийгмийн хувьд ч гэсэн эрүүл мэндээс илүү үнэт зүйл байхгүй. Хүн ардын эрүүл мэндийг хамгаалж, сайжруулах нь эн тэргүүний эрхэм зүйл хэрэг мөн. Эрүүл мэндийн асуудлыг бид нийгмийн өргөн байрнаас авч узэх ёстой. Тэр нь юуны өмнө, хөдөлмөр ахуйн нөхцөл, амьдралын түвшинээс хамаарна. Ардын эрүүлийг хамгаалах явдал асар их ач холбогдолтой нь мэдээж. Хүн амын эмчилгээ сувилгааны болон эмийн чанар сайтай тусlamж авах хэрэгцээг аль болох түргэн, газар сайгүй хангах нь чухал байна. Энэ бүхэн эрүүлийг хамгаалахын материал-техникийн баазын тухай, түүнчлэн эрдэм шинжилгээ, зохион байгуулалт, боловсон хүчний нэн тулгамдсан олон асуудлыг шинээр шийдвэрлэхийг шаардаж байна.

Үнд багагүй хөрөнгө шаардагдах нь мэдээж бөгөөд түүнийг бид олох ёстой.

Эрүүл мэндийг эмийн сангаас худалдан авч болохгүй гэдэг эртний үнэн үг бий. Хүний амьдралын хэвшилд тухайлбал, чөлөөт цагаа хэр зэрэг ухаалаг, ашигтай зарцуулж байгаад асуудлын гол оршино. Үнд зэрэг ухаалаг, ашигтай зарцуулж байгаад асуудлын гол оршино. Үнд бололцоо нөхцөл байгаа боловч ажил хэргийн зохион байгуулалт ноцтой доголдож байна. Олон нийтийн үүсгэл санаачлагага, хүн амын сайн төрлийн ажиллагаанаас олон зүйл хамаарах боловч хот хөдөөд хөдөлж мөрийн хамт олны дунд дээрээс шийдвэр хулээж, тусlamж горьдож

суух нь цөөнгүй. Бид өөрийн мэдэлд байгаа зүйл, соёлын ордон, клуб, стадион, парк, бусад олон зүйлийг яагаад муу ашиглаж байна вэ? Зөвлөл, үйлдвэрчний ээлэл, залуучуудын эвлэлийн байгууллага энэ асуудлыг хөндөж хөдөлгөж болохгүй гэж үү? Оршин суугаа газраа хялбар хийцтэй спорт заал, биеийн тамирын талбай байгуулах талаар илүү идэвхтэй ажиллах хөдөлгөөн өрнүүлж болохгүй гэж үү? Эцэст нь хоршооллын үндсэн дээр спортын, тойрон аяллын болон бусад клуб байгуулж болохгүй гэж үү? хэмээн тэмдэглэсэн билээ.

Эдгээр үндсэн чиглэл, заалтыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүд ЗСБНХУ-ын эдийн засаг-нийгмийг 1986—1990 он болон (XII таван жилийн төлөвлөгөө) 2000 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдан хэрэгжиж байна. Уг үндсэн чиглэл, төлөвлөгөөний гол зорилго нь:

— Өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүчтэй болгож бүх хүн амыг диспансерчлах,

— Эмнэлгийн тусламжийн чанар, соёлыг уlam сайжруулах,

— Эрүүлийг хамгаалах байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, хуучин эмнэлгийг шинээр тоноглох,

— Анаагаах ухааны боловсон хүчин бэлтгэх, хүмүүжүүлэх ажлын чанарыг сайжруулах,

— Анаагаах ухааны хөгжил болон эрүүлийг хамгаалахын практикт шинжлэх ухаан-техникийн ололтыг нэвтрүүлэх ажлыг түргэтгэх,

— Эрүүлийг хамгаалахын удирдлагын систем, аж ахуйг эрхлэх аргыг төгөлдөржүүлэх,

— Эрүүл аж төрөх ёсыг өргөтгэн нэвтрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөвхөн эрүүлийг хамгаалах системийн хүрээнд бус нийт улс орны хэмжээнд (нам, улс, олон нийтийн байгууллагыг өргөн хамарсан) иж бүрэн цогцолбор хэлбэрээр зохион байгуулах зэрэг гол гогцоо асуудалд анхаарлаа төвлөрүүлж байна. Гэхдээ эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд хамгийн бодитой, зөв, дот арга хэлбэрийг сонгон авах бөгөөд ЗХУКН-ын ХХVII их хурлаас дэвшүүлсэн эдийн засаг-нийгмийн хөгжлийг хурдаасах, өөрчлөн байгуулалтын зорилтой (өргөн ардчилал, ил тод байх, шинэ сэтгэлгээ, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх г. м) дүйцэх ёстой. Энэ асуудалд зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын олон шатны удирдлага, хүмүүс янз бүрээр хандаж, өргөн хэмжээгээр ил тод шүүн хэлэлцэж байна.

Үүнтэй холбогдуулан ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны коллеги 1987 оны 3-р сард «Зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын байдал ба ЗХУКН-ын ХХVII их хурал болон Тэв Хорооны нэгдүгээр сарын (1987 оны) бүгд хурлын шийдвэрийн дагуу өөрчлөн байгуулах хэтийн төлөвийн тухай асуудал» хэлэлцсэн юм. Уг хурлын материал орчин үед ЗСБНХУ-ын эрүүлийг хамгаалахын гол гогцоо асуудлыг хөндөж байгаагаараа ихээхэн анхаарал татаж байгаа бөгөөд манай орны эрүүлийг хамгаалахын зохион байгуулагчид, нийт эмч ажилчдад үлэмж сургамжтай юм.

Уг хуралд уг хэлсэн ЗСБНХОУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны сайд А. И. Потапов «ЗХУ-ын эрүүлийг хамгаалах систем өвчилжээ. Гэхдээ бүр хүнд өвчилжээ. Одоогоор оношийг бүрэн тогтоогсогуй, эмчилгээний программыг боловсруулаагүй, тавилан нч тодорхой бус байна» гэсэн билээ. Мөн хуралд илтгэл тавьсан ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны сайд Е. И. Чазов «...ЗХУ-ын эрүүлийг хамгаалак системд манай орны нийгмийн уйл амьдралын аль ч хүрээ (салбар)-нээс илүү их бэрхшээл дутагдал, шийдвэрлэгдээгүй асуудал хуримтлагджээ. Энэ салбарт өнгөрсөн хугацаанд (ЗХУКН-ын ХХVII их хурлаас хойц) ямар нэгэн хувьстالت өөрчлөлт байтугай, мэдэгдэхүйц ахиц гарсангүй» гэж тэмдэглээд ЗХУ-ын эрүүлийг хамгаалахын ажилд оршиж ирсэн үндсэн дутагдуудыг зааж, түүнийг арилгах, сайжруулах зарим асуудал, арга замыг дэвшүүлэн тавилаа.

ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны коллеги ажилд оршиж ирсэн дутагдлыг ил тод шүүн хэлэлцэж цаашид өөрчлөн байгуулах арга хэмжээг 4 гол чиглэлээр тодорхойлон заав. Үүнд:

1. Эрүүлийг хамгаалахын удирдлага, төлөвлөлт зохион байгуулалтыг эрс сайжруулах,
2. Эрүүлийг хамгаалахын материаллаг баазыг бэхжүүлэх өргөн далайцтай арга хэмжээг авах,
3. Боловсон хүчний асуудлыг онцгойлон анхаарч чанарыг эрс дээшлүүлэх,
4. Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлж, үр дүнг практикт бодино хугацаанд нэвтрүүлэх зэрэг болно.

Эдгээрийн талаар товч дурдъя:

1. Эрүүлийг хамгаалахын удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтад оршиж ирсэн үндсэн дутагдал нь:

а) Эрүүлийг хамгаалахын удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын асуудалд экстенсив аргыг голлож тооны үзүүлэлтийн хойноос хэт хөөцөлдсөн нь ажлын чанарыг хохируулж, одоогийн шаардлагыг хангаж чадахгүйд хүргэжээ. Жишээ нь: ЗХУ одоо 3 сая 300 гаруй мянган ортой (10 000 хүн амд 129,7 ор) нь дэлхийд тэргүүн байр эзэлж байгаа боловч эмнэлгийн тусlamжийн чанар ЭЗХТЗ гишүүн зарим орнуудад хүрэхгүй байна. ЗХУ-д эмнэлгийн орны өртөг өнгөрсөн 5 жилд 14,7 мянга, энэ 5 жилд (XII) 18,4 мянган рубль байхад зарим социалист орснд энэ норматив 40 мянгаас 80 мянган рубль байна. Энэчлэн эмнэлэг (больниц)-ийн зураг төслийг зохисход ЗХУ-д уг эмнэлгийн бүх өртгийн 15%-ийг эмнэлгийн ба технологийн төхөөрөмж эзэлдэг бол ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудад 40% байгаа ажээ.

Ийм нэхцэлд орчин үеийн анагаах ухааны ололт, технологийг газар бүр нэвтрүүлэх нь үнэхээр бэрхшээлтэй нь мэдээж. Үүний дээр ашиглалтанд оруулах орны төлөвлөгөөг биелүүлэхийг гол болгон хөөцөлдөж олон арван больницыг орон сууц, нийтийн байр, бусад барилгын «дайвар» болгон байгуулж (ж нь: ЗСБНХОУ-д шинээр ашиглалтанд оруулсан орны 40% нь зориулалтын бус барилгад байрлаж байна) хуучин больницуудыг засаж сэлбэх, өөрчлөн тохижуулах ажил үлэмж хоцорчээ. Үүнээс шалтгаалан ЗХУ-ын эрүүл ахуйн нормоор больнициын нэг оронд 7 м² талбай ногдох ёстой атал 4,2 м² талбай ногдох болж зарим эмнэлэг халуун, хүйтэн усны ба бохир усыг зайлуулах системгүй ажиллахад хүрчээ.

Энэчлэн амбулатори-поликлиникийн ажлыг дан ганц үзлэгээр төлөвлөн дүгнэх арга барил ноёрхож тооны хойноос хэт хөөцөлдсөнөөс хүмүүст үзүүлэх тусlamжийн чанар догоолдож зарим үед эмч эмнэлгийн ажилчдын хүнлэг үзэл, хариуцлагыг ч сулруулахад хүргэжээ. (зөвхөн үзлэгийн төлөвлөгөө биелүүлэх ганц зорилтод захирагдсанас) Үүний дээр зарим газар байгууллагад зохих бэлтгэл нэхцэл хангагдаагүй байхад бүх хүн амьг жил бүр диспансерчлах ихээхэн нүсэр ажлыг эхэлсэн нь үзлэгийн тоог эрс нэмэгдүүлж, үр дүн багатай ажил болж байгааг эмч ажилчид зүй ёсоор шүүмжлэх болжээ.

б) Эрүүлийг хамгаалах удирдлага (тухайлбал ЭХЯ) нь төвлөрсөн удирдлатыг хэт голлож, орон нутгийн болон доод шатны байгууллагын бие даасан байдал, идэвх санаачилгыг дарагдуулж ажлын дутагдал догоолдлыг дор бүр нь илрүүлж арилгахын оронд амжилт бүтээлээр халхавчилж, дутагдалтай эвлэрэнгүй хандсан, ажлыг үнэлж дүгнэхэд материаллат сонирхол, аж ахуйн механизмыг хангалтгүй ашигласан,

в) Эрүүлийг хамгаалахын удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын ажлын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, эмнэлгийн байгууллагын ажлыг дүгнэх чанарын үзүүлэлтийг боловсруулах талаар Нийгмийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулал-

тыг эрдэм шинжилгээний байгууллага (Семашкогийн нэрэмжит институт, Анааах ухааны академийн зарим институт, хүрээлэн)-үүд хангалтгүй ажилласан,

г) Эрүүлийг хамгаалах олон байгууллагын удирдатчид, улсын ариун цэврийн байцаан шалгах ерөнхий газар, орон нутгийн ариун цэврийн хяналтын байгууллагууд «Үрьдчилан сэргийлэх иж бүрэн программын биелэлтэд» зохих ёсоор хяналт тавьж чадаагүйгээс 70 гаруй яам, тусгай газар оролцсон энэ чухал төлөвлөгөөний олон заалт тасарнаас гадна зөвхөн орчныг бохирдлоос хамгаалахтай холбоо бүхий 196 заалтын зөвхөн 47 нь хэрэгжин, 104 хотод орчныг бохирдуулагч бодисын хэмжээ тогтоосон нормоос хэтэрч, ахуй хангамжийн газруудын 1/4; тусгай газар байгууллагын 1/3 нь хаягдал усыг дутуу цэвэрлэж орчныг бохирдуулж тэр нь гэдэсний болон бусад халдварт өвчин үе үе гарах эх сурвалж байгааг заан шүүмжилжээ. Гэтэл уг ажлыг гардан хариуцаж өндөр шаардлага тавьж таслан зогсоовол зохих ариун цэврийн хяналтын ба эмнэлгийн байгууллагууд үргээ муу биелүүлэн дутагдалтай эвлэрч өөрсдийгөө «зөвхөн засварлах алба» болгон хувиргажээ. Мөн бүх хүн амыг жил бүр диспансерчлах ажлыг одоогийн нөхцөлд бодит боломжгүйг шүүмжилж «Энэ бол улсыг хуурч байгаа хэрэг» гэж онцлон заав.

Дээрх дутагдлуудыг арилгах, эрүүлийг хамгаалахын удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын талаар:

— Удирдлагын экстенсив аргаас бүх салбарт интенсив аргад шилжиж зөвлөлт улсын хэмжээнд яватдаж байгаа өөрчлөн байгуулалтын дагуу шинэ сэктэлгээ, арга барилаар ажиллаж зөрчлийг шүүмжлэн ил тод байдлыг өрнүүлэх;

— Ажлыг дүгнэх, төлөвлөхөд тооны үзүүлэлтээс чанарын үзүүлэлтэд, явцын (дундах) үзүүлэлтээс эцсийн үзүүлэлтэнд шилжих, ЭХЯ бусад удирдах байгууллагын удирдлагыг шуурхай, уян хатан болгож нэгж байгууллагын санаачилга бие даасан байдлыг хангаж материаллаг сонирхол, аж ахуйн аргыг өргөн нэвтрүүлэх,

— Ариун цэврийн хяналтын далайц үр нөлөөг эрс дээшлүүлж, үрьдчилан сэргийлэх ажлыг бүх шугамаар эрчимжүүлэх,

— Бүх хүн амыг жил бүр диспансерчлахаас хүн амыг шатлан диспансерчлахад шилжиж 1995 оноос энэ ажлыг бүрэн хэмжээгээр явуулах.

— Ялангуяа эмнэлгийн нэгж (салбар) байгууллагын ажлыг олон тооны мэдээ, маягт, үзлэг дуудлагаар дүгнэдэг байсан аргыг өөрчилж тэднийг хариуцсан ажлынх нь эцсийн үр дүнгээр дүгнэж, тэдэнд зохих хэмжээний эрх итгэл хүлээлгэх (Ж нь: хэсгийн эмчийн ажлыг хариуцаж байгаа 1800 хүний эрүүл мэндийн өөрчлөлтөөр дүгнэх, гол ажлыг үрьдчилан сэргийлэхэд чиглүүлэх, больнициын хуудсыг 10—12 хоногоор бичдэг болгох г. м) зэрэг зорилтуудыг дэвшүүлэв.

2. Эрүүлийг хамгаалахын материаллаг баазыг бэхжүүлэх талаар ЗХУ өндөр амжилт олсон боловч эмнэлгийн барилга байгууламжийн зураг тесөл, техникийн ба эм багажийн хангамж (хүрэлцээ), чанар одоогийн шаардлагаас үлэмж хоцорч зарим багаж төхөөрөмж нь анааах ухаан өндөр хөгжсөн зарим орны тувшинд хүрээгүй, зарим багажийн ба лабораторийн хүчин чадлыг дутуу ашиглаж байгааг тодорхой баримтаар шүүмжлэн уг ажлыг эрс сайжруулах зорилтыг дэвшүүлэв.

Мөн больнициын орны фонд ашиглалтыг сайжруулахад больнициын өмнөх буюу амбулатори-поликлиникийн оношлогоо эмчилгээг өргөжүүлж шинэ байгууллага-оношлогооны төвийг өргөн байгуулахаар заав. (Энэ 5 жилд 25, дараагийн 5 жилд 50—60-ыг байгуулна).

Энэ нь газар бүрт байгуулах боломжгүй эмчилгээ-оношлогооны нарийн төвөгтэй аргыг төвлөрүүлэн зохион байгуулж, хүн амд хүртээмжтэй болгох бололцоог олгох ажээ.

3. ЗСБНХУ-д одоо (1986 он) 1 сая 200 мянга гаруй их эмч ажиллаж (10000 хүн амд 42 их эмч) байгаа нь дэлхийн их эмч нарын 1/3-ийг эзэлж байгаа юм. Гэвч саявтар 350 мянган эмч наарт явуулсан аттестатчлалын дунгээс узэхэд 30 мянга нь буюу бараг 10% нь аттестатчилагдсанд «тооцогдож» мянгаад нь ажлаасаа өөрчлөгджээ.

Мён Москва хотын анагаах ухааны дээд сургууль төгсөгчдийн дунд Москва хотын Гүйцэтгэх Хорооны Эрүүлийг хамгаалах газраас эрхлэн хийсэн экспертийн үнэлгээнээс узэхэд шалгалтанд хамрагдагсдын 27,7% нь дунд ба түүнээс доош үнэлгээ авч 36% нь эрхэлж байгаа мэргэжлийн ажлынхаа ур чадвар, практик дадлагыг эзэмшиж чадаагүй байжээ.

«Энэ бүхэн нь эмч нарыг бэлтгэж буй сургалтын систем орчин үеийн шаардлагыг хангахгүй сургалтын ажиллагаа эрүүлийг хамгаалахын практик шаардлагаас хөндий тасархай, онц хэрэгцээгүй мэдээллээр сургалтын ачааллыг хүндруүлж байна» гэсэн зарчмын дүгнэлт хийж цаашид:

— Эрүүлийг хамгаалахын практик шаардлагатай холбон сургалтын системийг өөрчлөн байгуулах;

Суралцагчдад тавих шаардлагыг эрс өндөржүүлэх (7 жил суралцахдаа сургалтын зохих шаардлага хангагүй оюутанд их эмчийн бус бага эмчийн диплом олгох)

— Сургалтын чанарыг сайжруулах зорилгоор оюутны бие даасан ажиллагаа, хариуцлагыг дээшлүүлж нэг багшид ногдох оюутны тоог щөөрүүлэх;

— Эмчийн мэргэжлийг тохиолдлоор эзэмшисэн буюу эмчийн ариун нэр алдар, өндөр шаардлагыг эрхэмлэн хадгалж чадахгүй буюу хүсэхтүй байгаа хүмүүстэй эвлэршгүй тэмцэл явуулж тийм хүмүүсийн эмчийн дипломыг хураах эрх зүйн арга хэмжээ авах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн боловсруулж байна.

4. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны ажлын түвшин үр дүнг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулалтын зарим өөрчлөлт хийж томоохон зорилт дэвшүүлэв.

— Эрдэм шинжилгээний томоохон байгууллага, институт ажлаа зөвхөн мэргэжлийн аргачлал, зөвлөмжөөр хязгаарлах нь хангалтгүй тул тэдгээрийн хүчийг эмчилгээ, оношлогооны шинэ багаж төхөөрөмж, шинэ эм, онолын шинэ үндэслэл боловсруулахад чиглүүлэх,

— Ийм зорилтыг зөвхөн эрдэм шинжилгээний томоохон төв гүйцэтгэж чадах тул үр өгөөж муутай эрдэм шинжилгээний зарим институтыг хааж (100 орчим) хэмнэсэн хөрөнгө хүчээр бусдыг нь бэхжүүлэх арга хэмжээ авах,

— Судалгаа шинжилгээний ажлын удирдлага, төлөвлөлт, өгөөжийг сайжруулах зорилгоор ЭХЯ-ны эрдмийн зөвлөлийг зөвлөх эрхтэй байгууллага болгон өөрчилж оронд нь Эрүүлийг хамгаалах Яаманд шинжлэх ухаан-техникийн удирдлагын ерөнхий газрыг байтуулав.

Зөвлөлтийн эрүүлийг хамгаалах ажлыг ЗХУКН-ын XXVII их хурал болон ЗХУКН-ын Төв Хорооны 1987 оны 1-р сарын бүгд хурлын заалтын дагуу өөрчлөн байгуулах дээрх үндсэн чиглэлүүдийн хамт ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны коллегийн хурал зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын тулгамдсан чухал асуудлууд (эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулж хүүхдийн нас баралт, халдварт өвчний гаралтыг багасгах, ууж согтуурах явдалтай тэмцэх ажлыг улам эрчимжүүлж наркологийн тусламжийн зохион байгуулалтыг сайжруулан үр дүнг дээшлүүлэх г. м)-ыг ажил хэрэгчээр ил тод хэлэлцэв.

Зөвлөлтийн эрүүлийг хамгаалахыг орчин үеийн шаардлагын дагуу өөрчлөн байгуулахад онцгой анхаарал татах байгаа асуудлын

нэг нь социалист эрүүлийг хамгаалахын урьдчилан сэргийлэх чиглэлийг бүхий л хүрээгээр өргөжүүлж үр дүн, эрч далайцыг нэмэгдүүлэх, уг ажлыг хэрэгжүүлэх болон эрүүлийг хамгаалахын материаллаг баатыг бэхжүүлэхэд улс, олон нийт, хоршоолол, үйлдвэр, аж ахуйн байгууллагуудыг өргөн татаан оролцуулах явдал юм. Энэ талаар ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны сайд Е. И. Чазов коллегийн хуралд тавьсан илтгэлдээ цохон тэмдэглэхийн хамт Правда сонины сурвалжлагчид өгсөн хариундаа хөндөж тавьсан асуудлууд нийтийн анхаарлыг татаж байна. Үүнд:

— ЗСБНХУ-ын хэмжээнд хэрэгжүүлж байгаа урьдчилан сэргийлэх ажлын иж бүрэн (догцолбор) программын биелэлтэнд тавих хяналтыг эрс сайжруулах,

— Орчныг бохирдлоос хамгаалах, хөдөлмөрийн болон хүнсний эрүүл ахуйн талаар ариун цэврийн хяналтын үр нөлөөг эрс дээшүүлэх,

— Хүн амын дунд эрүүл аж төрөх ёс, биеийн тамирын хөдөлгөөн, амралт-сувиллыг өргөжүүлэхэд эрүүлийг хамгаалахын оролцоог улам өргөжүүлэх, ялангуяа эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх ажлыг хүүхэд ёсвөр наасны залуучуудын дунд өргөн зохиох энэ ажлыг эмч эмнэлгийн ажилчид өөрсдөө хувийн үлгэр жишээгээр үлгэрлэж манлайллах,

— Амбулатори-поликлиникийн тусламж, диспансерчлалыг өргөжүүлж хэсгийн эмчийн ажлыг урьдчилан сэргийлэх, хэсгийнхээ хүн амын эрүүл мэндийг бүхэлд нь хариуцахад чиглүүлж тэдний эрх хэмжээг өргөтгэн, итгэл найдвар хүлээлгэх,

Цаашид энэ ажлыг урьдчилан сэргийлэх бусад салбар (ариун цэвэр халдварт судлалын станц, ариун цэвэр-гэгээрлийн ажил, эмнэлэг-биеийн тамирын хяналтын диспансер г. м)-тай холбож зохион байгуулах,

— Энэ ажлыг зохион байгуулахад ЭХЯ-д шинээр байгуулагдсан «Урьдчилан сэргийлэх хэлтэс» чухал үүрэг гүйцэтгэх болно.

— Эмнэлгийн үнэ төлбөргүй тусламжийг улам хөгжүүлэхийн хамт хүний амь наасанд аюултай бус зарим тусламжаар үнэ төлбөртэй үзүүлэх хэлбэрийг өргөжүүлэх, (1995 онд аж ахуйн тооцоотой поликлиникийг 2 дахин нэмэгдүүлэх) улс, хоршооллын байгууллага, иргэдийн сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн фонд байгуулах,

ЗХУ-ын үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлтэй тохиролцсоны үндсэн дээр 5000-аас дээш ажилчидтай үйлдвэрүүдэд тэдгээрийн хөрөнгөөр амралт-сувилал байгуулах,

— Хөдөлмөрийн чадвар түр алдалтыг бууруулснаас хэмнэсэн хөрөнгийг эрүүлийг хамгаалахад ашиглах, үйлдвэрчний эвлэлийн амралт сувиллын 20 мянган орыг эрүүлийг хамгаалахын реабilitац (нөхөн сэргээх) арга хэмжээнд шилжүүлэх,

— Тамхи татагчаас 3—5 мөнгөний татвар татаж түүнийг нь тамхины улмаас үүссэн өвчнийг эмчлэхэд зарцуулах зэрэг олон чухал санаануудыг сэдэн тавьжээ.

ЗСБНХУ-ын эрүүлийг хамгаалахын хөгжлийн одоогийн шатанд тавигдаж байгаа дээр дурдсан зорилт, бүтээлч шүүмжлэл нь зөвлөлт орны хөгжингүй социалист нийгмийн орчин үеийн хөгжлөөс үүсэн гарч байгаа өндөр шаардлага юм. Үүнийг далимдуулан ЗХУ-ын эрүүлийг хамгаалахын дутагдал доголдлыг шүүмжлэх нэрийн дор зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын улс орны болон дэлхий дахини түүхэн ач холбогдлыг угүйсгэж болохгүй нь мэдээж бөгөөд, аугаа их октябрыйн социалист хувьсгалаар жигүүрлэж, В. И. Лениний шууд удирдлагаар зохион байгуулсан зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын түүхэн туршилага одоо ч дэлхийн социалист системийн эрүүлийг хамгаалахын манлайд үлгэрлэн хошуучилж байна.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Б. Дэмбэрэл (Эрүүлийг хамгаалахын удирдлагын эрдэм шинжилгээний төв)

ХҮН АМЫГ БҮХ НИЙТЭЭР ШАТЛАН ДИСПАНСЕРЧЛАХЫН ОНОЛЫН ҮНДЭС, ПРАКТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ

1976 онд Москва хотод хуралдсан социалист орнуудын Эрүүлийг хамгаалах Яамны сайд нарын XVII зөвлөгөөн «Социалист эрүүлийг хамгаалахын хөгжлийн үндсэн чиглэл, хетийн төлөв»-ийн тухай асуудал хэлэлцээд дэвшүүлсэн зорилтынхоо дотор «...Орон тус бүрийн онцлогийт харгалзан бүх хүн амьг аажмаар диспансерийн хяналтад бүрэн хамрах шаталсан арга хэмжээ авах» чухал зорилтыг дэвшүүлсэн билээ.

Дараа нь 1977 онд Москва хотод хуралдсан ЭЗХТЗ-ийн эрүүлийг хамгаалах салбар дахь байнгын комиссын 5-р хуралдаанаар «ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хэмжээнд диспансерчлах аргыг хөгжүүлэх чиглэлийн тухай» асуудал хэлэлцээд диспансерчлах аргыг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, чиглэлийг тусгасан баримт бичгийг батлан гаргасан юм.

Москвагийн зөвлөгөөнөөс хойш, эдгээр баримт бичгүүдэд тулгуурлан социалист хамтын нөхөрлөлийн орнуудын коммунист ажилчны наਮуудын их хурал, бусад үндсэн баримт бичгүүдэд эрүүлийг хамгаалахын зорилтыг тодорхойлохдоо «хүн амьг нийтээр нь шатлан диспансерчлах» «диспансерчлалыг өргөтгэж хөгжүүлэх» асуудлыг тусгаж орчин үеийн чухал зорилт болгон дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Үг зорилтыг хэрэгжүүлэх ажлын явцад бүх социалист орнуудад диспансерчлах аргын талаар нэгдсэн ойлголт, зохион байгуулалтын нэгдсэн хэлбэр тогтох (тусгай мэргэжлийн диспансер, оршин суугаа дэвсгэр нутгаар буюу ажлын байраар хяналт тогтоох г. м), ихэнх социалист орнуудад уг ажилд орчин үеийн электрон тооцооны машин (ЭТМ) нэвтрүүлэх эхлэлт тавьжээ.

Хөгжлийн одоогийн шатанд ЗХУ бүх хүн амьг жил бүр нийтээр нь диспансерчлах (ежегодная всеобщая диспансеризация) зорилтыг дэвшүүлэн практикт хэрэгжүүлж эхэлсэн ба бусад социалист орнууд уг ажлын бэлтгэлийг хангаж, хүн амын аль болох өргөн хэсгийг олоноор нь диспансерчлах (массовая диспансеризация) зорилтыг шийдвэрлэж байна.

ЭЗХТЗ-ийн гишүүн социалист бүх орныг хамарч байгаа өргөн цар хүрээтэй энэ зорилт онолын хувьд:

1. Социалист нийгмийн мөн чаанар, социалист эрүүлийг хамгаалахын агуулга, социалист аж төрөх ёсны шаардлагаас урган гарч байна.

Үчир нь: Эмнэлгийн үйлчилгээний диспансерчлах арга бол социалист эрүүлийг хамгаалахын гол зарчим-жанжин шугам-урьдчилан сэргийлэх чиглэлийг хэрэгжүүлдэг шалгарсан арга бөгөөд тэр нь хүний бие махбод хүрээлэн буй гадаад орчин, амьдарч байгаа нийгмийн орчны нэгдмэл холбооны тухай материалист онолд тулгуурлаж, урьдчилан сэргийлэх эмчлэн эдгэрүүлэх арга хэмжээг нэгдмэлээр хослон явуулах өргөн боломж олгодогт уг аргын давуу тал оршино. Ийм арга хэмжээг нийгмийн хэмжээнд өргөн хүрээгээр авч хэрэгжүүлэх бодит боломжийг гагцхүү бодит социализм бүрдүүлж байгаад асуудлын гол зангилаа оршино. Энэ ч учраас, ер нь диспансерчлах арга, түүн дотор бүх нийтийг шатлан диспансерчлах нийгмийн өргөн цар хүрээтэй том зорилт гагцхүү социалист эрүүлийг хамгаалахын хүрээнд хэрэгжих бодит үндэстэй бөгөөд түүний хэрэгжин биелэхийн нийгэм эдийн засгийн үндэс нь социалист үйлдвэрлэлийн арга, социалист үйлдвэрлэ-

ЗХУ-Д НИЙТ ХУН АМЫГ ДИСПАНСЕРЧЛАХ ЗОРИЛТОГ ПРОГРАММЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН НӨХЦӨЛҮҮД

Хүчинээст I

УЛС НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ПРОГРАММ

| АНАГААХ УХААНЫ АРГА ХЭМЖЭЭ | АНАГААХ УХААНЫ АРГА ХЭМЖЭЭ | АНАГААХ УХААНЫ АРГА ХЭМЖЭЭ | АНАГААХ УХААНЫ АРГА ХЭМЖЭЭ |
|--|---|--|--|
| Зөвлөлтийн нийгмийн бүрэлдэхүүнийг жигдлиэн хөгжүүлэх лэх | Хүн амьтны амьдаралан түвшинг дээцлүүлэх | Хүрээлэн буй орчныг хамгаалах ажлыг сайжруулах | Хүн амьтны соёлын түвшин, зохион байгуулалттай ажиллагааг төгөлдөржүүлэх. |
| Үг зорилтыг намын програмчилсан баримт бичгүүдэл тусгаж, улс, одон нийтийн байгууллагыг эргэн оролцуулах | Өвчнийг эхний үе шатанд нь илдвэхтэй аргаар илрүүлэх | Бүх хүн амьн эрүүл мэндэл тасралтуг хяналт тогтоох | Нийгмийн ба урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэгдлийг хангах. |
| Больниц поликлиник диспансерийн өргөтгөх эмч, дунд мэргэжилтийн болит ханагамжийг сайжруулах. | Хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах Үндсэн дээр их эмч, дунд мэргэжилтийн болит ханагамжийг сайжруулах. | Хүн амьтны амьдаралтан төхөөрөмжийн Үйлдвэрлэлийг өргөтгөх | Шүүт-бын дэвшил УУН логотох, хүн амьтны эрүүл мэндийг хнакад автомат систем нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хууль эрхийн үндсийг өргөжүүлэх |

лийн харилцаа, социалист аж төрөх ёс юм.

2. Диспансерчлах аргыг өргөжүүлэх нь орчин үеийн социалист эрүүлийг хамгаалахын хөгжлийн түвшин (материаллаг бааз, боловсон хүчний хангамж г. м.) түүний давуу талаас гарч байна. (Хүснэгт 1-ээс узнэ үү).

3. Үйлчилгээний диспансерчлах аргыг шатлан өргөтгөх нь социалист эрүүлийг хамгаалахын одоогийн зорилтоос гадна, түүний ирээдүйн хөгжлийн төлөвөөс урган гарч байна. Шинжлэх ухаан техник, нийгмийн дэвшилийн орчин үед социалист орнуудад диспансерчлах аргын агуулга, түүний нийгэмд эзлэх байр суурь улам бүр өргөжин, урьд өмнө гол төлөв эрүүлийг хамгаалах байгууллагын хэмжээнд хэрэглэгддэг эмчилгээ үйлчилгээний арга байсан бол одоо (ялангуяа ЗХУ зэрэг хөгжингүй социалист орнуудад) улс олон нийт, эрүүлийг хамгаалах, нийгмийн даатгал, нийгэм хангамж зэрэг олон байгууллагын хамтын хүчээр хийгдэх нийгэм-анагаах ухааны цогцолбор бүрдмэл арга хэмжээ болон хөгжих хөгжингүй социалист нийгмийн эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын гол ундсэн хэлбэр болж хөгжих хэтийн төлөвтэй байна. Үүнийг зарим социалист орны эрдэмтэд (ЗХУ, БНБАУ) эрүүлийг хамгаалахын диспансерийн систем (диспансерная система здравоохранения) гэдэг шинэ ойлголтоор томьёолж байгаа юм.

Эрүүлийг хамгаалахын диспансерийн систем гэдэг нь хумус амбулатори-поликлиникт урсгалаар ирж үйлчлүүлэх бус, нийт хүн амын эрүүл мэндэд байнга тасралтгүй хяналт тогтоож, өвчин эмгэгийг эхний үе шатанд нь идэвхтэй аргаар илүүлэн эмнэлгийн бүх байгууллага урьдчилан сэргийлэх ба эмчлэн эдгэрүүлэх ажлын нэгдэл (полная интеграция), үйл ажиллагааны холбоо (приемственность) уялдааг хангаж, хөдөлмөр ахуй орчны нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн нийгэм эдийн засаг, техник, анагаах ухааны арга

хэмжээг хэрэгжүүлэхэд суурилагдсан эмнэлгийн тусламжийн зохион байгуулалтыг ойлгоно гэжээ.

4. Диспансерчлах аргыг өргөтгөн хэрэгжүүлэх нь орчин үеийн бодит социализмын эмчийн үйл ажиллагааны агуулга шаардлагаас үүдэн гарч байна.

Бодит социализмын нөхцөлд эмчийн ажлын агуулга нь зөвхөн эмчилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдахгүй эмч бол коммунист нам, социалист төрөөс хүн амын эрүүл мэндийн талаар авч явуулж буй арга хэмжээг хөдөлмөрчид хүн амын дунд гардан зохион байгуулагч, нийгмийн зүтгэлтэн юм.

Энэ ажлын эцсийн үр дүн социалист эрүүлийг хамгаалахын урьдчилан сэргийлэх чиглэлийг хэрхэн хэрэгжүүлснээр тодорхойлогдоно. (Хүснэгт 2).

Диспансерчлах аргыг шатлан өргөжүүлж, аажмаар бүх нийтийг хамрахын практик ач холбогдол нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийн хүрэлцээ, чанарыг шинэ шатанд гаргаж, эрүүлийг хамгаалахын нийгэм, анагаах ухаан, эдийн засгийн үр дүнг дээшлүүлснээр тодорхойлогдоно. Үүнтэй холбогдуулан эмч нарыг ажлынхаа (хяналтынхаа) үр дүнг эдийн засгийн аргаар дүгнэж, тооцож чаддаг болгон сургах нь нэн чухал.


5. Манай орон (БНМАУ)-ын хувьд энэ асуудал МАХН-ын XVII, XVIII, XIX их хурлаас дэвшиүүлсэн эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын шижим асуудлын нэг бөгөөд БНМАУ-ын хөдөө нутгийн өвөрмөц нөхцөлд өрхийн диспансерчлалыг хөгжүүлэх нь уг асуудлыг шийдвэрлэх тохиromжтой хэлбэр байж болох онцлогтой.

6. Диспансерчлах аргыг шатлан өргөжүүлж аажмаар бүх хүн амыг хамрах, цаашдаа эрүүлийг хамгаалахын диспансерийн систем тогтоох нь аль ч социалист орны эрүүлийг хамгаалахын өмнө орчин үеийн хөгжлийн шаардлагаар дэвшигдэн тавигдаж байгаа шинэ тулгар асуудал юм.

Энэ шинэ зорилтыг шийдвэрлэхэд ЗХУ-ын диспансерчлах аргыг

Xүснэгт 2

Үрьдчилан сэргийлэх ажилд эмчлэгч эмчийн гүйцэтгэх үүрэг



хөгжүүлэн хэрэгжүүлсэн туршлагаас суралцах нь зайлшгүй юм.

Суралцахдаа бид уг туршлагыг механикаар хуулбарлах буюу дуурайх бус шинэ сэтгэлгээ, арга барилын үүднээс бүтээлчээр тусган хэрэглэх хэрэгтэй юм.

Үүнтэй холбогдуулан 2 зүйлийг тэмдэглэхэд:

I. ЗХУ-ын эрүүлийг хамгаалахын хөгжлийн түүхээс үзэхэд ЗХУ-д диспансерчлах арга дан ганц «шүүд замаар» явсангүй зарим уед алдаж онож, тохиолдсон бэрхшээлийг давж туулж хөгжсөн түүхтэй.

Эдгээр алдаа, бэрхшээл нь гол төлөв болосон хүчин, материаллаг баазын зохих нөхцөл бүрдээгүй байхад «түргэвчилж» хийснээс шалтгаалж байсныг манай орны эрүүлийг хамгаалахын зохион байгуулагчид анхаарах нь зүйтэй юм.

II. ЗХУ-ын эрдэмтэд хүн амыг нийтээр нь диспансерчлах практик арга хэмжээнд шилжихэд гурван

гол нөхцөлийг харгалзахыг онцлон тэмдэглэж байна. (1).

Үүнд: а). Улс орны нийгэмэдийн эзгийн өндөр хөгжил (хөгжингүй социалист нийгмийн нөхцөлд).

б). Эрүүлийг хамгаалахын материал техникийн бааз нь хүн амын эрүүл мэндийн байдалд тасралтгүй идэвхтэй хяналт тавих нөхцөлийг хангахуйц хэмжээнд хүрсэн байх. (Эмнэлэг бүр бие даан «өөртөө үйлчилж» чаддаг болсон нөхцөлд).

в). Хөгжингүй социализмын нөхцөлд хүмүүсийн эрүүл мэнд нь зөвхөн уг хүний хувийн хэрэг бус, нийгмийн зайлшгүй хэрэгцээ болохыг иргэн бүр (хүн бүр) ухамсарласан нөхцөлд хийх юм.


Эдгээрээс үндэслэн манай оронд нийт хүн амыг шатлан диспансерчлахад бэлтгэл ажил, хэрэгжүүлэх хугацаанд маш парийн тооцоотой хандах нь чухал юм.

Саяхан (1986 оны XI сар) Улаанбаатар хотод БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах Яам, ДЭХБЫН ЗӨАБ хорооноос хамтран «Амбулатори-поликлиникийн тусламж, диспансерчлал» асуудлаар симпозиум зохион байгуулав. Уг симпозиумд Эрүүлийг хамгаалах Яам, Эрүүлийг хамгаалахын удирдлагын эрдэм шинжилгээний төвөөс боловсруулсан «БНМАУ-ын хүн амыг шатлан диспансерчлах» чиглэлээр 1986—1990 он буюу бэлтгэл шатанд

жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэд, үйлдвэрийн ажилчдыг диспансерчлах; 1991—1995 онд бүх ажиллагчид болон нийт хүн амын 60—80%-ийг хяналтад хамрах; 1996—2000 онд нийт хүн амыг хяналтанд бүрэн хамрах зорилтыг дэвшүүлэв. Уг зорилт нь стратегийн чиг шугамын хувьд зөв зүйтэй боловч түүнийг хэрэгжүүлэх хугацаа, практик арга хэмжээг маш нарийн тооцож, одоогийн хийж буй туршилт судалгаа (ЭХЯ-ны сайдын 1986 оны

Xүснэгт 3

Диспансерчлалын ангилал



148-р тушаал)-ны үр дүнг харгалзан цаашид тодотгож нарийсгах шаардлагатай мэт санагдана.

Урт хугацааг хамарч байгаа өргөн цар хүрээтэй энэхүү том зорилтын бүх талыг хөндөлгүй зөвхөн 1986—1990 оны бэлтгэл шатанд хийх зарим практик арга хэмжээнээс дурддяа.

Юуны өмнө диспансерийн хяналтанд одоогоор зонхицж байгаа «бүртгэх арга»-аас жинхэнэ хяналтыг чанартай хийж үр дүнг эдийн засгийн болон бусад аргаар тодорхой тооцдог ажилд шилжих;

Аймаг, хотын төв зэрэг хүн ам төвлөрсөн суурин газарт дэвсгэр шүтгийн болон албан ажлын харьяаллаар үйлчлэх амбулатори-поликлиникийн ба хэсгийн системийн зохион байгуулалт хүрэлцээг төгс шийддэх;

Лабораторийн шинжилгээ, реабилитацийн тусламж, эмийн хүрэлцээг эрс сайжруулж, түүнд экспресс (тургэвчилсэн) ба электрон тооцооны зарим дэвшилт арга нэвтрүүлэх;

Эмч нар хөдөлмөрчдийн сэтгэл зүйн бэлтгэлийг хангах зэрэг олон асуудлуудыг дэс дараатай шийддэврлэх шаардлагатай юм.

Товчоор хэлэхэд, энэ таван жилд хяналтад хамрагдагсдын тоог төдий л (олноор) нэмэгдүүлэхгүйтээр одоогийн тавьж байгаа хяналтын чанарыг эрс сайжруулж үр дүнг тооцох, дараагийн шатны зо-

рилтыг хэрэгжүүлэх материаллаг бааз, боловсон хүчний бэлтгэлийг хангахад гол зорилтыг чиглүүлмээр санагдана.

Эцэст нь «диспансерчлал», «бүх нийтээр диспансерчлах»-д хэрэглэж байгаа нэр томъёоны талаар дурддяа. (Хүснэгт 3-аас) үзнэ үү

Үүн дотроос бид ганц нэгээр буюу өрх гэрээр диспансерчлах аргуудыг хэрэглэж диспансерийн хяналтыг өргөтгэж хүн амыг шатлан диспансерчлах зорилтыг дэвшүүлж байгаа юм.

МАХН-ын XIX их хурлын илтгэлд «кийт хүн амыг зохих үе шаттайгаар диспансерчлаад шилжих» 1986—1990 онд эдийн засаг-нийгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд «хүн амыг диспансерийн үйлчилгээнд хамрах хүрээг өргөтгэн, эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүчтэй болгох»-оор заасан нь тус улсын эрүүлийг хамгаалахын орчин үеийн чухал зорилтыг тодорхойлж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Проблемы диспансеризации населения. Под редакцией А.Ф. Серенко-А. Ценова, М. 1982. 32—33, 48—49.
2. Г.А. Новогородцев, Г.З. Демченкова, М.Л. Полонский. Диспансеризация населения в СССР. М. 1979, 1985.
3. ЗХУКН-ын XXVII их хурлын материал, М. 1986.
4. МАХН-ыч XIX их хурлын материал. УБ. 1986.

Редакцийд ирсэн 1986.11.25.

ЭМЧИЙН СЭТГЭЛГЭЭ, ОРЧИН ҮЕ

Орчин үеийн анагаах ухааны практикт шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн гайхамшигт ололт нэвтэрч, эмч нарын мэргэжил үлам бүр нарийсч байгаагаас мэргэжлийн эмч нарын дотор зарим нэгэн зааг гарч байна. Нөгөө талаар зөвлөх эмч нарын нөлөө ихсэж түүнд найдах, тэдний амыг харах явдал ч бий болж байна. Үүний улмаас өөрийн туршилага, мэргэжлийн зөн билэгт үл итгэх явдал ч зарим эмч нарын дотор байгаа билээ. Энэ бүхэн нь эмч нар өвчтөнийхөө өвчнийг оношлох, эмчлэх тактик ээрэгтээ мэргэшлийн хувьд түргэн өсөх, бие дааж ажиллахад нөлөөлж буй нь илэрхий.

Ер нь өнөө үед эмчлэх ажил нь орчин үеийн анагаах ухааны онол, практикийн нарийн асуудлыг хэр зэргэг сонирхожж эсихэнэ зүрх сэтгэлэсээ хэрхэн ажиллах байгаагаас хамаарах тул эмчийн зохицтой бодогл чанар тун чухал юм. Иймийн учир сэтгүүлийн редакци энэ сэдвээр хэлэлцүүлэг нээж байна. Энэ хэлэлцүүлэгт эрдэмтэн, багши, профессор, эмч нарыг өргөн оролцохыг урьж байна.

Хүний бие махбод бол нэгдмэл систем юм. Энэ систем элемент буюу салбар тухайлбал зүрх судасны, тулгуур эрхтний, мэдрэлийн гэх мэт дэд системд хуваагдана. Шинжлэх ухааны суурь судалгааны онолын хувьд энэ олон арван салбар систем, элементийг тусгай нарийн мэргэжлийн ажилбарт мэргэжсэн мэргэжилтэн, өндөр мэдрэмж бүхий аппарат багаж, лабораторийн тусламжгүйгээр судалж, дүгнэх аргагүй юм. Энэ нь маргаангүй, орчин үеийн анагаах ухааны гол шугам мөн.

Анагаах ухаан клиник, эрүүл ахуй, туршилтын гурван чиглэлээр 172 нарийн мэргэжлээр хөгжих байна. Зөвхөн практикийн эмч нар 50· гаруй, зарим улсад 74 мэргэжлээр хүн амд эмнэлгийн тусламж үзүүлж, 10 мянга шахам өвчний онош хамшинжийг судалж байна.

Хүн, биологийн хувьд систем төдийгүй, нийгмийн талаас сэтгэл зүй, хөдөлмөр, ахуй, зан заншил зэрэг олон үзэгдэл юмсын уялдаа холбоо бүхий нийгэм-биологийн нэгдмэл цогц болдог. Энэ утгаар авч үзвэл практикийн эмч нарын үйл ажиллагаанд дифференциацчалыг хэтэрхий болгох нь эмчийн сэтгэлгээг боогдуулж болох талтай юм. Ийм учраас анагаах ухааны практикт ерөнхий буюу түгээмэл мэргэжлийн эмч бэлтгэх зайлшгүй хэрэгцээ гарч ирсэн юм. Дунджаар эмнэлгийн тусламж авахаар анх ирсэн нийт хүн амын 40—50%-ийг зөвхөн ерөнхий мэргэжлийн эмч нарын хүрээнд шийдэх боломжтой байна.

Эмчийн клиник сэтгэлгээ нэн чухал байгаагийн учир юунд байна вэ. Энэ нь:

1. Эмчийн уран гар, хүрц оюун ухаанд итгэх итгэл бол анагаах ухаанд онцгой байр эзэлж ирсэн, эзлэх ч болно. Орчин үед эмчид итгэх итгэл сүлрах хандлага ажиглагдаж байна. Үүнийг ерөнхий мэргэжлийн эмч цөөрсөн (итгэл авч чадах гол мэргэжил), эмнэлзүйн хурц илрэлтэй тохиолддог өвчин ховордсон, эмч өвчтөний хооронд зөвлөх эмч, техник орж «хөндийрүүлсэн» гурван гол шалтгаанаар тайлбарлаж болно. Зөвлөх эмчийн амыг харж, лаборатори багаж техникийн шинжилгээний үзүүлэлтийг хэт шохоорхсоноос болж эмч нарын клиникин чөлөөт сэтгэлгээ боогдож байгаа тал байгаа нь үнэн. Энэ бол анагаах ухааны механизмын нөлөөлөл болох зөвлөх эмч нарыг төрөл төрлөөр олшуулсан, доод байгууллагын ажлыг дээд газраас

зааж зааварласан, биеэ даасан бүтээлч чадварыг бөхцүүлсан зэрэг удирдлагын хуучин арга хэлбэртэй холбоож үзмээр санагдана.

2. Эмч нар нарийн мэргэжилд баригдаж өвчтөнийг өрөөсгөл судлах дутагдал байна. Үүнээс болж ёс суртахууны, мэргэжлийн алдаа гардаг. Орчин үед өргөсөх хандлагатай клиникийн анагаах ухааны ерөнхий асуудлыг (мэдрэл сульдах өвчний илрэл, диэнцефалин хам шинж, коллагены өвчинүүд, харшлын илрэл, бага зэргийн (субфебрил) халуунтай өвчний шинжлэх, оношлох арга, антибиотик, дайврын гаралтай бэлдмэлээр эмчлэх, эмийн гаж үйлчилгээг г. м) судалж, танин мэдэхэд ерөнхий мэргэжлийн эмч шийдвэрлэх үүрэгтэй болж байна. Нарийн мэргэжлийн эмч нарын оношлогооны тойм мэдлэг дутах, мэргэжилдээ хэт явцуурснаас болж сурьеэ өвчний ерөнхий хордлого, хурц халдварт өвчний эхлэл, хэвлэйн хөндийн хурц өвчин, эмнэл зүйн ерөнхий шинж тэмдэг зэрэгт ихээхэн «барыц алдаж» байгаа жишээ баримт багагүй гарч байна.

3. Нарийн мэргэжлийн эмч нар бие биедээ «зөвлөх» болж, харин тэд нарын санал нийлсэн буюу маргаантай асуудлыг холбох ерөнхий мэргэжлийн эмчийн өргөн сэтгэлгээ чамлагдаа байна.

4. Аль ч мэргэжилд өвчтөнийг судлах өвөрмөц тусгай арга байдгийн зэрэгцээгээр асуух, ерөнхий узлэг хийх, барих, тогших, чагнах нийтлэг арга (бодит узлэг) олон зуун жилийн уламжлалтай орхиж болохгүй арга мөн. Энэ бол эмч өвчтөнийг ёс суртахууны хувьд холбож өгдөг нандин холбоос юм. Эмч нар өвчтөнөөс асууж судлах, тав тухтай ярилцахын ач холбогдлыг бууруулж ёс төдий ханддаг сэтгэл зовоосон буруу арга барил газар авсаар байна. Зарим нарийн мэргэжлийн эмч нар өвчтөнг үзэж судлах уламжлалт сонгомол аргыг хэрэглэх нь багасч байгааг олон баримтаар нотолж болно.

Эмгэг анатомын товчооны 1986 оны тайлангаас үзэхэд үндсэн оношийн зөрөөний 38,9% объектив, 61,1% нь субъектив шалтгаантай. Субъектив шалтгааны 35,3% нь бодит узлэг хангалтгүй хийсэн, 36,3% нь эмчийн клиник сэтгэлгээ дутсан, 19,3% нь туслах шинжилгээг дутуу буюу хэтрүүлэн үнэлснээс болжээ.

Профессор Р. Хегглин (1965) дотрын өвчний оношлогоонд асуух арга ойролцоогоор 50%, бодит узлэг 30%, лабораторийн шинжилгээ 20%-ийн ач холбогдолтой гэж үздэг байжээ. Анагаах ухааны хүрээлэнд хийсэн зарим судалгаагаар амбулаторийн дотрын чиглэлийн эмч нарын тэн хагас нь бодит узлэгийг дутуу хийж байна. Бидний ажиллалтаар дэлүү зүүн хавирганы нуман дорроос үл ялиг тэмтрэгдэж байгааг бодит узлэгээр тодорхойлж чадаагүйгээс болж элэгний цирроз өвчтэй хүнийг «ходоодны шарх, үрэвсэл» гэдэг оношийн дор 10 шахам шинжилгээ, эмчилгээ хийж сар гаруй болсон тохиолдол нэг биш удаа гарсан юм.

5. Нарийн мэргэжил эзэмшиэнээр унших, боловсруулах, сэтгэх хэмжээ хязгаарлагдахгүй. Мэргэжилдээ бүрэн эзэн болоогүй эмч ажилдаа хайхрамжгүй, хүнтэй элэгсэг биш харьцдаг, унших судлах дургүй болдог. Хэрэв сонирхож буй мэдлэгийн салбарт юм бухэн эцэстээ хүртэл төгс хөгжчихсөн мэт санагдвал тэр хүний мэдлэг дутагдалтай байгааг харуулдаг ерөнхий зарчим байдгийг санаад илүү дэхгүй юм. Ой руу хичнээн гүн орох тутам төчнөөн өтгөн шигүү болдог гэсэн орос ардын цэцэн үг бий.

Эмчийн ерөнхий мэргэжлийн бат суурьгүй «нарийн» мэргэжлийн эмч нарын клиникийн сэтгэлгээ хязгаарлагдмал байдаг нь зүйн хэрэг юм.

6. Эмчилгээний тухай эмчийн бодол санаанд өрөөсгөл хандлага тод илэрч байна. Энэ бол эмийг эмчилгээний гол арга болгон олноор (эмийн полипрагмази) хэрэглэх явдал юм. Полипрагмази бол эмчийн сэтгэлгээ хөгжөөгүйн улмаас шинж тэмдгийн эмчилгээний арга хэрэг-

лэж байгаагий тод илрэл юм. Зарим эмч нар өвчнийг танин мэдэх, эмчлэн эдгэрүүлэхэд бие махбодын гадаад орчин, дотоод тогтолцооны диалектик холбоог дутуу үнэлж байна. **Жишээлбэл:** эмчилгээний гол хэлбэр болсон хөдөлмөр, ахуй, хоолны дэглэмийн зөвлөгөөг срөнхийлөх загварчлан тогтоох, дутуу үнэлэх өрөөсгөл хандлага ч байна. Чихрийн шижин өвчин, ходоод, элэг цөсний архаг үрэвсэл зэрэг олон өвчнийг зөвхөн хоолны дэглэм, амьдрал ахуйн зөв хэмнэлээр эмчилж болдог шүү дээ.

Ерөнхий мэргэжлийн эмч бэлтгэх явдал ерөнхий талыг эхлэн тодруулж байж тусгай руу хандах хөгжил, танин мэдэхүйн диалектикийн үүднээс ч тодорхой юм. Манай оронд ерөнхий мэргэжлийн эмч бэлтгэх, сургах, мэргэжүүлэхэд учир дутагдалтай байна. Ерөнхий мэргэжлийн эмч, нарийн мэргэжлийн эмч нарын зохицтой зөв харьцаа тогтоох хэрэгтэй юм. Ерөнхий мэргэжлийн эмч, хүн амд хамгийн ойрхон, өвчтөнийг судлах аргыг бие хүн, сэтгэл, гадаад орчинтой холбон судлах чадвартай эмч-нийгийн зүтгэлтэн болно.

Манай эмнэлэг үйлчилгээний практикт хэсгийн ба сумын эмч нар-ерөнхий мэргэжлийн эмч бэлтгэх суурь мөн. Ерөнхий мэргэжлийн эмч үйлчилгээний дэвсгэр нутгийн хүн амын өвчин эмгэгийн талаар нарийн мэргэжлийн эмч нарт зөвлөх, зөвлөгөө өгөх чадвартай, тэднийг төвлөрүүлэн мэргэжлийн тусламжийг зохион байгуулах үүрэгтэй байх ёстой. Ерөнхий ба мэргэжлийн эмч нарыг бэлтгэх, ашиглах асуудлыг ЗХУ болон бусад социалист оронд ихээхэн анхаарч байна.

Куба улсад эмчийг өрхийн мэргэжлийн хэлбэрээр бэлтгэж байна.

Манай улсын поликлиникийн тусламжийн хүрээнд ерөнхий ба нарийн мэргэжлийн эмч нарын харьцаа 1 : 2-оос хэтрэхгүйгээр байх зарчмыг баримтлах нь зөв болов уу. Учир нь дэвсгэр нутгийн хүн ам-ерөнхий мэргэжлийн эмч-нарийн мэргэжлийн эмч гэсэн бие биендээ нөлөө бүхий цагариг холбоон дээр больникоос гадуур үзүүлэх эмнэлгийн тусламжид тулгуурлана. Ийм нөхцөлд ерөнхий мэргэжлийн эмч нарыг нарийн мэргэжлийн тусламжийг удирдан зохицуулах «удирдаач» болох төвшинд бэлтгэвэл зохио.

Ерөнхий мэргэжлийн эмч бэлтгэх асуудалд зохион байгуулалт, сэтгэл зүйн зарим бэрхшээл байна. Поликлиникоор үзүүлэх эмнэлгийн тусламжийн зохион байгуулалт өрөөсгөл байна. Нийслэл хотод гэхэд хэсгийн эмнэлэг бүхий дэвсгэр нутгийн поликлиник зохион байгуулахын оронд үйлчилгээний хүн амаас холдсон улс, хот, районы «зөвлөх» поликлиник нэмэгдэх хандлага байна. Энэ нь нарийн мэргэжлийн «зөвлөх» эмч нарыг олшруулна гэсэн уг. Ийм поликлиникийн эмч нарт үзүүлэх, шинжилгээ хийлгэх хүмүүс хэсгийн эмчээс бичиг баримт бүрдүүлэхээс эхлээд элдэв янзын үл ялих саад, дамжлага олширчээ. Ажлын арга барилд «...яльтай яльгүй дүрэм, горим, бичиг цаастай хэт зууралдах явдлаас болж ажиллах нөхцөл байдал яаж хүндэрснийг...» ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев 1985 оны 4 сарын бүгд хуралд онцлон тэмдэглэсэн билээ.

Поликлиникийн материал техникийн бааз үлэмж хоцрогдож байгаагаас гадна поликлиникт өвчтэй хүнийг гардан эмчилж, эрүүл хүний эрүүл мэндийг хамгаалж, нарийн мэргэжлийн эмч нартай холбож эцсийн үр дүнг хариуцдаг оношлох, эмчлэх, сэргийлэх өргөн сэтгэлгээ бүхий эмч нар үгүйлэгдэж, хөдөлмөрчдийг чирэгдүүлэх, эмч нарыг өвчтэй хүний төлөө хариуцлагыг сулруулах нэг хүчин зүйл болж байгаа биш.

Эмч, эмнэлгийн удирдах ажилтан нарын ерөнхий мэргэжлийн тухай сэтгэлгээ «хоцрогдож» энэ нь хүн ам, нийгэмд буруу нөлөө үзүүлж байна уу?

Эмчийн клиникийн сэтгэлгээнд саад болж байгаа зохион байгуулалтын бусад асуудлыг ч хөндөж ярих нь зүйтэй. Дээд газраас эмнэ-

лэг, эмчийн ажлыг шалгахдаа цаас бичгээр дүгнэдгээс болж эмч нар узлэгийн өрөөндөө мэргэжлийн ном сэтгүүл ашиглахын оронд элдэв янзын судалгаа, самбар үзүүлэн, цаас бичгээр шалгалтын нүл хуурах гэсэн арга хэлбэр элбэгших шинжтэй байна. Таван жил ба жилийн аттестатчиллыг онолын төвшинд хийж улс төр, гадаад хэлний мэдлэг мэд дагавар хүчин зүйлийг гол болгосноос эмч нарын мэргэжлийн практик ёсөлт, клиникийн сэтгэлгээг хөгжүүлэхийн төлөө шуцалтгүй хөдөлмөрлөх идэвх суларч байгаад дүгнэлт хийвэл зохино. Аттестатчиллыг эдийн засгийн урамшилтай холбох цаг болжээ. Эмчийн ажлыг ор хоногт, узлэгийн төлөвлөгөөний тооны үзүүлэлтээр биш, үйлчлэх хүрээний хүн амыг жилд 1—2 удаа идэвхтэй үзэж өвчнийг эрт илрүүлэн төгс эмчилж, диспансерчилж байгаа эцсийн үр дүн-чанаараар дүгнэх хэрэгтэй байна.

Нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэх, мэргэжүүлэхэд ялгавартай хандахгүй байна. Цэвэр шинжлэх ухааны чиглэлтэй боловсон хучнийг дээд сургуульд байхаас эхлэн шинжлэх ухааны чимхлүүр салбарт орчин үеийн техник лабораторт сургаж бэлтгэх нь зөв. Харин өвчтэй хүнтэй ажиллах практикийн эмч нарыг оношлох, эмчлэх арга ухаанд гаршуулж, түгээмэл мэргэжил дадлагажуулж «эмч» болсон нөхцөлд нарийн мэргэжлээр мэргэжүүлж нь зүйтэй санагдана.

Ерөнхий мэргэжлийн эмч, нар бол дотрын өргөн мэлдэгтэй байхаас гадна анагаах ухааны сүлжээнээс өрөнхий арга, архаг ба хурц халдварт өвчийн, хэвлэлийн хүчний, мэс засал, эх барихын ба хүүхдийн яаралтай тусламж, халиваар, сүлжээ, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын түгээмэл мэргэжлийн эзэнтүүлэхийн байх ёстой. Ийм эмчийг оюутны сургалтаас эхлэн сонирхжүүлж дэс дараатай, системтэй бэлтгэх хэрэгтэй юм.

Доцент Ш. Жигжидсүрэн,
Анагаах ухааны дэд эрдэмтэн Ц. Мухар

Б. Ганбаатар (*Эрүүл ахуй халдварт, Нян, судлалын улсын институт*)

УЛААН БУРХАН ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ СТРАТЕГИ, ТАКТИК

Сэргийлэх тарилгын өргөжүүлсэн программын хүрээнд 2000 он гэхэд дэлхий дахинд устгаж болох өвчний бүлэгт улаанбурхан өвчнийг оруулж байгаа бөгөөд социалист орнууд энэ зорилтыг эхлэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна (1, 3, 29).

Манай орны эрүүлийг хамгаалахын материаллаг бааз, боловсон хүчиний потенциал нь улаанбурхан өвчинтэй тэмцэх ажлын талаар гарч буй шинжлэх ухаан, техникийн ололтыг өөрийн орны нөхцөлд тохируулан алс хэтийн чиглэсэн тодорхой зорилготой эрчимжүүлсний үндсэнд энэ зорилтыг хангах боломж олгож байна. Тус орны онцлог нь уудам дэлгэр нутагт харьцаангуй цээн хүн оршин суудгаас хүн амын нягтрал бага, эмнэлгийн үйлчилгээний радиус газар зүй, эдийн засгийн буцууддэд ялгаатай энэхүү хүн ам, эмнэлгийн байгууллагын байршилын онцлогийг харгалзан тус орны нөхцөлд улаанбурхан өвчинтэй тэмцэх стратеги тактикийг 3 учелтэйгээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. (22) Үнд:

1986—1990 он буюу нэгдүгээр үед нь улаанбурхны вакцинжуулалтын үр дүнг чанархуулж, вакцинд хамрагдах хувийг 90—97%-д, вакцины дархлалын түвшинг 80—90%-д хүргэх зэрэгээр өвчин үүсгэгч (Морбилии вирус)-ийн байгаль дахь эргэлтийг багасган эпидемийн дэгдэлтээс сэргийлэх нөхцөлийг хангах.

1991—1995 он буюу хоёрдугаар үед нь улаанбурхны вакцины дархлалын түвшинг 90—95%-д, вакцинд хамруулах хувийг 95—98%-д хүргэж, аллаг цоог өвчлөлөөс сэргийлэх практик боломжийг бүрдүүлэх.

1996—2000 он буюу гуравдугаар үед нь нэг хоёрдугаар шатны зорилтыг бүрэн хэрэгжүүлсний үндсэн дээр тус орны нутаг дэвсгэрийн хэмжээнд улаанбурхны вирусийн зэрлэг омгийн байгаль дахь эргэлтийг хязгаарлан улаанбурхан өвчиний ховор бүртгэгдэх өвчиний нозологийн хэлбэрт оруулах бодит боломжийг хангаж болох юм.

Дэвшүүлж байгаа зорилтын үндэслэл

Улаанбурхны эмнэл зүй, халдварт судлалын зарим нэг нийтлэг зүй тогтол нь дэлхийн ихэнх оронд адил төстэй боловч хэд хэдэн улс оронд онцлог байдал ажиглагдаж байна (7, 8, 28). Энэ нь өвөрмөц сэргийлэлтийн аргаар өвчлийн зүй тогтолтыг өөрчилж болохыг харуулж байгаа юм (3, 6, 23).

Эсрэгтөрөгч (антител)-ийн тогтвортой байдал нь ийлдэс судлалын хувьд вирус нь хувилбаргүй болохыг харуулж байгаа

бөгөөд халдвартын голомт зөвхөн өвчтөн байдаг. Эрүүл хүн, амьтан вирусийг тээврэлэгч болох нь тогтоогдоогүй, тийм учраас өвчин үүсгэгч байгальд голомтлон хадгалагдахгүй гэж үздэг. Үүсгэгчийн эдгэр онцлог шинж байдал нь вакцинжуулалтын аргаар улаанбурхан өвчиний асуудлыг шийдвэрлэж болно гэдэг дүгнэлтэд хүргэж байгаа юм (3, 23). Улаанбурхан өвчинеэр өвчилсний дараа дархлал насан туршид хадгалагдаж, энэ дархлал жирэмсэн эхээс урагт дамжин, төрснөөс хойш 6-гаас 12 сар хүртэл идэвхтэй үйлчилнэ. Улаанбурхны дархлалыг «өвчилсний дараах», «эхээс урагт дамжсан», «вакцины дараах» гэж ангилдаг бөгөөд өвчлөлийн дараах дархлалын эзлэх жинг бууруулан вакцины дархлалыг эрс нэмэгдүүлж, эхээс урагт дамжих дархлалыг тэр түвшинд нь идэвхтэй тогтвортой байлгах нь дэвшиүүлж буй зорилтын гол үндэслэл юм (5, 7, 23, 28).

Бодит байдалд хийсэн дун шинжилгээ

Манай орон 1973 оноос улаанбурхны эсрэг вакциныг эхлээд 10 сартай, дараа нь 1980 оноос 13 сартайгаас 24 сартай хүүхэд тарьж, 1976 оноос тариулах наслын бүх хүүхдийг заавал вакцинжуулах журам тогтоон, 1975—76 онд «Шварц» омгийн вакцины нэг удаа, бусад жилүүдэд нь ЗХУ-ын Ленинград (Л-16) омгийн вакцини хэрэглэж байна. Сүүлийн 12 жилийн (1973—1985) судалгаагаар жилд дунджаар 60846 хүүхэд вакцинжуулалтанд хамрагдаж байна. Улаанбурхны вакциныг аймаг, хотын хэмжээнд АЦХС Станцын шууд удирдлагаар хүүхдийн хэсгийн эмнэлгүүд, сум, сум дундын эмнэлгийн хүрээнд, сумын эмнэлгийн эмч ажилчид, бригадын үйлчилгээнд бригадын бага эмч нар гардан хариуцаж байна.

1980-ад оноос аймаг, хотын төвд сар бүр «Рутин» хэлбэрээр сум, сум дундын эмнэлгийн хүрээнд жилд 2 удаа зохион байгуулалттайгаар вакцинжуулах арга барилг тогтох байна. Төлөөлөгч томилон тарилга зохион байгуулах аргыг энэ хугацаанд олонтоо хэрэглэж, төлөөлөгч хотоос аймагт, аймгаас сумдад 3—7 хоногийн хугацаатай төлөвлөгөөт тарилга зохион байгуулах байв. Вакциин эхэн тарих нас хоёр удаа (1973, 1986) социалист орнуудын практик туршилагад тулгуурлан өөрчлөгдэж, эпидеми гарах үед нас бууруулах, нас ахиулж тарих зохион байгуулалтыг халдварт судлалын заалтаар хийж байна.

Улаанбурхны вакциныг жилд 1—2 удаа (хүйтний улиралд) ЗХУ-аас импортоор авч, эмийн төв баазад хадгалан,

аймгуудад 1980 он хүртэл жирийн байдлаар, 1980 оноос эхэн тээвэрлэх зориулалтын «мөстэй» саванд жилийн хэрэгцээгээр хүргүүлж аймаг, хотын АЦХС Станицы, хэсгийн эмнэлгүүдэд вакциныг хөргөгчинд, тогтмол цахилгаангүй сумын эмнэлэгт зоринд хадгалж байна.

Тарилгын хяналтыг ЭАХСУ-ын Институт улсын хэмжээнд аймаг, хотын үйлчилгээний хүрээнд АЦХС-ын Станицын тарилгын болон халдварт судлалын мэргэжилтнүүд төлөвлөгөөний гүйцэтгэл, тарилганд хамрагдах хувь, тарилга хийсэн тухай картыг хэрхэн хөтөлсөн байдлаар гүйцэтгэж байна.

Халдварт өвчиний тайлангийн материалд тулгуурлан өвчлөлийг 20 жилийн (1965—1985) байдлаар вакциин хийлгэхийн өмнөх үе (1965—1973), вакцинжуулалтын дараах (1973—1985) үе 1-сэн хоёр үзүүлэлтээр харьцуулж үзэхэд өвчлөл 2—3 дахин буурч эпидеми лэгэндийн интервал 1—2 жилээс 3—4 жил болор Вакциин хийхийн өмнөх үед хамгийн бага өвчлөлтэй байсан 1970 онд 10000 хүнд 61,0 өвчиний тохиолдол бүртгэгдэж, вакцинжуулалтын жилүүд тухайлбал 1975 онд өвчлөл бүртгэгдээгүй. Өвчлөл, вакцинжуулалтын материалд тулгуурлан хүн амын дархалын түвшингийн хэмжээг харьцуулж үзэвл 1965 оноос хойш 20 жилийн хугацаанд нийт хүн амын 57,3% нь улаанбурхны эсрэг дархалтай үүнээс 82,4% нь вакцины, 17,5% нь өвчлөлийн дараах дархлал тогтоох боломж бүрдсэн гэж үзэж болох юм.

Бүртгэгдсэн нийт өвчлөлийн 54,2%-ийг эмнэлэгт, 45,8%-ийг гэрээр эмчилжээ. 1985 онд ДЭХБ-тай хамtran түүвэр аргаар 4 аймаг (Ховд, Хөвсгөл, Дундговь, Дорноговь) нэг хотод (Улаанбаатар) сэргийлэх тарилганд хамрагдах байдлыг судалж, аймгуудад 67%, хотод 88% байгааг, эмнэлгийн заалтаар түр чөлөөлөлт 10—15%, тодорхойгүй шалтгаанлар 15—20% нь сэргийлэх тарилгаас хоцорч байгааг судалж тогтоо.

Манай орны хэмжээнд улаанбурхны өвчиний талаар хийсэн судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж үзвэл:

1) Ретроспективный анализ судалгаа.

2) Дархлал тогтын судалгаа тээсэн хоёр хэсэгт хувааж үзэх боломжтой юм.

Хийсэн судалгаа шинжилгээний ажлууд ихэвчлэн онол-практикийн бага хурлаар хэлцэгдсэн илтгэл байгаа бөгөөд «тезис»-ийн хэлбэрээр нийтлэгдэжээ. Нийт 11 илтгэл хэвлэгдсэнэй 7 илтгэл нь (18—19) халдварт өвчиний тайлангийн материалд тулгуурлан хийсэн судалгаа, нэг илтгэл нь (20) өвчтөний түүх ашиглаж хийсэн клиник-эпидемиологийн судалгаа, гурван илтгэл вакцинжуулалтын дараах болон идэвхгүй дархалын түвшин тодорхойлох судалгааны ажил байна. Мөн хүн амын дархалын түвшингийн талаар хийсэн 3 мэдээлэл англи хэл дээр, нэг өгүүлэл (12) монгол хэлээр хэвлэгдэн гарчээ. Эдгэр судалгааны материалуудад дүн шинжилгээ хийж үзэхэд болон судлаачид өвчлөлийг 5—20 жилийн байдлаар судалж, вак-

цин хийж эхэлсэн 1973 оноос өвчлөл, вакцинжуулалтын өмнөх үеийнхтэй харьцуулхад 17 дахин (19) буурч, үхлийн хувь сүүлийн 10 жилд (1970—80) 1,2—1,6% болж (13), хүндэрл 2 дахин (20) багассаныг эпид судалгааны аргаар харуулсанас гадна вакцинжуулалтын жилүүдэд (1973—1985) улаанбурхны өвчлөл 2—4 жилийн интервалтай (13, 14) бүртгэгдэж, өвчлөл сургуулийн наслын хуухдүүдэд олон тохиолдох болсон болон вакциин хийлгээд өвчилж буй гол нэг шалтгааныг вакцинд муу хамрагдсанас (88% зарим аймагт, 67,2% сумдад) (15, 18) мөн вакциныг тээвэрлэх, хадгалах, техникик ажиллагааны буруугаас (18, 19) гэж үзсэн байна.

Вакциин хийлгээд өвчилсэн тохиолдлыг Ховд аймгийн өвчлөлд хийсэн судалгаагаар 28,5% (18) улсын хэмжээнд хийсэн судалгаагаар 40% (19) гэж үзжээ. Хүн амын дундах улаанбурхны эсрэг дархалын түвшинг 1982 оноос эхлэн (17) манай оронд БНАГУ-ын мэргэжилтнүүдэй хамtran хийж, судалгаанд хамрагдсан хүмүүсийн 80,6%-д (18) улаанбурхны эсрэг бие 1:8 буюу түүнээс их, 1—3 наслын хуухдийн дунд дархалын түвшин хангатгүй байна гэсэн урьдчилсан дүгнэлт хийсэн байна. Улаанбурхны эсрэг вакциин хийлгэх нас хүрээгүй (13 сар) хуухдэд, эхийн эсрэг биеийн таныц тодорхойлох ийлдэс судалын шинжилгээний аргыг 1984 онд (12) 1—15 сартай 300 эх, хуухдэд хийжээ. Судалгаанд хамрагдсан эхчүүдийн 93,3% нь улаанбурхны эсрэг биеийн геометрийн таныц 1:10, хуухдүүдийн 48,6%-д нь 1:5 байгааг мэдээлсэн байна.

ДЭХБ 1951 оноос эхлэн улаанбурхан өвчиний хөдлөл зүйл судалж, одоо 136 орон энэ судалгаанд оролцон өвчлөл, тархалтын байдлыг нэгтгэн хянаж байгаа бөгөөд жил бур дунджаар 60 сая өвчлөл бүртгэгдэж нас барагт 3 саяд хүрч байна. (8, 7)

1986 оноос эхлэн урьдчилан сэргийлэх тарилгын хурдавчилсан программаар вакцинд хамрагдах хувийг ойрын жилүүдэд (1986—1990) эрс нэмэгдүүлэх, вакцинжуулалтын өмнөх үеийн (1939—1968) өвчлөлд ретроспективный анализ хийх, вакциныг хадгалах, тээвэрлэх, хийх техникик ажиллагаанд хөргөлтийн найдвартай систем нэвтрүүлэхийг зөвлөж байна.

Дэлхийн улс орнуудад улаанбурхны өвчлөл хариулсан адилгүй байна. Европын 25 оронд хийгдсэн нэгдсэн судалгаагаар дэлхийн 2 дугаар дайны дараа өвчлөл нэмэгдэж 1, 2, 3, 4 дүгээр сард их, 8, 9, 10 дугаар сард бага байхад Африкийн 37 оронд 5, 6 дугаар сард хамгийн их өвчлэлтэй, 1 дүгээр сард бага өвчлөл бүртгэгдэж 6 сартайгаас 1 хүртэлх наслын хуухдийн өвчлөл өндөр байна.

Азиин 25 орны судалгаагаар өвөл хавар өвчлөл их, зүн намар бага байна. Улаанбурхан өвчин бүртгэгдээгүй тийм ёлс орон дэлхийн дахинд байхгүй байна. Харин сэргийлэх тарилгыг дэлхийн ихэнх орнууд түүний дотор социалист бүх ор-

нүүд төлөвлөгөөтэй хийж байна (3, 7, 8, 25, 29).

Вакцинжуулалтанд нөлөөлж байгаа зарим хүчин зүйл:

Өвөрмөц сэргийлэлтийн аргаар (улаанбурхны эсрэг) хүн амын өвчлөмтгий бүлгийн дархалын түвшинг нэмэгдүүлэн, өвчлөлийг бууруулж, өвчин үүсгэгчийн байгаль дахь эргэлтийг өөрчлөн, эпидемийн голомтыг таслахад вакцинжуулалтын зорилго оршиж байна. Аль ч улс оронд вакции тариулсан хүүхдийн өвчлэл бүртгэгдэж байгаа буюу энэ шэлтгааныг 1970-аад оноос эхлэн судалж (4—7, 10, 21, 22, 27, 29) вакциин-өвчлөлийн дотоод холбоог хэд хэдэн хүчин зүйтэй холбон тайлбарлаж байна. Үүнд:

1. Улаанбурхны амьд вакциин нөлөөгөөр бий болдог эсрэг биений үүсэлтийг иммуноглобулин саатуулж чанартайг 1971 онд Баррата, Арбертер, Кригманн нар анх мэдээлж, энэ чиглэлээр үргэлжлүүлж хийсэн судалгааны ажиглалтууд, мэдээлэл чин болохыг баталж өгөв (1, 4). Улаанбурхны вакцинтай иммуноглобулины хамт хэрэглэхгүй байх, эсвэл бие биендээ харшилахгүй уед нь хэрэглэхийг судлаачид зөвлөж байгаа бөгөөд сэргийлэх тарилгын календарь 3 сараас доочгүй хугацааг тохиromжтой гэх буюу зарим орнууд (БНСЧСУ, БНАГУ, АНУ, Япон) өвөрмөц биш иммуноглобулин хэрэглэх заалтыг багасгах тактик баримталж байна. Манай оронд өвөрмөц биш гаммаглобулиныг өврүүний А гепатитаас сэргийлэх зорилгоор З хүртэлх насны хүүхдэд 1970-аад оноос эхлэн өргөн хэрэглэж байгаа бөгөөд улаанбурхны вакции хийлгээ 13 сартайгаас 3 хүртэлх насны хүүхдэд насны хувьд давхардаж вакции, гаммаглобулины хооронд баримтлах хугацаа 1—2 сар байсныг 1986 оноос 3—6 сар болгох чиглэл баримталж байна. Манай улсын хэмжээнд улаанбурхны вакциин эсрэг бие үүсэхэд иммуноглобулины сөрөг нөлөөллийн талаар эпидемиологи, иммунологийн судалгаа хийгээгүй байна.

2. 12 сар хүрээгүй хүүхдэд улаанбурхны вакциин хийхэд вакциин хийлгэсэн хүүхдийн 50 орчим хувь нь дархлал тогтоогүй юм уу эсвэл тогтсон дархлал удаан хадгалагдах чадваргүй байгаа тухай анх Рейнолд, Линнеттан (1972), Штарке, Хайдюк (1973) нар мэдээлсэн. Нэг нас хүрээгүй байхдаа вакциин хийлгэсэн хүүхдийн 55 орчим хувь өвшилж байгааг Вилкинс, Кирриг, Шлудерберг (1974) нар судалжээ. Эхээс урагт дамжсан улаанбурхны дархалын таныц 6 сар хүртэлээ өндөр түвшинд байж 12 сар хүрэхэд аажимдаа арилж алга болно (элеминаций) гэсэн судалгааны энэ дүгнэлтэнд үндэслэн улаанбурхны вакции эхлэн тарих тохиromжтой насыг сонгон авч байна.

Манай орон 6 жилийн хугацаанд (1973—1980) 10 сартай 491269 хүүхдийг вакцинжуулсан бөгөөд 13 сартайгаас эхлэн хийх болсон 1980 оноос хойш халдварт судлалын заалтаар нас бууруулж тарих зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч, тухайн уед нь нас

бууруулж тарьсан хүүхдийн тооогоог нарийвчлан судлаагүй учир дүгнэлт гаргах боломжгүй байна.

ЗХУ, БНАГУ, БНСЧСУ, БНУАУ, АНУ зэрэг ихэнх оронд 1970-аад оны дунд үеэс эхлэн нэг нас хүрээгүй байхдаа вакции хийлгэсэн хүүхдийг 2 нас хүрэхэд нь давтан вакцинжуулах арга хэмжээ авч вакции хийлгэх насанд хүрээгүй хүүхдийн өвчлөлийн шалтгаан судлалд их анхаарал тавьж байна.

3. Улаанбурхны вирус температур, гэрэлд идэвхт чанараа түргэн алддаг онцлогтой (24, 26, 30) энэ «эмзэг» шинж чанар вакциин омогт дамжин хадгалагдаж улддэг учир температур, гэрэлд идэвхт чанараа амархан алддаггүй вакции бий болгох талаар ЗХУ болон бусад оронд судалгаа хийж байна (2, 17, 11). Одоо туршилтанд байгаа «Москва-5» вакции (1984 оноос эхлэн мэдээлэл гаргасан) практикт хэрэглэж буй улаанбурхны вакциинудын дотор температур, гэрэлд хамгийн тэсвэртэй нь гэж үзэж байгаа юм (11). Улаанбурхны амьд вакции нэг ампулдаа 2 тунгаар хатааж, талсжуулсан хэлбэрээр савлагдах ба (12-оос дээш) хүйтэнд 1 жил хадгална. Найруулж усгасны дараа 30 минутын дотор хэрэглэхгүй бол дархлал тогтоо чадвараа алддаг. Ийм учраас манай улсад вакции хадгалах, тэсвэрлэх, хийх үеийн техник ажиллагаанд нарийн дэглэм шаардлагдаж, ялангуяа дулааны улиралд хөдөө орон нутагт жилийн турши хэрэглэх боломжийг хүндруулж байна.

4. Вакциин дархлалд зарим халдварт өвчин бусад вакциин нөлөөлдөг байдлыг харгалзан вакциин түр хойшлуулах заалт, вакции болон зарим халдвартын хооронд баримтлах хугацааг тогтоожээ. Судалж тогтоосон эдгээр заалтын хяналтыг БНАГУ, БНСЧСУ-д «Улаанбурхны өвчлөл, вакцинжуулалтын хөдлөлийн судалгаа»-гаар практикийн байгууллагууд хянаж байна. Манай орон энэ үзүүлэлтийг урьдчилан сэргийлэх тарилгын ажиллагаанд ойрын хугацаанд ивэртуулэх шаардлагатай байна.

Стратеги, тактикийг хэрэгжүүлэх

үндсэн чиглэл

Улаанбурхны вакциин шинэчилсэн схемийн дагуу аймаг, хотын төвд хийж буй одоогийн энэ «Рутин» хэлбэрээр сумын эмнэлэг, бригадын эмнэлгүүдэд хэрэглэх боломжийг системтэйгээр өргөжүүлэх, тогтолцоог цахилгантай сумын эмнэлгийг вакции хөргөлтийн системтэй болгох, бригадын үйлчилгээний хүрээнд вакциинжуулалт зохион байгуулах оновчтой арга боловсруулах.

Вакции зохион байгуулахад хэрэглэж ирсэн төлөөлөгчийн хэлбэрийг бүрэн зогсоож, «Өвчлөл, вакцинжуулалтын үр дүнг хяналт удирдлагын системийг социалист орнуудын туршлагад тулгуурлан, өөрийн өвөрмөц онцлогт тохирсон арга барилаар хэрэгжүүлэх. Үүний бэлтгэл ажил болгон 1986—1987 оноос эхлэн «Улаанбурхны өвчлөл, вакцинжуулалтын хөдлөлзүйн» судалгааны аргыг сэргийлэх тарилгыг гардан хийж буй ажилтанд

эзэмшүүлэх, «Эрүүл мэндийн паспорт»-ыг эрүүл аж төрөх ёс хэрхэн төлөвшиж буйг харуулах нэг гол баримт болгон хотөлж хөвшиүүлэх арга зүй боловсруулан цэцэрлэг, бага, дунд сургууль, цэрэгт анх элсэн орох уед нь тэдний эрүүл мэндийг хамгаалах, халдварт тараахас сэргийлэх үндсэн дээр вакцинжуулсан дараа элсүүлэн авах журам бий болгох. Биологийн идэвхт чанаараа алдаг зарим «эмзэг» вакциин, биобэлдмэлийг хадгалах, тээвэрлэх, хөргөх найдвартай систем бий болгох эх сурвалжийг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэн энэ зорилгоор аймаг, хотод вакциин, биобэлдмэлийг хадгалах, хөргөх системтэй зориуулалтын склад баруулах асуудлыг шийдвэрлэх.

Хөргөх нарийн систем бага шаардах тийм вакциин манай нөхцөлд тохиromжтой харгалзан гэрэл, температурт тээвэртэй вакциинг сонгон хэрэглэх таатик баримтлан вакциин биологийн идэвхт чанарыг вирус судлал, индикатор, бүртгэлийн аргаар хянаж, вакциин тариулсан хүүхдийн өвчлөлийн шалтгааныг вакциин дархлалд нөлөөлж буй серөг хүчин зүйл, эхээс урагт дамжих дархлалын таныц, вакциин эхлэн тарих тохиromжтой нас, давтан вакцинжуулалтын судалгаа болон хүн амын дархлалын түвшинг тодорхойлох иммунолог-серологийн судалгааны чиглэлээр төлөвлөгөөтэй авч хэрэгжүүлэх.

Вакциин хамралт нь тавьж буй энэ зорилтыг шийдвэрлэх эхний алхам бөгөөд эмнэлгийн үйлчилгээний чанаас шууд хамаарах ажил юм. 1981—1985 онд эмнэлгийн заалтаар вакцинжуулалтаас чөлөөлгөж буй хувь 10—15 байгааг

1. 1986—1990 онд 5—10%
2. 1991—1995 онд 3—5%

3. 1996—2000 онд 1—3% хүртэл бууруулах таатикийн үүднээс вакцинаас чөлөөлж буй эмнэлгийн заалтыг хянаж багасгах, бие султай өвчлөмтгийн хүүхдийг вакцинжуулалтанд хамруулах арга бо-

-
-
-

ловсруулах. Энэ зорилгоор «Эмнэлгийн заалт хянах» мэргэжлийн хамтлагийг нэгж, хэсгүүдэд ажиллуулан эмнэлгийн заалтаар түр чөлөөлгэсэн хүүхдийг тусгайлан эмчилж, вакцинжуулах журам боловсруулах.

Тодорхой биш шалтгаанаар 15—20% нь 1981—1985 онд вакцинжуулалтаас чөлөөлгэсэн байна. Үүнийг 1986—1990 онд багтааж бүрэн зогсоох арга хэмжээ авах.

Вакциин хийсэн тухай «тарильтын картанд» тэмдэглэхийн хамт хүүхдийн эрүүл мэндийн паспортанд тусгай таних тэмдэгээр тэмдэглэх ясь, цэцэрлэг, ТМС-д анх элсэн ороход нь тэр хүүхдийн эрүүл мэндийг хянах журам тогтоох. Энэ журмыг ЗХУ-ын жишигэээр ард иргэдийн шилжих хөдөлгөөний уед баримтлах боломжтой юм.

Дээр дурдсан ойрын болон хэтийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд вакцинд хамрагдсан байдал, вакциины дархлалын түвшинг үе шатчилан нэмэгдүүлэхээр төлөвлөж болно гэдэг дүгнэлт хийж байна. Үнд: 1981—1985 онд вакцинд хамрагдсан байдал 67—88% байгааг

1. 1986—1990 онд 90—97%
2. 1991—1995 онд 95—98% д хүргэх мөн вакциин дараах дархлал 63,6 — 74,3% байгааг

1. 1986—1990 онд 80—90%
2. 1991—1995 онд 90—95%

3. 1996—2000 онд 95% болгож чадсаар өвчлөлт өнгөрсөн 5 жилийн дунджаар 10000 хүн амд 26,9% байгааг

1. 1986—1990 онд 7—11%
2. 1991—1995 онд 4—7%

3. 1996—2000 онд 2—0,05% хүртэл бууруулах боломжтой болох юм.

Энэ нь эпидемиэс алаг цоог өвчлөлд, алаг цоог өвчлөлөс ховор бүртгэгдэх өвчлөлийн хэлбэрт аажим шилжих болох диалектик зүй тогтолыг шинжилж ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлнэ гэсэн хэргээ юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. О. Г. Анджапаридже — Достижения и перспективы специфической профилактики вирусных заболеваний Вестн. АМН СССР. 1983, 12, 3—8.

2. О. Г. Анджапаридже, И. Б. Коняева, Н. Н. Боголюбова и др.—Сравнительная характеристика физико-химических свойств вакцинированного штамма Л—16 вируса кори и его клона. Москва—5. Воп. вирусол. 1984, 6, 691—693.

3. П. Н. Бургасов—Ликвидация кори—Близжайшая задача ЖМЭИ, 1983, 6, 3—6.

4. В. М. Болотовский, Б. Г. Геликман, И. В. Славинская и др.—Иммуноструктура привитых против кори детей школьного возраста ЖМЭИ, 1984, 2, 83—86.

5. В. М. Болотовский, Н. С. Титова—Современные аспекты проблемы вакцинопрофилактики кори. Сов. мед. 1974, 1, 22—26.

6. В. М. Болотовский, О. М. Тамм, Б. Г. Геликман и др.—Иммuno-эпидемиологические наблюдения за длительностью поствакцинального иммунитета у привитых

против кори детей. ЖМЭИ, 1987, 6, 36—42.

7. Ф. Л. Блэк, Л. Л. Берман, М. Либель и др.—Недостаточность иммунитета против кори у детей вакцинированных в раннем возрасте: влияние повторной вакцинации. ВОЗ. Бюллетень, том 62, 2, 1984, 109—114.

8. А. М. Галазка, Б. А. Лайэр, Р. Х. Генденсон и др.—Показания и противопоказания к применению вакцин в рамках расширенной программы иммунизации ВОЗ. Бюллетень, том 62, 3, 1984, 12—20.

9. Б. И. Липовецкая—Корь в Монголии. В кн: Сборник научных работ (Эпид. Бак. и клиника инф. заболеваний) 1941. выпуск 1, 77—89.

10. С. К. Литвинов, Џ. Торриджиани, Г. И. Подопригора—Программа ВОЗ по разработке новых вакцин: цели задача и подходы. ЖМЭИ, 1985, 9, 96—101.

11. С. С. Узанов, Н. В. Юминова, А. Л. Пасечник и др.—Клинические и сероэпидемиологические исследования привитых живой коревой вакциной из генети-

- ческих однородного штамма. Москва 5. ЖМЭИ, 1985, 9, 49—54.
12. Е. Батболд, П. Нямдааваа, С. Алтанхүяг—Монгол хүүхдэд улаан бурхны эсрэг идэвхгүй дархалыг судлах асуудалд. Ана-гаах ухаан, 1984, 4, 36—39.
13. Ч. Дангаа, П. Маам—К вопросу изучения эпидемиологии кори в МНР в условиях массовой иммунизации. В кн: Актуальные вопросы вирусологии (тезисы докладов 11 Республиканской вирус. конф) 1980, 32—35.
14. Г. Жамба, В. Ф. Попов—Особенности коревой инфекции в Монголии. В кн: Актуальные вопросы педиатрии, акушерства и гинекологии (материалы совместной монголо-советской научно-практической конференции) УБ. 1977. 79—81.
15. Ж. Купул, Л. Пурэвжав—Анализ зарегистрированных случаев инфекционных заболеваний в МНР за последние 20 лет (1958—1978 гг). В кн: Научно-практическая конференция, посвященная к 55-летию провозглашения МНР. УБ. 1979. 8—11.
16. Ж. Купул, О. Цэрэнчимэд—Эпидемиология и профилактика кори в МНР. В кн: Научно-практический конф. мед. работников. посвященная 50 летию провозглашения МНР. УБ. 1974, 70—72.
17. П. Нямдааваа, Г. Штарке, Э. Герике и др.—Сероэпидемиология важнейших вирусных инфекций человека в МНР. В кн: Тезисы докладов третьей научно-практической конференции. Актуальные вопросы вирусологии. УБ., 1982. 3—4.
18. Н. Уртнасан, П. Нямдааваа—Эпидемиологический анализ вспышки кори в Ховдском аймаке в 1981—1982 годах. В кн: Тезисы докладов третьей научно-практической конференции. Актуальные вопросы вирусологии. УБ., 1982. 11—13.
19. С. Цэрэн, Ж. Купул, Ч. Лхагва, И. Ф. Чебаторь—Современные особенности эпидемиологического процесса коревой инфекции в МНР. В кн: Тезисы докладов IV-ой научно-практической конференции. Актуальные вопросы вирусологии, УБ., 1984, 28—29.
20. Б. Энхболд, Г. Церендагваа, Е. Батболд—К изучению клинико-эпидемиологических особенностей кори в условиях массовой вакцинации. В кн: Тезисы докладов IV-ой конф. Актуальные вопросы вирусологии, УБ., 1984. 26—17.
21. Ambrosch F. und G. Wiedermann Epidemiologische Untersuchungen zur Masernimpfung. Wjener Kjinische Wochenschrf 1976, 88. s., 545—548
22. Ganbaatar B. Bedeutung der biologischen Stabilität des Masern-Zebend-Impstoffes im Hinblick auf testlegungen zur Masernbekämpfung in der MVR Dissertation, Berlin, 1985, s. 1—70
23. Foege William H. The global elimination of measles Public Health Reports 97, 1982, s. 402—405
24. Gray A. Stability of measles vaccines Inf. Congr. Biol. Stand, Ze. Gazier. 1978 s. 265—266
25. Hitzig W. H. Impfungen gegen Masern Therapeutische Umschau, 1983. 3/40, s. 209—211
26. Improved stability of freeze-dried measles vaccine W—ly Epidem. Rec. 1979, 46, s. 354
27. Kubas M. Ober eine Beobachtung im Verlauf der Masernschutzimpfung Dtsch. Ges. wesen. 1966 s. 881—882
28. Starke G., P. Hlinak, B. Nöbel, Chr. Winkaler Maserneradikation-eine Möglichkeit? Dtsch. Ges. wesen. 1970. 25. s. 2384—2390
29. Starke G. And S. Rudinecz Der gegengärtige Stand des Masern-Eradikations-programmes in der DDR I. Hyd. Ep. Mikro. und Immun. 1975, 19. s. 265—270
30. Stability of Freeze-Dried measles vaccine Wkly-Epidemiol. Rec. 1981. 23, s. 177—184

К ВОПРОСУ СТРАТЕГИЯ И ТАКТИКА БОРЬБЫ С КОРЬЮ

Б. ГАНБАТОР.

В статье даётся ретроспективный анализ заболеваемости корью регистрируемой в МНР, за последние 20 лет в сопоставлении с данными серологических и иммунологических исследований. В 1973 году в нашей стране проведена массовая иммунизация детей в возрасте от 10 месяцев до 15 лет. Использовалась живая коревая вакцина Л—16. Массовая иммунизация против кори привела к значительному снижению заболеваемости. Ты же анализировали возможность формирования иммунитета против кори. На основании этого прогнозировали охват детского населения вакцинацией против кори, ожидаемые результаты иммунной прослойки и заболеваемости в последующие годы.

Редакций ирсэн 1986. 06. 04

Ц. Цэрэгмаа (*Анагаах ухааны дээд сургууль*)

А. А. Подколзин, В. А. Томилец (*Москва хотын Анагаах ухааны II дээд сургууль*)

ЭСЭД ЦАГИРАГТ АДЕНОЗИН МОНОФОСФАТ (Ц—АМФ)-ЫГ ИХЭСГЭГЧ БОДИСЫГ ХЭРЭГЛЭН ДАРХЛАЛЫН ҮЛ ХАРИУЛАХ ЧАНАР ҮҮСГЭХ НЬ

Эсийн доторх цагираг нуклеотидын хэмжээ нь дархлалын урвалыг зохицуулахад чухал нөлөөтэй болох нь сүүлийн үед тодорхой боллоо. Ялангуяа ц—АМФ (цагираг аденоzin монофосфат) нь дархлалын урвалыг дарангуйлж дархлалын үл хариулах чанар (иммунная толерантность) үүсгэдэг гэж үзэж байна. Харшлыг эмчлэхэд ийм дархлалын үл хариулах чанар бий болгох шаардлага гардаг тул энэ нь практикийн ихээхэн ач холбогдолтой юм.

Эсэд ц—АМФ ихсэхэд гистамин болон бусад биологийн өндөр идэвхт бодисууд ялгарах нь багасаж (4,7), эсрэг бие үүсэх нь дарангуйлагдаж (5), лимфоцитын эс хөнөөх чанар сулардаг болох нь (2) илрэв. Эсэд ц—АМФ-ын хэмжээг ихэсгэдэг бодисууд нь антиген бамитогены нөлөөгөөр лимфоцит хуваагдах процессыг дарангуйлж сааттуулна (3). Харин ц—ГМФ (цагариг гуаназин монофосфат) нь дархлалын урвалд ц—АМФ-ын эсрэг үйлчлэл үзүүлдэг.

Лимфоцитын идэвхижлийн тухай орчин үеийн нэлээд тархмал онолын (8) ёсоор бол антиген лимфоцитод үйлчлэхэд эсийн доторх ц—АМФ багасаж, ц—ГМФ ихсэн лимфоцитын хуваагдал идэвхэждэг. Тэгвэл ямар нэг антиген биед үйлчлэх үед эсийн доторх, ц—АМФ-г ихэсгэвэл уг эсрэг төрөгчийн хувьд дархлалын үл хариулах чанар үүсэх ёстой. Гэвч эсэд ц—АМФ ихэсгэх үйлчлэлтэй бодисыг хэрэглэх замаар харшлын үед дархлалын үл хариулах чанар бий болгох гэсэн туршилтууд одоо хэр төдийлөн тодорхой үр дунд хүрч чадаагүй байгаа билээ. Амжилтгүй болох шалтгаан нь уг бодисыг бага хэмжээгээр ганц удаа хэрэглэсэнтэй холбоотой байж болох юм. Иймээс бид эсэд ц—АМФ багасаж, ц—ГМФ ихсэн лимфоцитын хуваагдал идэвхжэдэг замаар дархлалын үл хариулах чанар үүсгэх боломжийг туршин судлах зорилт тавив.

Судалгааны материал, арга зүй

Туршлагыг 150—200 г жинтэй 74 усан гахайд хийв. Туршлагын амьтдыг 2 бүлэгт хуваан нэгдүгээр бүлгийн усан гахайд 0,1 мл адууны хэвийн ийлдсийг 1 удаа арьсан дор тарив. Хоёрдугаар бүлгийн усан гахайн арьсан дор шарилжны тоосонцырын ханд мэн 0,1 мл 1 удаа тарьж мэдрэгжүүлэв. Тоосонцырын антигены үйлчилгээг удаан болгож сайжруулах зорилгоор хөнгөн цагааны усан ислийн 33 мг/мл концентрацттай гель 0,5 мл-г антигены хамт тарив. Дархлалын үл хариулах чанар үүсгэх зорилгоор ПГЕ₂ (простагландин Е₂) аминофиллин болон ц—АМФ-г хэрэглэлээ. ПГЕ₂-ын 10³ м уусмал 0,2 мл, аминофиллиныг кг жинд 50 мг-аар, ц—АМФ-г кг жинд 5 мг-аар бэдож мэдрэгжүүлэлтийн эхний 1—5 хоногт хэвлэлийн хөндийд дээрх бодисыг тарьснаас хойш 12 хоног дээр эсрэгтөрөгчийг арьсан дор мэн 0,1 мл хийж дахин мэдрэгжүүлэв. Мэдрэгжүүлэлтийн байдлыг Бойдены цус шууд бус наалдуулах урвал (ЦШБНУ), Оварын арьсны идэвхгүй анафилаксын (АИА) сорилоор (1,6) 2%-ийн Эвансийн хөхийг хэрэглэн тодорхойлов. 14—15 хоног дээр амьтдыг анх мэдрэгжүүлсэн эсрэгтөрөгчөөс 1 мл-г судсанд тарьж шийдэх тунг тодорхойлов. Шийдэх тунгийн дунг Вейгле-Кохрене-Диксоны арга (9) шокийн индек-

сээр тооцоолов. Судалгааны материалд дүн бүртгэлийн боловсруулалт хийв. (Хүснэгт 1)

Судалгааны үр дүн.

Бидний судалгаа нь дархлалын засварыг мэдрэгжүүлэлтийн эхний үед олон дахин хийх нь үр дүнтэй болохыг батлав.

Хүснэгт 1-ээс үзэхэд туршлагын амьтанд дархлалын засвар хийснээр тухайн эсрэгтөрөгчийн эсрэг дархлалын хариу урвал эрс буурсан нь харагдаж байна. Зарим тохиолдолд тухайлбал ПГЕ₂, аминофиллиныг хавсан хэрэглэхэд адууны ийлдсээр мэдрэгжүүлсэн усан гахайд ЦШБНУ-ын таньц $0,75 \pm 0,6$; АИА 0; шарилжны тоосонцор тарьсан амьтдад ЦШБНУ-ын таньц $0,5 \pm 0,3$; АИА мөн 0 болж мэдрэгжилт бараг үгүй болжээ. Энэ байдал шийдэх тун хийх үед ч ажиглагдав. Дархлалын засвар хийгээгүй амьтанд шокийн индекс адууны ийлдэс тарихад $3,5 \pm 0,3$; тоосонцрын ханд тарихад $3,2 \pm 0,3$ байсан бол дархлалын засварын үр дүнд $0,25 \pm 0,2$; $0,20 \pm 0,1$ болж багассан байна. Хоёр сарын дараа үзэхэд эсрэг биесийн таньц бага хэвээр байсан нь бидний үсгэсэн дархлалын үл хариулах чанар нэлээд батжилтай болохыг харуулав.

Дүгнэлт.

1. ц—АМФ болон эсэд түүний хэмжээг ихэсгэгч бодис нь дархлалын үл хариулах чанар үүсгэх чадвартай байна.

Хүснэгт 1

Туршлагын амьтанд дархлалын засвар
хийсэн судалгааны дүн

| № | Амьтны тоо | Мэдрэгжүүлсэн антиген | Дархлалын засвар хийхэд хэрэглэсэн бодис | Шокийн индекс | ЦШБНУ | АИА |
|----|------------|-------------------------|--|----------------|----------------|-------|
| 1 | 5 | адууны ийлдэс (АИ) | — | $3,5 \pm 0,3$ | $4,5 \pm 1,0$ | 1:128 |
| 2 | 5 | шарилжны тоосонцор (ШТ) | — | $3,2 \pm 0,3$ | $4,0 \pm 0,8$ | 1:128 |
| 3 | 8 | АИ | ПГЕ ₂ + аминофиллин | $0,25 \pm 0,2$ | $0,75 \pm 0,6$ | 0 |
| 4 | 8 | ШТ | ПГЕ ₂ + аминофиллин | $0,20 \pm 0,1$ | $0,5 \pm 0,3$ | 0 |
| 5 | 8 | АИ | ПГЕ ₂ | $2,3 \pm 0,7$ | $1,7 \pm 0,3$ | 1:16 |
| 6 | 8 | ШТ | ПГЕ ₂ | $1,0 \pm 0,7$ | $0,3 \pm 0,2$ | 1:2 |
| 7 | 8 | АИ | аминофиллин | $4,0 \pm 0,8$ | $7,7 \pm 0,4$ | 1:128 |
| 8 | 8 | ШТ | аминофиллин | $2,6 \pm 0,3$ | $1,7 \pm 1,0$ | 1:8 |
| 9 | 8 | АИ | ц—АМФ | $3,7 \pm 0,2$ | $7,6 \pm 1,1$ | 1:64 |
| 10 | 8 | ШТ | ц—АМФ | $2,0 \pm 0,6$ | $2,0 \pm 0,4$ | 1:8 |

2. Дурдсан бодисыг олон дахин хэрэглэх нь дархлалын үл хариулах чанар үүсэхэд сайн нелөөлөв.

3. Дархлалын үл хариулах чанар үүсэх нь бодис бүрт болон антиген бүрт харилцан адилгүй ба бодисыг хавсан хэрэглэхэд илүү үр дүнтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. *Boydens S.V.J. exp. med.* 1951. V 93, p 107—120
2. *Henney C.S. Bourne H.R. Lichtenstein L J.Immunol.* 1972. V 108, p 1526—1531
3. *Goodwin G.S. Bankhorst A.D. Messner R.P. J. exp med.* 1977. v 146. p 1719—1734
4. *Lagunoff D. Biochem. Pharmacol.* 1972 v. 21. p 1883—1889
5. *Melman K.J. Bourne H.R. J. Clin. invest.* 1974 v 53 p 13—22
6. *Ovary. Int. Arch. Allergy.* 1953 v 3 p 293
7. *Uvnäs B.Life Sci* 1974 v 14 p 2355—2366
8. *Watson J. Epstein P.Cohn, M.Nature* 1973 v 246, p 404—407
9. *Weigle W.Cochrane C.Dixon E. J.Immunol.* 1960.p 469—477

ИНДУКЦИЯ ИММУНОЛОГИЧЕСКОЙ ТОЛЕРАНТНОСТИ ВЕЩЕСТВАМИ, УВЕЛИЧИВАЮЩИМИ УРОВЕНЬ ВНУТРИКЛЕТОЧНОГО ц—АМФ

Ц. Цэрэгма, А.А. Подколзин, В. А. Томилец

Исследование проводилось на 74 морских свинках, сенсибилизованных нормальной лошадиной сывороткой и экстрактом полыни. Для создания иммунологической толерантности использованы ц—АМФ, аминофиллин и простагландин Е₂, которые увеличивают внутриклеточный ц—АМФ. Результаты исследования показали, что многократное, длительное использование веществ, увеличивающих уровень ц—АМФ в клетке, приводит к развитию толерантности к данному антигену.

Редакцияд. ирсэн 1986. 12.01

Д. Баасанжав (*Анагаах ухааны хүрээлэн*)
Г. Цагаанхүү (*Анагаах ухааны дээд сургууль*)

МЭДРЭЛИЙН ӨВЧТӨНД ҮЗҮҮЛЖ БАЙГАА СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ЦААШИД САЙЖРУУЛАХ НЬ

Судалгааны зорилт, арга, материал

Аймаг, хотуудын нэгдсэн эмнэлэгт 1981—1983 онд хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо болон ажилласан ор, орны эргэлт зэргийг аймаг хотуудаас Эрүүлийг хамгаалах Яаманд ируулсэн эмнэлгийн үйл ажиллагааны тайландаа дун шинжилгээ хийж статистик үзүүлэлтүүдийг гарган судалж хэвтүүлэн эмчлэх тусlamжийн хэрэгцээг хэрхэн хангаж байгааг аймаг хотуудын нэгдсэн эмнэлэг бүрээр бо-

лсын улсын хэмжээгээр нэгтгэн авч үзэн үнэлж дүгнэв.

Дурдсан 3 жилд аймаг хотуудад мэдрэлийн өвчинөөр хэвтэж эмчлүүлсэн өвчтөнүүдийн тоог он сноор болон 3 жилийн дунджаар, мөн оны эргэлтийн дундаж, ажилласан мэдрэлийн ор, 1000 хүн амьтдам мэдрэлийн өвчинөөр хэвтсэн өвчтөнүүдийн болон ногдох орны үзүүлэлтүүдийг гаргав. (Хүснэгт 1).

Судалгааны үр дүнгээс: Улсын хэмжээгээр дурдсан 3 жилд дунджаар жилд 8700 өвчтөн (1981 онд 8243, 1982 онд 8817, 1983 онд

Хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо болон орны
эргэлт, ажилласан орны дундаж тоо, 1000 хүн
амд ногдох зарим үзүүлэлт

Хүснэгт 1

| Аймаг, хот | Хэвтсэн өвчтөний тоог он тус бүрээр болон 3 оны дунджаар | | | | | Ажилласан дун- даж орны тоо | Орны эргэлт дундаж | 1000 хүн амд ног- дох дундаж | |
|---------------|--|------|------|------------------------|-------------|--------------------------------|-----------------------|------------------------------------|-------------|
| | 1981 | 1982 | 1983 | 3 оны дунд- жаар | орны тоо | | | орны тоо | орны тоо |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | |
| 1. Архангай | 448 | 682 | 489 | 539,7 | 26,0 | 20,7 | 6,4 | 0,3 | |
| 2. Баян-Өлгий | 207 | 218 | 205 | 210,0 | 10,0 | 21,0 | 2,5 | 0,1 | |
| 3. Баянхонгор | 336 | 379 | 321 | 345,3 | 20,0 | 17,2 | 5,0 | 0,3 | |
| 4. Булган | 103 | 140 | 166 | 136,3 | 8,6 | 15,8 | 3,0 | 0,2 | |
| 5. Говь-Алтай | 169 | 190 | 209 | 189,3 | 14,0 | 13,5 | 3,0 | 0,2 | |
| 6. Дорноговь | 90 | 93 | 83 | 88,7 | 7,0 | 12,6 | 1,9 | 0,1 | |
| 7. Дорнод | 303 | 297 | 307 | 302,3 | 16,6 | 18,2 | 4,5 | 0,2 | |
| 8. Дундговь | 151 | 133 | 176 | 153,3 | 10,0 | 15,3 | 3,5 | 0,2 | |
| 9. Завхан | 239 | 314 | 363 | 305,3 | 20,0 | 15,2 | 3,5 | 0,2 | |
| 10.Өвөрхангай | 318 | 325 | 341 | 328,0 | 21,6 | 15,2 | 3,5 | 0,2 | |
| 11.Өмнөговь | 151 | 204 | 203 | 186,0 | 11,3 | 16,5 | 5,2 | 0,3 | |
| 12.Сүхбаатар | 157 | 207 | 242 | 202,0 | 15,6 | 13,0 | 4,3 | 0,3 | |
| 13.Сэлэнгэ | 146 | 147 | 220 | 171,0 | 13,0 | 12,9 | 2,2 | 0,2 | |
| 14.Төв | 289 | 313 | 323 | 308,3 | 19,0 | 16,2 | 3,4 | 0,2 | |
| 15.Увс | 281 | 358 | 304 | 314,3 | 20,0 | 15,7 | 3,9 | 0,2 | |
| 16.Ховд | 287 | 383 | 367 | 345,7 | 20,0 | 17,2 | 4,8 | 0,3 | |
| 17.Хөвсгөл | 498 | 326 | 535 | 453,0 | 30,0 | 15,1 | 4,7 | 0,3 | |
| 18.Хэнтий | 249 | 214 | 160 | 207,7 | 16,3 | 12,7 | 3,4 | 0,3 | |
| Аймгуудын дүн | 4422 | 4923 | 5014 | 4781,3 | 299,3 | 15,8 | 3,8 | 0,2 | |

Нэг аймагт
ногдох дундаж

245,7 273,5 278,5 265,6 6,61

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|--|------|------|------|--------|------|------|-----|---|
| УБ хотын клиникийн төв эмнэлэг | 1392 | 1316 | 1674 | 1460,7 | 70,0 | 20,9 | | |
| УБ хотын ЭХГ-ын харьяа бусад эмнэлгүүд | 453 | 576 | 170 | 339,7 | 32,7 | 10,4 | | |
| УКТЭ | 768 | 718 | 691 | 725,7 | 50,0 | 14,5 | | |
| Улсын нэгдсэн тусгай эмнэлэг | 286 | 372 | 401 | 353,0 | 54,3 | 14,5 | | |
| Дархан | 442 | 432 | 441 | 438,3 | 20,0 | 21,9 | 6,8 | |
| Эрдэнэт | 112 | 168 | 290 | 190,0 | 20,0 | 9,5 | 4,7 | |
| Төмөр замын эмнэлэг | 368 | 312 | 377 | 352,3 | 20,0 | 17,6 | | |
| Хотуудын дүн | 3821 | 3894 | 4044 | 3919,7 | 23,7 | 15,6 | 6,8 | |

Аймаг хотуудаар нэгтгэсэн дүн

(Улсын хэмжээний) 8243 8817 9058 8699,5 536,3 15,7 4,8

9058) мэдрэлийн өвчнөөр хэвтэж эмчлүүлсний 4781 нь (53%) аймгуудад, улдсэн 47% нь (3919 өвчтөн) хотуудад тус тус байжээ.

Хотуудад эмчлүүлсэн мэдрэлийн нийт өвчтөний 3200 (81,6%) нь зөвхөн Улаанбаатар хотод эмчлүүлсэн байна. Дархан хотод жилд 438,3, (1000 хүн амд 6,8), Эрдэнэтэд 190,0 (1000-д 4,7) тус тус эмчлүүлжээ. Улаанбаатар хотод эмчлүүлсэн мэдрэлийн нийт өвчтөнөөс 1460,7 (45%) нь УБ хотын клиникийн төв эмнэлэгт, 725,7 (22,6%) нь улсын клиникийн төв эмнэлэгт, 353,0 (11,0%) нь улсын нэгдсэн тусгай эмнэлэгт, 342,5 (11,%) нь төмөр замын нэгдсэн эмнэлэгт, бусад нь (10% орчим нь) районын эмнэлэгт тус тус хэвтэж эмчлүүлсэн нь дээрх хотуудын (Улаанбаатар, Дархан, Эрдэнэт) нийлбэр дүнгээр 1000 хүн ам тутмаас дунджаар 6,8 өвчтөн хэвтэж эмчлүүлжээ.

Аймгуудад хэвтэж эмчлүүлсэн мэдрэлийн өвчтөнүүдийн дундаж тоо хоорондоо нэлээд ялгаатай Сайна. Тухайлбал, Дорноговь аймагт 88,7, Архангай аймагт 539,7 байгаа нь даруй 3,8 дахин их байна. Нийт аймгийн дунджаар жилд нэг аймагт 265,6 өвчтөн хэвтэж эмчлүүлсэн нь нэг аймагт дунджаар 15—16 ор ажиллаж иржээ.

Улсын хэмжээгээр дурдсан онуудад жилд дунджаар 537 ор ажиллаж байснаас 300 ор (55,8%) нь аймгуудад, улдсэн 237 ор (44,2%) ць хотуудад тус тус ажилласан байна.

1000 хүн ам тутмаас мэдрэлийн өвчнөөр хэвтсэн өвчтөнүүдийн тоо аймгуудын дунджаар 3,8, хотуудын дунджаар 6,8, улсын дунджаар 4,8 үзүүлэлттэй байна. 1000 хүн амд ногдох мэдрэлийн ор аймгуудын дунджаар 0,2, хотуудын дунджаар 0,4, улсын дунджаар 0,3 тус тус үзүүлэлттэй байна.

Мэдрэлийн орны эргэлт аймгуудад жилд 12,6—21-ийн дотор байж нийт аймгуудын дунджаар 15,3 байв.

Аймгуудын энэхүү дунджаас доогуур үзүүлэлт бүхий орны эргэлттэй аймгуудад Дорноговь (12,6), Хэнтий (12,7), Сэлэнгэ (12,9) Сүхбаатар (13,0), Говь-Алтай (13,5) зэрэг аймаг орж байна. Энэ нь дээрх аймгуудад мэдрэлийн дундаж ор хоног бусдаасаа харьцангуй өндөр байсныг харуулж байна. Орны эргэлтийн үзүүлэлт харьцангуй өндөр Сайгаа аймгуудад Баян-Өлгий (21,0), Архангай (20,7%), Дорнод (18,2), Ховд, Баянхонгор (17,2) аймгууд орж байна. Эдгээр аймагт дундаж ор хоног бусдаасаа харьцангуй бага байсныг харуулж байна. Ор-

ны эргэлт. дундаж ор хоногт хэвтээн өвчтөнүүдийн өвчний бүтэц, орны хүрэлцээ, ажилласан мэргэжлийн эмчийн ажиллагаа их нөлөөлж байна.

Дээрх өрөнхий дундаж үзүүлэлтүүдээс үзвэл аймгуудад хүн амд үзүүлж байгаа мэдрэлийн стационарын тусlamжийн хэрэгцээний шаардлага хотуудаас доогуур түвшинд байв. Гэвч аймгуудад энэ байдал ялгаатай байна. Архангай аймагт 1000 хүн ам тутмаас жилд 6,4 өвчтөн хэвтэж эмчлүүлсэн нь мэдрэлийн өвчинөөр хэвтэх хэрэгцээний шаардлагыг зохих түвшинд хангаж байгаа нь харагдаж байна. Архангайгаас доогуур ч гэсэн харьцангуй дээр үзүүлэлттэй (1000 хүн амд ногдох) аймгуудад Өмнөговь (5,2), Баянхонгор (5,0), Ховд 4,8). Хөвсгөл (4,7), Дорнод (4,5), Сүхбаатар (4,3) зэрэг орж байна.

Гэтэл хэт доогуур үзүүлэлт Дорноговь (1,9) Баян-Өлгий (2,5), Сэлэнгэ (2,2) аймагт гарч байгаа нь эдгээр аймагт мэдрэлийн өвчинөөр хэвтэж эмчлүүлсэн тусlamжийн хэмжээ бусад аймгаас ихээхэн доогуур байсан буюу мэдрэлийн стационарын тусlamжийн хэрэгцээг муу хангаж байжээ. Үлдсэн аймгуудад ч 1000 хүн ам тутмаас хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тооны дундаж үзүүлэлт 3,0—3,9 дотор байгаа нь хангалттай биш байна.

Аймгуудын нэгдсэн эмнэлэгт ажилласан мэдрэлийн орны дундаж тоо 7,0—30-ийн дотор байгаа нь аймгуудын дунджаар нэг аймагт 16,6 ор ажиллаж байна. Гэтэл энэ дунджаас ч доогуур тооны орыг Дорноговь (7,0 ор), Булган (8,6 ор), Баян-Өлгий (10,0 ор), Дундговь (10,0 ор), Сэлэнгэ (13,3 ор) аймгуудад ажиллуулсан нь 1000 хүн амд ногдох орны үзүүлэлт 0,1—0,2-оос хэтрээгүй байна.

ЗХУ-ын судлаачдын судалгаагаар хүн амд үзүүлэх мэдрэлийн стационарын тусlamжийн норм, норматив 1000 хүн ам тутмаас хэвтэх шаардлагатай өвчтөний тоо 6,88—10,5 дотор байна (1, 2). Хэвтэх шаардлагатай өвчтөний тоо хүн амын дунд тухайн өвчний өвч-

лөлтийн хэмжээ, хүн амын насы болон ажил мэргэжлийн онцлог, суурьшлын байдал зэргээс хамаарах учир зарим ялгаатай байдаг.

ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамнаас бүх холбоотын хэмжээнд 1980—1985 онд баримтлах мэдрэлийн стационарын тусlamжийн дундаж нормативыг 1000 хүн ам тутмаас дунджаар 6,7 хүн хэвтэхээр тооцож тогтоосон байна. Энэ нормативыг манай оронд авч хэрэглэх бүрэн боломжтой нь харагдаж байна. Зарим аймаг, хотод (Улаанбаатар, Дархан хот, Архангай аймагт) дээрх нормативт хүрсэн байна.

Манай судлаачдын судалгаагаар мэдрэлийн өвчинөөр эмчлэх ор 1000 хүн амд 0,63—0,66 байх нь хангалттай гэж үзэж байна (3, 4), ЗХУ-д 1980—1985 онд мөрдөж баримталбал зохих бүх холбоотын өрөнхий дундаж нормативоор 1000 хүн амд 0,47, 1990 онд 0,8 мэдрэлийн ор байвал зохино гэж үзсэн байна.

Дүгнэлт: 1. Тус оронд 1000 хүн ам тутмаас мэдрэлийн өвчинөөр хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тооны үзүүлэлт ихэнх аймагт ихээхэн доогуур үзүүлэлттэй байгаагаас Дорноговь, Баян-Өлгий, Сэлэнгэ, Булган, Говь-Алтай зэрэг аймаг харьцангуй илүү доогуур үзүүлэлттэй байна (1,9—3,0).

Аймгуудад мэдрэлийн өвчинөөр хэвтуулэн эмчилж байгаа тусlamжийн хэмжээ ЗХУ-ын дунджаас (6,7) 2 дахин бага байна. Харин хотуудын дундаж үзүүлэлт ЗХУ-ын дундажтай ойролцоо байна.

2. Тус орны хүн амд ногдох мэдрэлийн орны дундаж тоогоор аймгуудын дундаж үзүүлэлт ЗХУ-ын баримталж байгаа дунджаас (0,47) 36%-иар бага байна. Энэ үзүүлэлтээр улсын дунджаас доогуур үзүүлэлттэй аймгуудад Баян-Өлгий, Дорноговь (0,1), Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс (0,2) аймгууд орж байна.

3. Тус орны хэмжээгээр хүн амд үзүүлэх мэдрэлийн стационарын тусlamжийн хэрэгцээний хуртээмж ихэнх аймагт ихээхэн ду-

тагдалтай байгааг анхаарч ойрын жилүүдэд аймгуудын мэдрэлийн орны дундаж тоог дунджаар 2 дахин нэмэн түүнд ажиллах мэргэжлийн эмч боловсон хүчинээр хангах ажлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

4. Ойрын жилүүдэд тус оронд 1000 хүн ам тутмаас мэдрэлийн өвчнөөр хэвтэх өвчтөний жилийн дундаж тоог 6,0, 1000 хүн амд ногдох орны улсын дунджийг 0,5-аар бодож мэдрэлийн стационарын тусlamжийн хэрэгцээний хангалтыг дээшлүүлэх зорилт тавьж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. И. Д. Богатырев—“Основы организации неврологической помощи населению”. Медицина. 1981. 20.
2. Е. А. Логинова—Там же. 1969. 20.
3. Л. Буджав, Н. Чагнаа—Эрүүлийг хамгаалахын төлөвлөлт, эдийч засаг, нормативын зарим асуудал. 1973. 163—164.
4. Ц. Мухар нар—Эрүүлийг хамгаалахын норм, нормативын төсөл (зөвлөмж) 1986.

3. Мэндсайхан, С. Балгансурэн (Армийн клиникийн төв эмнэлэг)

В. В. Митин, Р. Цэвэлмаа (Улсын клиникийн төв эмнэлэг)

ЗАЛУУ НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ДУНД ТОХИОЛДОЖ БАЙГАА ЗҮРХ СУДАСНЫ ЭМГЭГИЙН ТАРХАЛТЫГ ОЛНООР ФЛЮР ЗУРАГ АВАХ ШИНЖИЛГЭЭГЭР СУДАЛСАН НЬ

Хэрлэг өвчин нь ихэвчлэн залуу хүмүүст тохиолддог. Энэ тухай В. Ф. Зеленин 10—15 насанд хэрлэг бусад нааснаас харьцангуй их, Незлин 15—25 насанд уг өвчний 75% нь тохиолддог болохыг дурдажээ. Г. П. Матвейков болон бусад судлаачдын номонд аль ч оронд энэ өвчин хүн амын дотор 0,3—5,8% эзэлдэг тухай дурдсан байдаг. В. А. Насонова, Л. И. Беневоленская (1971) нарынхаар уг өвчний тархалт нийт хүн амын дунд 2—5%-ийг эзэлдэг ажээ. Гэвч судлаачдын олонх нь орчин үеийн хэрлэгийн эмнэл зүйн шинжүүд бүдгэрч, хурц хэлбэрүүд цөөрөн, сунжруу буюу нууц явцтай хэлбэрүүд олшрон аль хэдий зүрхний гажиг үүсгэсэн хойноо илэрч байгаа тухай бичих боллоо (1—2, 4—5).

Уушгини сурьеэ өвчиний илрүүлэх найдвартай аргын нэг олноор нь флюр зураг авах шинжилгээгээр зүрх судасны эмгэгийг оношлох гэсэн оролдлого нэлээд дээр үеэс эхэлжээ (3). В. В. Зодиев нарын судлаачид цээжний эгц зургаар зүрхний хэлбэр хэмжээ, байрлалыг түйлын анхааралтай шинжилж үзэх нь нэлээд чухал баримжаалсан дүгнэлт хийж болдог тухай бичээд энэ нь бусад байрлалуудаар шинжлэхэд ихэнхлээ нотлогддог юм гэжээ (3). Манай орны нөхцөлд хэрлэг өвчиний тархалтыг залуу хүмүүсийн дотор судалж үзэх нь дараах байдлуудаас шалтгаалж байна. Үүнд:

СОСТОЯНИЕ СТАЦИОНАРНОЙ ПОМОЩИ НЕВРОЛОГИЧЕСКИМ БОЛЬНЫМ В МНР И ПУТИ ЕЕ УЛУЧШЕНИЯ

Д. Басанжав, Г. Цаганху

По данным авторам за 1981—1983 г было госпитализировано 3,8 случаев на 1000 населения по общесреднему показателю аймаков (этот показатель колеблется по аймакам от 1,9 до 6,4) и городов 6,8 сл., а по общегосударственному масштабу—4,8 случаев.

Средний показатель число неврологических койк на 1000 населения составляет 0,2 для аймаков (колеблятся от 0,1 до 0,3), 0,4 для городов. Общегосударственный средний показатель равняется на 0,3 койк на 1000 населения.

Авторы считают, что полученные данные указывает на низкий уровень обеспечения потребности стационарной помощи неврологическим больным в большинстве аймаков и выдвигает предложения для улучшения данного вида помощи населению.

Редакций ирсэн 1986.09.27

1. Манай орны хүн ам эрс залуужсан;

2. Зөвхөн оршин суугаа нутаг орны физик газар зүйн онцлогоор ялгагдахаар үл барам янз бүрийн хэв заншилтай хүмүүс харьцаангуйгаар өргөн уудам нутагт тархан амьдарч байгаа нь энэ өвчний үнэнхүү тархалтыг нэлээд бодитойгоор судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаагаар;

3. Залуу насын эрэгтэйчүүдэд зүрхний хэлбэр дүрсийн өөрчлөлт толдуу хэрлэгийн шалтгаантай байгаагаас;

4. Эмчилгээ урьдчилан сэргийлэх цогцолбор арга хэмжээг зөв төлөвлөн зохион явуулах зэргээс урган гарч байна.

АРГАЧЛАЛ: Дотор, сурьеэ, гэрлийн эмч нарын оролцоотойгоор 13 аймаг хотын нэгдсэн эмнэлэгт 18—28 насын 9000 гаруй залуучуудад олноор нь флюр зураг авах шинжилгээг нэгэн зэрэг хийв. В. В. Зодиевын (1950) аргачлалын дагуу флюр зургуудыг АКТЭ-ийн рентген кабинетад, дотор, зүрх судас, гэрлийн эмч нарын оролцоотойгоор давтац харж:

а) Митраль гажгийн хэлбэртэй зүрхний өөрчлөлт бүхий

б) Гол судасны гажгийн хэлбэртэй зүрхний өөрчлөлт бүхий

в) Зүрхний хоёр ховдлын томрол бүхий гэж ялган булэглэв. Эдгээрийг тогтооход уушгины зураглал нэлэнхүйдээ тодорч. Өтгөрсөн байх нь оношлогооны зайлшгүй нэг хэмжүүр гэж үзсэн болно. Бүлэг тус бүрийг мөн нийлсэн үзүүлэлтүүдийг аймгуудаар гарган промилиор тооцож дундаж алдаат гаргав.

СУДАЛГААНЫ ДҮН: Хүснэгтээр залуу насын эрэгтэйчүүдийг олноор нь уушгины флюр зураг авах шинжилгээгээр судлахад илэрч байгаа зүрхний хэлбэр дүрсийн өөрчлөлтийг ийм насын 1000 хүнд ногдох байдлаар 13 аймаг хотоор харуулав.

Хүснэгт 1

Зүрхний хэлбэр дүрсийн өөрчлөлт (аймаг хотуудаар)

| Аймаг, хот | Mitralь гажгийн хэлбэртэй | Gol судасны гажгийн хэлбэртэй | Xoёр ховдлын томрол бүхий | Бүгд |
|------------|---------------------------|-------------------------------|---------------------------|-----------|
| | M±T | M±T | M±T | M+M±T |
| Булган | 7,2 | 4,1 | 10,3 | 21,6±4,6 |
| Дундговь | 16,1 | 5,3 | 29,6 | 51,2±11,4 |
| Ховд | 26,2 | 1,4 | 17,4 | 45,1±7,9 |
| Увс | 18,2 | 2,8 | 15,3 | 36,4±5,8 |
| Төв | 16,5 | 1,9 | 13,3 | 31,8±4,4 |
| Хөвсгөл | 13,0 | 3,7 | 14,8 | 31,6±5,3 |
| Эрдэнэт | 24,4 | 14,6 | 31,7 | 70,9±12,6 |
| Налайх | 17,9 | 2,9 | 5,9 | 26,9±8,8 |
| Дорнговь | 4,0 | = | 20,0 | 28,0±10,4 |
| Баянхонгор | 6,9 | 2,3 | 33,3 | 42,5±6,8 |
| Хэнтий | 10,6 | = | 24,9 | 35,6±7,8 |
| Сүхбаатар | 6,8 | 6,8 | 30,9 | 44,7±8,5 |
| Завхан | 18,4 | 3,0 | 30,7 | 52,3±8,7 |
| Дунджаар | 14,9±1,9 | 3,5±0,6 | 20,6±1,4 | 39,1±2,0 |

Хүснэгт 1-ээс харахад зүрхний хэлбэр дүрсийн янз бүрийн өөрчлөлт аймгуудад харилцан адилгүй түвшинд, бас ч цөөнгүй тохиолдож байна. Энэ нь дан ганц цээжний эгц зургаар уг асуудалд хан-

даж байгаатай (судалгааны аргачиллын өрөөсгөл тал) холбоотой боловч үзүүлэлтүүд нэлээд өндөр, аймгуудаар харилцан адилгүй янз бурийн түвшинд байгаа нь сонирхол татах байна. Тухайлбай; Эрдэнэт, Ховд, Завхан, Сүхбаатар, Баянхонгор аймгуудад уг үзүүлэлтүүд нэлээд өндөр харагдаж байхад Булган, Налайх, Дорноговь аймгуудад бага байна. Залуу насы эрэгтэйчүүдэд митраль гажгийн хэлбэр бүхий өөрчлөлт дунджаар 14,9 промиль ($\pm 1,9$), гол судасны гажгийн хэлбэртэй—3,5 промиль ($\pm 0,6$), хоёр ховдлын томролтой 20,6 промиль ($\pm 1,4$) тохиолдож, нийтдээ 39,1 промиль ($\pm 2,0$) байна.

УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ 1. Олноор нь флюор зураг авах шинжилгээгээр зүрхний хэлбэр дүрсийн өөрчлөлтийг тогтоох нь зүрхний гажгууд, түүний гол шалтгаан-хэрлэгийн өвчлөлийг аймгуудаар жишиг үзүүлэхэд ач холбогдолтой мэт санагдлаа.

2. Энэ өөрчлөлтүүд харьцаангуйгаар «коо эрүүл» байх ёстой залуу насы эрэгтэйчүүдэд нэлээд тохиолдож байгаа нь зүрх судасны эмгэг гажгууд үүний дотор хэрлэгийн өвчлөлийг, эдгээр насы хүмүүсийн дунд тодорхой хэмжээгээр байгаа болов уу гэх үндэстэй байна.

3. Эдгээр үзүүлэлтийг залуу насы эрэгтэйчүүдийн дунд зүрх судасны эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион явуулахдаа харгалзан үзэж болох юм.

4. Олноор флюор зураг авах шинжилгээгээр зүрхний өөрчлөлт бүхий гарсан хүмүүсийг түүврэлэн авч нарийн шинжилгээнд оруулж байх нь зүйтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. П. Я. Бобылов, Ч. Цэрэннадмид—Клинические лекции по внутренним болезням. УБ. 1984.
2. В. Н. Дзяк, И. И. Крыжановская—Ревматизм и приобретенные пороки сердца, „Здоровья“ Киев. 1982.
3. В. Зодиев—Флюорография как метод выявления сердечнососудистых заболеваний при групповых исследованиях. М. 1950.
4. Г. П. Матвеевов, С. С. Пшоник, В. К. Милькаманович—„Ревматизм“. Белорусь. 1979.

РЕЗУЛЬТАТЫ ПРЕДВАРИТЕЛЬНОГО ИЗУЧЕНИЯ РАСПРОСТРАНЕННОСТИ СЕРДЕЧНОЙ ПАТОЛОГИИ СРЕДЫ МОЛОДЫХ МУЖЧИН ПО ДАННЫМ МАССОВОГО ФЛЮОРОГРАФИЧЕСКОГО ОБСЛЕДОВАНИЯ

З. Мэндсайхан, С. Балгансурен, В. В. Митин, Р. Цэвэлма

Авторами изучена распространенность сердечной патологии по данным массового флюорографического исследования в условиях МНР. Установлено, что „митральная“ конфигурация сердца составляет в среднем 14,9%, „аортальная“—3,5%, увеличение обойх желудочков 20% о. Таким образом из общего числа обследованных патологические изменения конфигурации сердца выявлены у 39,1%о.

Несмотря на недостаточную информативность флюорографического метода для определения конкретной нозологической формы заболевания, тем не менее он дает возможность судить об общих признаках патологии сердца. Поэтому авторы сочли возможным использовать этот метод и впервые сделали попытку определить частоту тех или иных изменений конфигурации сердца у молодых лиц в различных аймаках и городах МНР, которые важны для проведения лечебно-оздоровительных мероприятий.

Редакций ирсэн 1986.01.21.

Ё. Думаа, Ш. Чадраавал, Д. Эржэн (*Анагаах ухааны хүрээлэн*)

ЗҮРХНИЙ ЦУС ТАСАЛДАХ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСИЙН ЛИПИДИЙН СОЛИЛЦООНД ЭМЧИЛГЭЭНИЙ ХООЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Зүрх судасны өвчин аль ч оронд төдийлөн буурахгүй, харин ч өндөр хөгжилтэй оронд нэмэгдэх хандлагатай байна (5,6).

Зүрх судасны өвчнүүд болон ялангуяа зүрхний цус тасалдах өвчин үүсэх үндсэн шалтгаан нь бие махбодын өөх тосны солилцооны өөрчлөлттэй холбоотой болохыг олон судлаачид тогтоогоод байна (2, 4, 5). Иймээс зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх оношлоход гиперлипопротеидемийг (липопротеидын хэт ихсэлт) илрүүлэх нь чухал юм (2, 4). Зөвхөн гиперлипопротеидемийг ч биш, липид, липопротеид (ЛП)-ын солилцооны өөрчлөлттэй холбоотой үүсэх молекулын өвчин болох дислипопротеидемийг судлах нь клиникийн чухал ач холбогдолтой юм (5, 6).

Зүрхний цус тасалдах өвчний үүсэх шалтгаан нь өөх тосны солилцооны харьцааны өөрчлөлттэй холбоотой байгаа учраас түүнд нөлөөлэх хүчин зүйл нь:

1. Хоногт хэрэглэх хоолоо тодорхой дэглэмгүй, илчлэгийн хэмжээг хэтрүүлэн хэрэглэснээс биеийн жин хэт ихээр нэмэгдэж таргалах (2, 3).
2. Амьтны гаралтай өөх тосыг тогтмол их хэмжээгээр хэрэглэх
3. Биеийн хүчин багаар шаардагдах, хөдөлгөөн багатай, ялангуяа оюуны хөдөлмөр голлон эрхэлдэг хүмүүсийн дунд элбэг тохиолдож байна (1.5).

Иймээс зүрхний цус тасалдах өвчнийг эмийн эмчилгээнээс гадна өдөр тутам хэрэглэх хоолны найрлагын тохироог зохицуулж эмчилж байна (2.3).

Зүрх судасны аливаа өвчний үед гарах липидийн солилцооны өөрчлөлт, хоол тэжээлийн онцлогоос болж, хэрхэн өөрчлөгдөж байгааг судалсан судалгааны ажил одоогоор манай оронд хийгдэгүй байна. Харин монгол хүмүүсийн липидийн (өөх тосны) солилцооны үзүүлэлтийг С. Ямаахай судалсан [6].

Иймээс бид уг судалгааны ажлыг Оргил рашаан сувилал, Улаанбаатар хотын клиникийн төв эмнэлгийн зүрх судасны тасгийг түшиглэн 1985—1986 онд хийв.

Судалгааны арга зүй, үр дүн

Бид судалгаандаа:

1. Оргил сувилал болон клиникт эмчлүүлэн сувилуулахаар ирсэн хүмүүсийн цусны сийвэнд хоолны эмчилгээний өмнө ба дараа нийт холестерин (nХС), триглицерид (ТГ), нягтралтай липопротеидын холестерин (ИНЛП—ХС), маш бага нягтралтай липопротеидын холестерин (МБНЛП—ХС), бага нягтралтай липопротеидын холестерин (БНЛП—ХС)—(Фредриксоны гиперлипопротеидемийн энэ ангиллыг 1970 онд ДЭХБ-аас хүлээн авч, дэлхийн олон улсын эрүүлийг хамгаалахын практикт тусгагдан хэрэглэгдэж байна)-ийг 120 дээжинц давталттайгаар тодорхойлов.

2. Сувилал, клиникийн нөхцөлд хэрэглэж байсан бодит хоолны (сувилал, клиникт урьд нь өгч байсан хоол) өөх тосны найрлагыг тооцоолон гаргасны үндсэн дээр тосны ханаагүй хүчлээр баялаг хүнсний бүтээгдэхүүн нэлээд хэмжээгээр оролцуулсан, тосны ханамал хүчлийг багасгасан туршилтын хоолны жор гарган 20—21 хоног хэрэглүүлсний дараа үр дүнг өвчтөнүүдийн цусны сийвэнгийн липидийн солилцооны үзүүлэлтээр гаргав.

3. Судалгаа явуулсан сувилал, клиникт хэрэглэж байсан бодит

хоол, өөрсдийн зохиосон жороор туршилтын хоолны химийн найрлагыг тодорхойлов.

Өвчтөний цусны сийвэнгийн липидийн солилцооны үзүүлэлтүүдийг (нХС, ТГ, ИНЛП—ХС, БНЛП—ХС, МБНЛП—ХС) ЭЗХТЗ гишүүн орнуудын мөрдэж буй дислипопротеидемийг илрүүлэх аргачлалын дагуу хийсэн болно.

Бид хоолны эмчилгээнд цусны холестерин, триглицеридыг бууруулах үйлчлэл бүхий тосны ханаагүй хучил линол, линолеины хүчлийг ихээр агуулдаг наранцэцгийн тосыг хоногт 50 гр-аар бодож өвчтөний хэрэглэж буй 1 дүгээр хоолны шөл, тарганд хийж сайтар хутгаж өгсөн болно.

Судалгааны дүн

1. Судалгаанд авсан зүрхний цус тасалдах өвчтэй хүмүүсийн цусанд нийт ХС, ТГ, ИНЛПХС, МБНЛПХС-ийг хоолны эмчилгээнд өмнө тодорхойлоход: нийт ХС— $6,71 \pm 0,24$ м. моль/л; ТГ—1, $69 \pm 0,33$ м. моль/л; ИНЛПХС—1, $99 \pm 0,20$ м. моль/л; БНЛПХС—2, $88 \pm 0,31$; МБНЛП— $0,35 \pm 0,067$ м. моль/л, хоолны эмчилгээний дараа: Нийт ХС— $5,63 \pm 0,19$ м. моль/л; ТГ— $1,59 \pm 0,19$ м. моль/л, ИНЛПХС $1,85 \pm 0,10$ м. моль/л; БНЛПХС $2,49 \pm 0,23$ м. моль/л; МБНЛПХС $0,34 \pm 0,044$ м. моль/л хэмжээтэй байв. Одоо эдгээр үзүүлэлтийг гадаадын судлаачдын судалгаатай (1-р хүснэгтэнд) харьцуулан үзье.

Хүснэгт 1-ээс харахад бидний судалгаанд авсан хүмүүсийн цусны сийвэнгийн нийт ХС, ТГ-ийн хэмжээ С. Ямаахайн гаргасан зүрх судасны өвчингүй гэж оношлогдсон монгол хүмүүсийн липидийн солилцооны үзүүлэлтээс нэлээд их байгаа боловч хоол эмчилгээний дараа нийт ХС—16,1 хувь, ТГ—6 хувь тус тус буурсан байна. Зүрхний цус тасалдах өвчтэй хүмүүсийн нийт ХС-ийн хэмжээ өвчлөлийн эхэн үе буюу хурц үед $8,35 - 9,05$ м. моль/л хурч байсан. Гэхдээ бид дан хоолны эмчилгээгээр эмчлэх зорилго тавьсан учраас хэт хүнд өвчтөн сонгож авах боломжгүй байсан юм. Нэгэнт зүрхний цус тасалдах өвчний архаг хэлбэрийг сонгосон учир хоол эмчилгээний өмнө нХС, ТГ-ийн хэмжээ хэт өндөр биш байлаа. Туршилтын хоолыг өгснөөр ИНЛП—ХС төдийлөн буурахгүй байгаа нь эмчилгээний үр дунтэй болох нь харагдлаа. (ИНЛП—ХС-ний хэмжээ буурахгүй байх нь зүрх судасны өвчинүүдийн үед ач холбогдолтой байдаг).

2. Судалгаа явуулсан сувилал, клиникин эмнэлэгт сувилуулан эмчлүүлж буй зүрх судасны өвчтэй хумууст зориулан өгч байсан бодит туршилтын хоолны нийт липид, ТГ, Фосфолипид, ХС, тосны ханасан ба ханаагүй хүчлийн хэмжээг тооцоолон үзэж харьцуулсан дүнг гаргав.

Бид туршилтын хоолны жорыг боловсруулахдаа: Сувилал, клиникт хэрэглэж байгаа бодит хоолны найрлагыг урьдчилан тооцоолсны үндсэн дээр зүрхний цус тасалдах өвчний онцлогт тохирсон туршилтын хоолны жор гарган, мөн найрлагын тохироог зохицуулсан юм.

Бид голлон тосны ханаагүй хүчлийн орцыг нэмэгдуулэх зарчмыг баримталсан бөгөөд тосны олон, цөөн тоот ханаагүй хучил бие махбодод нөөцлөгдөн хуримтлагддаггүй, бодисын солилцоонд түргэн хугацаанд орж задардаг онцлогтой байдаг.

Туршилтын хоолны ханасан тосны хүчлийг бодит хоолныхоос 30,9 хувиар бууруулж, тосны нийт ханаагүй хүчлийг 41,8 хувь, тосны олон тоот ханаагүй хүчлийг 54,5 хувь, цөөн тоот тосны ханаагүй хүчлийг 25,1 хувь тус тус нэмэгдуулсэн болно.

Хүснэгт 3-т тосны олон тоот ханаагүй хүчлүүдийг бодит байтуршилтын хоолонд байх хэмжээг тооцоолон үзэхэд: Туршилтын хоолонд уг хүчлүүдийн эзлэх хувийг 3,0—10,6 хувиар нэмэгдуулсэн бай-

Зүрхний цус тасалдах өвчтэй хүмүүсийг эмчилгээний хоолоор
эмчлэн липидийн солилцоог тодорхойлсон дүнг гадаадын судлаачдын
судалгааны дүнтэй харьцуулбал:

| | Липид | Цусны сийвэнд агуулагдах липидын хэмжээ (м.моль.л) | | | | | |
|--|---|--|----------------------------|------------------------------------|--------------------------------------|--|-----------------------------|
| | | Нийт холестерин $M \pm m$ | Триглицерид $M \pm m$ | Их нягтралтай ЛпХС $M \pm m$ | Бага нягтралтай ЛпХС $M \pm m$ | Маш бага нягтралтай ЛпХС $M \pm m$ | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
| Эмчилгээний хоолны өмч | Бидний судалгаагаар | 6,71 ± 0,24 | 1,69 ± 0,33 | 1,99 ± 0,20 | 2,88 ± 0,31 | 0,35 ± 0,067 | |
| | М.А. Самсонов И.А. Фролова | 6,497 ± 0,083 | 1,65 ± 0,028 | 1,30 ± 0,016 | 4,454 ± 0,070 | 0,744 ± 0,023 | |
| | В.А. Мещерякова, М.А. Самсонов (гиперхолестеринемийн үед) | 9,7 ± 0,39 | 1,80 ± 0,10 | 1,80 ± 0,03 | 7,0 ± 0,3 | 0,79 ± 0,04 | |
| Эмчилгээний хоолны дарзаа | Бидний судалгаагаар | 5,63 ± 0,19 | 1,59 ± 0,19 | 1,85 ± 0,10 | 2,49 ± 0,23 | 0,34 ± 0,044 | |
| | М.А. Самсонов И.А. Фролова | 6,125 ± 0,075 | 1,37 ± 0,034 | 1,295 ± 0,018 | 4,209 ± 0,073 | 0,62 ± 0,022 | |
| | В.А. Мещерякова М.А. Самсонов | 7,6 ± 0,28 | 1,3 ± 0,09 | 1,6 ± 0,03 | 5,4 ± 0,30 | 0,57 ± 0,04 | |
| С. Ямаахайн зүрхийн шишжилгээгээр зүрхний өвчингүй гэсэн оноштой монгол хүмүүсийн липидийн со- лилцооны дун- даж үзүүлэлт) | эрэг- тэй (зүрх, судасны өвчтэй хүмүү- сийг илрүүлэх шишжилгээгээр зүрхний өв- чингүй гэсэн оноштой мон- гол хүмүүсийн липидийн со- лилцооны дун- даж үзүүлэлт) | 40—59 нас | 5,60 ± 0,04 5,60 ± 0,05 | 0,89 ± 0,03 0,94 ± 0,03 | 1,26 ± 0,07 1,66 ± 0,04 | 2,83 ± 0,17 3,11 ± 0,30 | 0,40 ± 0,008 0,43 ± 0,02 |
| | Эмэг- тэй | 40—59 нас | 5,39 ± 0,04 5,63 ± 0,06 | 0,91 ± 0,04 0,94 ± 0,04 | 1,83 ± 0,06 1,83 ± 0,08 | 2,48 ± 0,15 3,14 ± 0,13 | 0,35 ± 0,025 0,43 ± 0,01 |

на. Ялангуяа арахилон, линол, линолейны хүчлүүдийг хэзээ ч орлуулж болшгүй бодист тооцдог.

Эдгээр бодис нь бие махбодын эсийн мембранны хамгийн идэвхтэй хэсэгт оролцохос гадна бодисын солилцоог зохицуулж улмаар холестерины хэсэгчилсэн солилцоонд нөлөөлж, гиперхолестеринеими үед холестерины хэмжээг бууруулах нөлөөтэй байдаг. Энэ хэрэгцээг

Xүснэгт 2

Сувилал, клиникин нөхцөлд хэрэглэсэн бодит ба туршилтын хоолны липидүүд, тосны ерөнхий ханаагүй хүчлийн харьцаа (хоногийн хоолонд агуулагдах хэмжээ мг-аар)

| Липидийн үзүүлэлт | Нийт липид | | | | | | | | |
|--------------------------------|------------------|------------------|----------------|-----------------|------------------|-----------------|-----------------|-----------------|---|
| | M ± m | M ± m | M ± m | M ± m | M ± m | M ± m | M ± m | M ± m | |
| Эмчилгээний хоолны ширээ | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. Бодит хоол Ширээ № 10 | 95,77 ± 10,65 | 88,46 ± 10,13 | 3,87 ± 0,53 | 0,37 ± 0,037 | 86,03 ± 11,99 | 27,24 ± 8,32 | 7,61 ± 1,84 | 24,66 ± 9,34 | |
| Туршилтын хоол Ширээ № 10с | 59,72 ± 2,92 | 45,26 ± 10,65 | 3,70 ± 1,46 | 0,40 ± 0,033 | 59,39 ± 18,23 | 46,83 ± 5,82 | 16,72 ± 7,37 | 32,88 ± 4,76 | |

Xүснэгт 3

Бодит болон туршилтын хоолны ханаагүй тосны хүчлийн хэмжээ (хоногийн хоолонд агуулагдах хэмжээ-мг)

| Тосны ханаагүй хүчлийн бүрэлдэхүүн | Тосны ханаагүй хүчлийн хэмжээ (мг-аар) | | | | | |
|---|--|----------------------|---------------------------|----------------------------|-------------------|--------------------|
| | Линолын хүчил | Линолей- ны хүчил | Арахи- доны хү- чил | Мипис- толейны хүчил | Пальме- толейн | В. сито- стерон |
| Эмчилгээний хоол | M ± m | M ± m | M ± m | M ± m | M ± m | M ± m |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Бодит хоол Ширээ № 10 | 1,33 ± 0,11 | 0,28 ± 0,017 | 0,11 ± 0,071 | 0,53 ± 0,072 | 1,82 ± 0,18 | 0,036 ± 0,04 |
| Туршилтын хоол Ширээ № 10 | 12,6 ± 0,79 | 0,37 ± 0,079 | 0,30 ± 0,076 | 0,60 ± 0,16 | 1,98 ± 0,50 | 0,12 ± 0,057 |

Хангахын тулд линолын хүчлийг хамгийн ихээр агуулдаг наранцэгийн ба эрдэнэшишийн тос, маргарин зэргийг тогтмол хэрэглэх нь чухал юм. Зүрхний цус тасалдах, судас хатуурах, цусны даралт их-сэх зэрэг өвчний хурц үед цусны холестерини хэмжээ эрс нэмэгддэг снцлогтой. Иймээс бид эмчилгээний хоолоор цусан дахь холестерини хэмжээг бууруулах зорилго тавьж, судалгааны эцэст зүрхний цус тасалдах өвчтэй хүмүүсийн холестерини хэмжээ 16,1%-иар буурсан болно.

Бид мөн судалгааны явцад бодит ба туршилтын хоолны химийн найрлагыг хавар, намрын улирлаар тодорхойлж тооцоолон гаргав.

Бодит ба туршилтын хоолны химийн найрлага

| № | Хэрэглэсэн хоол | Хоолны химийн найрлага | | | |
|---|-----------------|---------------------------|------------------------------|------------------------------|--|
| | | Уураг (г) $M \pm m$ | Өөх тоос (г) $M \pm m$ | Нүүрс ус (г) $M \pm m$ | Илчлэг кдж $M \pm m$ |
| 1 | Бодит хоол | 98,1±8,79 | 82,4±6,21 | 480,1±17,9 | 31372±168,3 ккал 13176,24±168,3 кдж |
| 2 | Туршилтын хоол | 102,4±27,9 | 87,7±28,0 | 420,4±29,3 | 2968,3±356,4 ккал 2466,86±356,4 кдж |

Дүгнэлт 1. Тосны олон тоот ханаагүй өөхний хүчлээр баялаг наранцэцгийн тосыг эмчилгээний зориулалтаар тогтмол хэрэглэхэд дусны сийвэнгийн холестерин, триглицеридийг бууруулах үйлчлэлтэй байна.

2. Наранцэцгийн тосыг зүрхний цус тасалдах өвчтэй хүмүүст хэрэглэхэд цусны сийвэнгийн холестерин, триглицеридийн хэмжээг бууруулахын зэрэгцээ их нягтралтай липопротеидийн холестериний хэмжээг бууруулахгүй хэвийн хэмжээнд байлгаж байгаа нь эмчилгээний үр дүнг сайжруулах нэг чухал хүчин зүйл болж байна.

3. Зүрх судасны өвчтэй хүмүүст хэрэглэх хоолны найрлаганд амьтны гаралтай тос, нүурс усны хэмжээг багасгах нь тухайн өвчний үед хэрэглэх хоолны эмчилгээний үр дүнг дээшлүүлж байгаа нь бидний судалгаанаас харагдлаа.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Ф. И. Комаров, Б.Ф. Коровкин, В.В. Меньщиков — Биохимические исследования в клинике Л. „Медицина“ 1981. 175, 186, 189, 196.
2. В.А. Мещерякова, М.А. Самсонов и др — Значение применения алиментарного фактора в профилактике и лечении ишемической болезни сердца. Тер. арх. 1985. 10. 14—19.
3. Б.Л. Смолянский, Ж.И Абрамова — Справочник по лечебному питанию для диетсестер и поваров. Л. „Медицина“ 1984. 16—19.
4. М.А. Самсонов, И.А. Фролова и др — Против атеросклеротическая диета у больных ишемической болезнью сердца. Клиническая медицина. 1981. 11. 29—35.
5. Под. ред. Е.И. Чазова, А.Н. Климов — Дислипопротеидемии и ишемическая болезнь сердца М. „Медицина“ 1980. 26—120.
6. С.Ямаахай — Монгол хүний липидын солилцооны үзүүлэлт УБ. 1987.

ВЛИЯНИЕ ДИЕТОТЕРАПИИ НА ЛИПИДНЫЙ ОБМЕН
БОЛЬНЫХ ИШЕМИЧЕСКОЙ БОЛЕЗНЬЮ СЕРДЦА

Ё. Дума, Ш. Чадравал, Д. Эржэн

Авторами исследовано состояние фактического лечебного питания больных ишемической болезнью сердца в сочетании с ожирением в санаторно-курортных и стационарном условиях.

Проведена коррекция лечебного питания на оснований обогащения рационов жирами растительного происхождения, что дало положительный результат в улучшении биохимических показателей крови больных данного контингента.


Редакций ирсэн 1987.03.31

ЭЛЭГНИЙ ШИНЖ ТЭМДГИЙН ПОРФИРИ ӨВЧИН БҮХИЙ ГЭР БҮЛ

Элэгний архаг порфири өвчин (*Porphyruria cutanea tarda*) нь порфири өвчний өргөн бүлэгт хамарагдах бөгөөд арьс амархан шалбарах, цэврүүтэх, арьсны ил хэсэгт нөсөөжилт ихсэх, гуужих зэрэг шинж тэмдгээр илэрдэг. Энэ өвчний уед уропорфирийн декарбоксиаза ферментийн идэвх, төрөлхийн тажиг эсвэл гаднын янз бүрийн хүчин зүйлийн (согтууруулах ундаа, дотоод шүүрлийн найрлагатай эм их хэрэглэх, элэгний янз бүрийн өвчин г. м.) нөлөөгөөр элтэнд багасч хэвийн нөхцөлд бие махбодод маш бага хэмжээгээр ялгарч байсан порфирийн их хэмжээгээр ялгаран хуримтлагдаж элэг, арьсыг гэмтээж эхэлдэг байна.

Материал, арга. Эпидемиологи судалгааны явцад нэгэн эмэгтэй

Элэгний шинж тэмдгийн порфири өвчин бүхий гэр бүлийн хэлбэр илэрсэн байдал



— Клиникээр илэрсэн тохиолдлууд



— Клиникээр илрээгүй тохиолдлууд



— Биохимийн сөрөг илрэлтэй



— Шинжилгээнд хамрагдаагүй

Үр дүн

Порфири өвчинтэй болохыг нь анх оношлосон 33 настай албан хаагч эмэгтэйг П/5 гэсэн тэмдгээр

томъёолсон бөгөөд түүнд гипертрихоз, арьс цэврүүтэх, шалбарах, нөсөөжилт ихсэх шинж тэмдгүүдээс гадна АЛАТ—0,5; АСАТ—0,8;

НbsA сөрөг, плазм дахь нийт порфирийн 10,67 микрогр./л (нормдоо 0,8 хүртэл); шээсэн дэх нийт порфирийн 2338 микро гр./л (нормдоо 200 хүртэл) байлаа. Цус авах болон делагилийг 125 мг-аар долоо хоногт хоёр удаа уух эмчилгээг хийсний дунд жилийн дараа арьсаар гарах шинж тэмдгүүд угүй болж, өлөн элэгний шээсэн дэх нийт порфирийн 417 микрогр./л болтлоо буурчээ. Дээр дурдсан өвчтөн эмэгтэйн ахад (П/3) арьсны клиник шинж тэмдэг илэрхий байсан боловч шээс, цусны шинжилгээ өгөөгүй юм. Түүний охин (Ш/13) 12 настай. 9 настай байхад нь арьс цэврүүтэх, шалбараах, нөсөөжих, гипертрихоз шинж тэмдгүүд илэрч, порфирийн өвчин мөн болохыг оношилсон учир цус авах болон витаминаар эмчилсэн нь сайн үр дүнтэй болсон байна. Судалгааны үеийн шинжилгээгээр плазмын нийт порфирийн 4,12 микрогр./л, шээсний нийт порфирийн 380 микрогр./л, АЛАТ—0,8, АСАТ 0,9 байв.

Энэ өвчтөнүүдийн ах (П/3) 41 настай малчин, хоёр удаа халдварт гепатитаар өвчилсөн, гучин настайд нь арьс цэврүүтэх, шалбараах, шээсний өнгө улайлз зэрэг шинж тэмдэг илэрч, цус ханах, барагшин уух, витамин эмчилгээ хийлгэж байжээ. Судалгааны үед плазмын нийт порфирийн 825 микрогр./л, АЛАТ 0,54, АСАТ 0,59 байснаас гадна элэг нь баруун хавирганаас доош хоёр хуруу дор тэмтрэгдэж байлаа.

Нэгдүгээр (1) үеийнхэнд хийсэн шинжилгээгээр 1/1-ийн шээсэнд нийт порфирийн 793 микрогр./л, 1/3-ын шээсэнд 1085 микрогр./л, 1/4-ийн плазмын нийт порфирийн 21,4 микрогр./л болох нь тодорхойлогдлов.

Дүгнэлт. Энэ шинжилгээнд нэг тэр бул, садан төрлийн 30 хүн хамрагдсан бөгөөд үүнээс 8 хүн (27,6%) элэгний шинж тэмдгийн порфири өвчтэй болохыг оношлов. Дээрх 8 хүний 4-д клиник шинж тэмдэг илэрхий байлаа. Үүнээс үндэслэн нэг гэр булийн дотор элэгний шинж тэмдгийн порфири өв-

чин доод зах нь хоёр удаа илрэх тохиолдолд гэр бүл, садан төрлийн бусад гишүүнд зохих шинжилгээ хийж, уг өвчний клиник шинж тэмдэггүй тохиолдол байж болзолшгүйг шалган тогтоож байх нь зүйтэй. Ингэснээр уг өвчнийг элэгний хатингарал, хорт хавдар зэрэг хүндрэлт хэлбэрт хүрэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. *Berman J. Porfiricka choroba Praha 1960*
2. *Kordac V. „Porfirie v klinice praxe“ (Thomayerova sbirka s. 43—96, Praha, Avicenum 1978)*
3. *Kordac V. et al: „Chlorochin v lecbe symptomaticke jaterni porfirie-souhru dvanactiletich zkusenosti u 307 pacientu“ (Casopis lek. ces. c. 120 s. 1225—1227, Praha 1981)*
4. *Grossman M. E., Bickers D. R., Poh —Fitzpatrick M. B. et al: „Porfiria cutanea tarda. Clinical features and laboratory findings in 40 patients“ (Amer. Jour. Med. 67, 1970 s 277—286)*
5. *Kalab M., Kollarova J., Cervinka J. et al: „Symptomaticka jaterni porfyrie s familiarnim vyskytem“ (Casopis lek. ces. c. 124 s. 715—720, Praha 1985)*
6. *Martasek P., Jirska M., Kordas. V. „Porphyrinogens in plasma“ (Arch. Derm. N 118, s. 624—625.)*
7. *Кузнецова Н. П. и др. „Порфирии“ Москва 1981*

СЕМЕЙНЫЕ СЛУЧАИ

СИМПТОМАТИЧЕСКОЙ ПЕЧЕНОЧНОЙ ПОРФИРИИ

Г. Энхдолгор, П. Мартасек, В. Кордач

В большинстве случаев с симптоматической печеночной порфирией приходится встречаться как с приобретенным заболеванием, встречающимся спорадически. Наряду с этой формой приходится наблюдать семейную форму заболевания, наследственность которой носит аутосомно-домinantный характер.

В данном исследовании определялись клинические и биохимические параметры заболевания в семье с семейными случаями симптоматической печеночной порфирии. На основании исследования экскреции порфиринов с мочой, определения концентрации плазматических порфиринов диагноз заболевания можно поставить уже в доклинической стадии у бессимптомных носителей и таких образом предупредить развитие цирроза печени или вээнкнове-

ние первичного рака печени. Было обследовано 30 членов семьи трех поколений. У 4 лиц было установлено заболевание с клиническим проявлением, у че-

тырех пробандов имело место бессимптомная форма заболевания.

Редакция 1987.02.26

Л. Сюунцэцэг, Т. Гомбосурэн (*Анагаах ухааны хүрээлэн*)

В ГЕПАТИТЫН ЭПИДЕМИОЛОГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Сүүлийн жилүүдэд В вируст гепатитын ахуйн замаар халдвартлах онцлогийг судлах явдал судлаачдын анхаарлыг ихэд татаж байна. (1, 2, 6).

Манай орны хүн амын дунд В вируст гепатитын гадаргуугийн эсрэгтөрөгч агуулагчид 9,3% хүртэл байгаа нь (3,7). В вируст гепатит ахуйн замаар халдах нэг хүчин зүйл болж болзошгүй тул бид энэ судалгааг хийсэн юм.

МАТЕРИАЛ БА АРГА: Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэг төрөгч (HBsAg) давтан илэрсэн 10 голомтын 61 хүнд эпидемиологийн ажиглалт явуулж, тэдгээрээс 50 хүнд (эх 6, эцэг 4, хүүхэд 37, ойр дотны хүн 3) биохимиийн болон иммунологийн шинжилгээ хийв. HBsAg-ыг Гельд тундасжуулах аргаар тодорхойлов. Үүнээс гадна Улаанбаатар хотын Халдварт өвчний анагаах клиникийн эмнэлэгт эмчлүүлж буй 88 өвчтөнд эпидемиологийн судалгаа, ретроспектив аргаар 13 өвчтөн, түүний 43 хавьтальд халдварт судлалын судалгаа, биохими, иммунологийн шинжилгээ хийв.

АЖИГЛАЛТЫН ДҮН: HBsAg давтан илэрсэн 9 голомтын 50 хүнд биохими иммунологийн шинжилгээ хийхэд 5 голомтын 38 хүнээс 8/21%-д нь HBsAg дахин илрэв. HBsAg эерэг хүмүүсийн 4 нь HBsAg байнга тээгч эх, 4 нь 4 сартайгаас 11 насты эмэгтэй хүүхдүүд байв. HBsAg тээгч эдгээр 8 хүний 7-д нь тимол, Алат, АсаT-ын сорил өөрчлөлттэй байгаа нь HBs Ag-ыг байнга тээгчдэд элэгний үрэвсэлт процесс явагдаж буйг харуулж байна. HBsAg эерэг 5 голомтын 1-д нь 1 удаа, 2-д нь 2 удаа, 2-д нь 5 удаа вируст гепатитын өвчлөл янз бүрийн хугацаанд гарч

HBsAg тээгч эх, хүүхдийн хамт байсан 38 хүнээс 15 (39,5%)-нь вируст гепатитаар өвчилжээ. Эдгээр өвчлөгчдийн 2 нь HBsAg эерэг байв. HBsAg эерэг голомтын 1-д нь 3 хүнээс, 1-д нь 2 хүнээс, 3-д нь 1 хүнээс тус тус HBsAg илэрч байлаа.

Мөн ретроспектив аргаар судалгаа хийсэн 13 өвчтөнтэй хавьтальд орсон 43 хүний ийлдсэнд HBsAg илрээгүй боловч эдгээр голомтонд вируст гепатитын өвчлөл янз бүрийн хугацаанд хоёр ба түүнээс дээш удаа гарч байсан байна.

Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэгт эмчлүүлж буй 88 өвчтөний 36 (40,9%) нь А гепатит оноштой, 52(59,1%) нь В гепатит оноштой байв. А гепатитаар өвчлөгчдийн дотор нууц үеийнхээ хугацаанд эмнэлгийн ямар нэгэн парентерал үйлдэлтэй, өвчний хавьтальтай, HBsAg эерэг илэрсэн өвчтөн 8 (22,2%), В гепатитаар өвчлөгчдөөс нууц үеийнхээ хугацаанд эмнэлгийн ямар нэгэн парентерал үйлдэлгүй, гэр, хэрш, ажлын газартаа өвчний хавьтальгүй атлаа HBsAg эерэг 18 (34,6%) өвчтөн байлаа. Эмнэлгийн нөхцөлд ямарч парентерал эмчилгээ хийлгээгүй, зөвхөн гэрээр парентерал эмчилгээ хийлгэсэн 8 (9,1%) байв.

ХАРЬЦУУЛСАН ДУГНЭЛТ: Ахуйн нөхцөлд HBsAg тээгч эх нь халдвартараах аюулаар их байхаас гадна хүүхэддээ уг өвчинг тараахдаа HBsAg агуулагч эцгээс 4 дахин илүү байдаг гэсэн С. Н. Цыбулякын (4) судалгаатай бидний ажиглалт тохирч байна. Судалгаагаар илэрсэн HBsAg тээгчид бүгд эмэгтэйчүүд байгаа нь В гепатитын халдварт агуулагч эх, тэдгээрийн хүүхдүүд В гепатит

тараахад голлох үүрэгтэйг харуулж, архаг гепатиттай өвчтөн, HBsAg тээгч нь халдвартархаа хад тодорхой үүрэг гүйцэтгэж байгааг илрүүлсэн нь зөвлөлтийн судлаачдын дүнтэй (5) дүйж байна.

Нэг голомтод HBsAg агууллагч 1—3 хүн байгаа нь В гепатит гэр ахуйн замаар халдах эх уурхай цөөнгүй байдгийг харуулж байна. Эмнэлгийн нөхцөлд ямар нэгэн парентерал эмчилгээ, үйлчилгээ хийлгээгүй зөвхөн гэрээр парентерал эмчилгээ хийлгэсэн өвчтөн болон өвчинийхөө нууц үеийн хугацаанд эмнэлгийн ямар нэгэн парентерал үйлдэлгүй, гэр, хөрш, ажлын газартаа өвчиний хавьтальгүй атлаа HBsAg ээрэг өвчтөн цөөнгүй байгаа нь эдгээр өвчтөнүүдийн халдвартын эх уурхайг гэр орон болон ойр дотны хавьтагсдаас илрүүлэх судалгаа шинжилгээг гүнзгийрүүлэн хийх шаардлага тайг харуулж байна.

А вируст гепатит оноштой өвчтөний дотор HBsAg тээгчид цөөнгүй байгаа мөн В вируст гепатит оношийн дор А вируст гепатит баагүй тохиолдож байгаа нь ялгах оношлогоог сайжруулахын чухлыг харуулж байна.

Цаашид В вируст гепатит ахуйн замаар халдах онцлогийг орчин үеийн өндөр мэдрэг аргаар нарийвчлан судлах нь уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замыг улам тодорхой заан өгч болох юм.

ДҮГНЭЛТ—Вируст гепатит өвчиний голомтод түр ба удаан хугацаагаар HBsAg агууллагчид цөөнгүй тохиолдож байна.

— HBsAg агууллагч эмэгтэйчүүд нь гэр бүлийнхээ гишүүдэд В вируст гепатитын халдварт

М. Дарьсурэн, Т. Варламова. Д. Дамдин (*Ардын эмнэлгийн хүрээлэн*)
Ц. Готов (*Улсын багшийн дээд сургууль*)

ДЕНДРОНИЗИД ЭМИИН КЛИНИК ТУРШИЛТ

Гадаад орчны төрөл бүрийн тааламжгүй үйлчлэлд бие махбодын тэсвэрлэх чанарыг дээшлүүлэх явдал чухал юм.

раагч гол эх уурхай болж байна.
— В вируст гепатит нь парентерал замаас гадна ахуйн замаар цөөнгүй дамжин тархаж байна.

— В вируст гепатит гэр ахуйн нөхцөлд хувийн зүү шприцээр дамжин парентерал замаар халдаж байна,

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Т. Т. Волохович, Ю. Н. Мастюкова, В. С. Кривицкая и др.—Эпидемиологическая значимость различных категорий носителей поверхностного антигена гепатита В. ЖМЭИ. 1981. З. 73—78.
2. Б. А. Герасун—Естественные пути распространения вирусного гепатита В. ЖМЭИ. 1984. 2. 12—15.
3. Л. И. Трофимова, Э. Пурэвдалаа—Частота выявления HBs Ag у больных вирусным гепатитом в межэпидемический и эпидемический периоды инфекционного гепатита. (Сборник тезисов докладов) 1980. 50.
4. С. Н. Цыбуляк—Эпидемиологические значение родителей-носителей HBs Ag в распространении вируса гепатита В. (Сборник тезисов докладов симпозиума) 1983. 41.
5. Л. И. Шляхтенко, В. В. Нечаев и др.—Эпидемиология вирусного гепатита в очагах и их эпидемиологические обоснование. (Сборник тезисов докладов симпозиума) 1983. 37—38.
6. П. И. Яровой—Вирусный гепатит. Кишинев. «Штийнца», 1980.
7. Арслан—Данные о носительстве HBsAg у здоровых людей в МНР. УБ. 1978.

НЕКОТОРЫЕ ВОПРОСЫ ЭПИДЕМИОЛОГИИ ГЕПАТИТА В

Л. Оюунцэцэг, Т. Гомбосурэн

Путем эпидемиологического наблюдения выявили, что в очагах вирусного гепатита часто встречаются временные и постоянные HBs-антитело-носители и HBs Ag носители женщины являются основными истоциками гепатита В для членов семьи.

Редакций ирсэн 1985. 06. 08.

Шинжлэх ухаан техникийн үс-рэнгүй хөгжлийн энэ зуунд хүний бие махбодод улам бүр өндөр шаардлага тавигдаж байна.

Ийм учраас бие махбодыг чийрэгжүүлэх, сэргээх болон дасан зохицлын үйлчилгээтэй биологийн идэвхт шинэ бодисыг эрж хайх нь чухал юм.

Бид, дээр үеэс түвд ба монголын анагаах ухаанд биеийг чийрэгжүүлэх, ядаргааг гаргах эм болгон хэрэглэж байсан Адамсын тэрэлж (цагаан даль)-ийг судалсан юм.

Дорно дахины эмч нарын төсөөллээр бол адамсын тэрэлж нь хүний бие махбодын хүч тэнхээг дээшлүүлэн ажиллах чадвар, тэсвэр хатуужлыг сайжруулах үйлчилгээтэй ажээ. Ийм учраас түүнийг удаан ужиг явцтай өвчин, биеийн тэнхээ тамир доройтох, ажиллах чадвар, биеийн эсэргүүцэл суларсан үед хэрэглэхийг заасан байдаг.

Ардын эмнэлгийн хүрээлэнгээс энэ ургамлын химийн судалгааг хийж цэцэг навчинд тритерпены төрлийн гликозид (0,1%) ба бусад биологийн идэвхт бодис байгааг илрүүллээ. Уг ургамлаас тритерпены гликозид агуулсан нийлбэр бодис цэвэршуулэн гарган авч «Дендронизид» гэсэн нэртэй бэлдмэлийн биологийн идэвхийг тогтоов.

Эм судлаач Т. Варламова адамсын тэрэлж ургамлын эм зүйн шинж чанар, ялангуяа түүний хамгаалах, дасал зохицлын үйлчилгээг судлан тогтоожээ. Үүний дунд уг ургамал хор багатай, удаан хугацаагаар хэрэглэхэд гаж нөлөө үзүүлдэггүйн зэрэгцээ, төв мэдрэлийн системд нөлөөлж нойрсохын эсрэг үйлчлэхээс гадна булчингийн хучдэлийг сайжруулах, сэргээх нөлөөтэйг тогтоосон юм. Амьтан дээр туршсан судалгааны дун нь адамсын тэрэлжийн бэлдмэлийг клиникийн нөхцөлд сорих боломжийг бий болгосон билээ. Юуны өмнө бид уг бэлдмэлийн сэргээх үйлчилгээг илрүүлэхийн тулд Улсын багшийн дээд сургуулийн I курсын оюутнуудын оюуны хөдөлмөрт үзүүлэх нөлөөг судаллаа. Сорилтын гол зорилт нь Анфимовын зохиосон үсгийн хүснэгтэнд өгөгдсөн ажлыг тодорхой нөх-

цэлд гүйцэтгэхэд оршино. Энэ нь уг ажлын тоо чанарын үзүүлэлтийг гаргах боломжийг өгдөг.

Бидний явуулсан судалгаагаар бэлдмэлийг нэг удаад 15 дуслаар хэрэглэхэд үр дун хамгийн тодорхой илэрсэн бөгөөд энэ үед ажлын хурд 52,4%, үйлдлийг нарийн зөв гүйцэтгэх чадвар 47,4% нэмэгдэж байлаа. Бэлдмэлийн сэргээх үйлчилгээний ургэлжлэх хугацааг тодорхойлохын тулд 1,5-аас 6 цагийн турш ажиглалт хийв. Хяналтын группын ажлын үе дэх хурд ба алдааны хувь үзүүлэлтээс онц ялгагдахгүй ба 6—8 дахь цагаас ажиллах эрч аажим буурч байлаа.

Харин бэлдмэл хэрэглэсэн группын ажлын хурд ихсэх ба алдааны хувь багасах үзүүлэлтүүд 6 цагийн турш хадгалагдаж байсан юм. Үүнээс үзэхэд бэлдмэл оюуны хөдөлмөрийн чадварыг дээшлүүлэх, анхаарлыг төвлөрүүлэн оюуны үйл ажиллагааг эрчимжүүлэх нөлөөтэй Солох нь тодорхойлогдож байна.

Үүний зэрэгцээ биеийн ажлын үед адамсын тэрэлжийн бэлдмэлийн сэргээх үйлчилгээг тодорхойлов. Судалгааг Биеийн тамир спортын хорооны сургалтын лаборатори хийв.

Биеийн хүчний ихээхэн ачааллын үед тамирчдын булчингийн идэвхт ажиллагаанд үзүүлэх нөлөөг тодорхойлохын тулд идэвхт үйл хөдлөлийг эрчимт ачааллаар сорьдог PWc₁₇₀-ыг сонгон электровелоэргометрийн багажийг ашиглав. Энэ сорилтын агуулга нь минутын хугацаанд тодорхой хэмжээний зай (метр)-д ногдох дундаж ачааллын (кг) эсэргүүцлийг даван туулснаар гүйцэтгэх ажил, тэр үеийн зүрх судасны үйл ажиллагааны өөрчлөлтөөр ажиллах чадварыг тодорхойлоход оршино. Бэлдмэлийг 21 хоногийн хугацаагаар хоногт 60 дуслаар хэрэглэсний дараа тамирчдад тодорхой хэмжээний ачаалал олгон туйлдаж ядарсан үед максимум эрчимтэй хурд, ачаалал өгч гүйцэтгүүлэхэд эмийн эрчимжүүлэх нөлөө нь 33% хуртэл хамгийн тод илэрч байв. Дендронизид, ядарч

щуцсан булчингийн сэргэх процесс явагдах хугацааг богиносгож зүрх судасны системийн динамик өөрчлөлт хэвийн байдалд түргэн орохад эерэгээр нөлөөлж байлаа. Гэтэл хяналтын группын тамирчдын биеийн хүчний чадварт ахиц гараагүй, ядаргааны шинж хэвээр үлдэж байв.

Тэрэлжийн бэлдмэлийг хэрэглэсэн тамирчдын ачааллын үед зүрх судасны үйл ажиллагааны дасах ба сэргээх чанарын урвалжууд, хяналтынхаас илүү түргэн явагдаж байгаа нь ажиглагдсан юм. Иймд бэлдмэлийг биеийн хүчний хүнд ажил хийдэг хүмүүст булчингийн системийн хэт ядаргаанаас сэргийлэх болон спортын төрлөөр өндөр ачаалалтай дасгал сургууль хийх үед хэрэглэж болох нь нотлогдоо. Судалгааны дээрх үр дүн нь дендронизидын бэлдмэлийг эмчилгээний практикт туршин судлах чигийг зааж өгсөн юм. Бид энэхүү үр нөлөөг неврастени, гипотони, дистони, астенийн шинж бүхий 119 өвчтөнд сэтгэл мэдрэлийн улсын диспансер, стационарын нөхцөлд судаллаа. Клиник туршилтын дунгээс үзвэл эмчилгээний сайн үр дүн өгч байгаа нь ажиглагдав. Эмийг хэрэглэсний даруйд алжаал ядаргаа багасч, ажиллах чадвар дээшилж байна. Цусны даралт багасах өвчиний үед бэлдмэлийг хэрэглэхэд 7—10 дахь хоногоос артерийн даралт хэвийн байдалд орж байгаа нь ажиглагдав. Харин өвчин даамжирч органик өөрчлөлтэд орсон буюу мэдрэлийн сэрэмтгий чанар давамгайлсан тохиолдолд бэлдмэлийг хэрэглэх хэрэггүй юм. Эмийг турших хугацаанд ямар нэг гаж нөлөө илрээгүй ба нэг удаад 12—15 дуслаар өдөрт 3 удаа хэрэглэж эмчилгээний дундаж курсыг 30—45 хоногоор тогтоосон нь үр дүнтэй байна.

Энэхүү бэлдмэлийн фармакологи, клиникийн илрэл нь түүнд агуулагдаж байгаа тритерпеноид зэрэг тодорхой үйлчлэгч бодисын зэрэгцээ бичил язгуур чухал үүрэг гүйцэтгэнэ. Бэлдмэлийн үйлчилгээ

нь түүнд байгаа ганц нэг бодис биш, харин хэсэг буюу нийлбэр идэвх бүхий бодис агуулагдаж байгаагаас хамаарч болох юм.

Дендронизидын бэлдмэлий үйлдвэр практикт шилжүүлснээр оюуны болон биеийн хөдөлмөрийн ядаргаа, гадны тааламжгүй нэхцэлд бие махбодыг түргэн хугацаанд дасгах, сэтгэл санааны хямраалаас урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Дүгнэлт 1. Адамсын тэрэлжийн бэлдмэлийн эм судлал, эмнэл зүйн туршилтын дунгээс үзэхэд уг бэлдмэл хүн хорхоодойн төрлийн эмүүдтэй төстэй үр нөлөөтэй болох нь илэрсэн бөгөөд эмийг зарим өвчинээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор хэрэглэж болох нь тогтоогдлоо.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. И. И. Брехман—«Женьшень» Л. Медгиз. 1957
2. И. И. Брехман—«Элеутерококк», Л. Наука. 1968
3. Н. С. Саратиков—«Золотой корень». Томск. 1974.

КЛИНИЧЕСКИЕ ИСПЫТАНИЯ ДЕНДРОНИЗИДА

М. Дарьсурэн, Т. С. Варламова-Д. Дамдин, Ц. Готов

В работе представлены данные клинического испытания препарата из рододендрона Адамса. Установлено, что Дендронизид оказывает стимулирующее влияние на умственную деятельность.

Судя по результатам испытания тестов на физическую работоспособность препарат повышает устойчивость организма спортсменов к предельным физическим нагрузкам, стимулирует их работоспособность и выносливость. Выявлена эффективность Дендронизида при неврозах, неврастении, дистонии, астенических состояниях различного генеза, повышенной сонливости, функциональном ослаблении сердечной деятельности, гипотонии и т.д. Дендронизид обладает действием сходным с препаратами группы женьшения и может стать важным фактором, повышающим эффективность комплексного лечения, а также средством профилактики ряда заболеваний.

Редакцийд ирсээ 1985. 10. 30

Б. Жав. (Анагаах ухааны дээд сургууль)

ЭХ БАРИХУЙН ПРАКТИК ДАХЬ ГЕМОРРАГИЙН ШОК
(үргэлжлэл)

Геморрагийн шок, судсуудад цус түгээмээр бүлэгнэх хам шинжийн клиник, онош

Геморрагийн шокийн үед гарах эмгэг физиологийн үндсэн механизмыг тусгасан шинжүүд (эргэж байгаа цусны хэмжээ багасах, цусны хүчил-суурийн ба эрдэнэй бланс өөрчлөгдхө, хязгаарын цусны эргэлт хямрах, судсуудад цус түгээмэлээр бүлэгнэх хам шинжтэй хослох), цус алдах нөхцөлийг бүрдүүлсэн эх барихуйн эмгэгийн шинжтэй хавсрان илрэнэ. Төрсөн эхэд үүсэх геморрагийн шокийн клиник явц дор дурдсан онцлог шинжүүдтэй байна.

Бие сурлах, огиулах, цангах, толгой эргэх нь шокийн клиникийн шинж юм. Өвчтөн нүдний урдуур бүрэлзэнэ, амхатна гэсэн зовиуртай байдаг. Цус алдах нь ихсэх тутам өвчтөний ухаан суларч суулдээ ухаан алдана. Зохицох урвалын улмаас цус дахин хувиарлагдаж хоол боловсруулж өрхтэй, булчин ба арьс цусаар хомсдоно. Арьс цагаарч сааралдуу туяатай, хүйтэн эсвэл чийглэг болно. Өвчтөн нүд хонхижсон, нүүрний байдал ядарсан шинжтэй, судасны лугшилт олширч, дүүрэлт сультай болно. Хүнд явцтай шокийн үед хязгаарын судасны лугшилт мэдэгдэхгүй. Зүрхний титэмийн булчин хүчилтөрөгчийн дутагдалд орсноос үйл ажиллагаа нь өөрчлөгдөнө. Электрокардиограммын шинжилгээнд зүрхний жигд хэмийн байдал эхлээд түргэссэн алаа дараа нь удааширч, Р-шүдний өндөр намсаж, харин Т шүдний өндөр ихсэнэ.

Төвийн венийн ба артерийн даралт буурна. Артерийн даралт буурах нь геморрагийн шокийн хожуу шинж юм. Эргж байгаа цусны хэмжээний 30%-ийг алдахад артерийн даралт эрс буурна. Энэ нь төвийн гемодинамикийн байдлыг зохицуулахад чиглэгдсэн механизм дутагдалд орсныг гэрчилнэ.

Артерийн даралт буурахын сацуу бөөрний цусан хангамж хомсдож шээсний гарц эрс багасна. Артерийн даралт 60—50 мм. мөнгөн усны баганын өндөр болоход шээс ялгарахгүй. Бөөрний капилляр дахь гидростатик даралт сийвэngийн онкотик даралтаас багасна.

Алдаж байгаа цусны хэмжээ ихсэх тутам амьсгалын дутагдлын шинж тод илрэнэ. Үүнд: амьсгалын тоо нэг минутанд 30, түүнээс дээш, амьсгалын эмгэг хэм (чейнастоксийн амьсгал) үүснэ. Өвчтөн нэн цочимтгой болж, үе уе хөхөрне. Шокоос гаргах эрчимт эмчилгээ хийхгүй,

алдсан цусыг бүрэн нөхөхгүй бол. Өвчтөн наркозинос удаан гарахаас гадна мэс заслын дараах эрт үед амьсгалын дутагдал удаан байна.

Даамжрах явцтай шингэн дутагдал нь эргэшгүй шокийн эмгэг жамд гол хүчин зүйл болно. Хэвийн явцтай жирэмсэн үед эргэж байгаа цусны хэмжээ гажмаар нэмэгддэг. Төрөхийн өмнөхэн хуртэл эргэж байгаа цусны хэмжээ 1000—1200 мл ээр нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл төрөх хуртэл эргэж байгаа цусны нийт хэмжээ 5000—52000 мл болсон байна. Эрүүл жирэмсийн эмгэгтэйн эргэж байгаа цусны хэмжээ сийвэngийн хэмжээ хэр нэмэгдсэнээр ихсэнэ. Жирэмсний хугагцаагийн сийвэн жирэмсэн биш эмэгтэйн сийвэнтэй харьцуулахад 800—850 мл ээр ихсэнэ. Ийнхүү сийвэнгийн хэмжээ ихсэнтэй уялдаж жирэмсний эцэст эритроцитын тоо, гемоглобины концентрац (Hb), мөн венозны гематокрит (Ht) харьцаангийгаа багасна. Жирэмсэн биш эмэгтэйн венозны гематокрит 42,5% байгаа бол жирэмсний эцэст 38% хуртэл багасдаг талтай. Ийнхүү цусны хэмжээ ихсэх нь төрөх явцад цус алдахад зохицох, даах боломжийг нөхцөлдүүлнэ.

Жирэмсний хожуу хордлого, төмөр дутагдлын цус багадах, ихсэс түрүүлэх зэрэг жирэмсний хундрэлийн үед эргэж байгаа цусны хэмжээ зохих хэмжээгээр нэмэгдэхгүй байх юмуу, эсвэл багасна. Нефропатитай төрсөн эхийн эргэж байгаа цусны хэмжээ төрөхийн өмнө 3800—4000 мл буюу жирэмсэн биш эмэгтэйн ЭЦХ-тэй адилхан байдаг учраас жирэмсний хожуу хордлоготой төрөгч, төрсөн эхийн цус алдахыг даах чадавх нэлээд багассан байдаг.

Ихсэс түрүүлсэн үед жирэмсэн эмэгтэйн эргэж байгаа цусны хэмжээ, эрүүл жирэмсний ЭЦХ-ээс бага байдаг. Төрөлтийг мэс ажилбаргаар төгсгөсөн нөхцөлдүүлсүүс, ялангуяа эритроцитын хэмжээ жирэмсэн биш эмэгтэйнхтэй харьцуулахад багассан байна.

Төрөхийн өмнөх үед төмөр дутагдлын цус багадалттай жирэмсэн эмэгтэйн (гемоглобины түвшин 90 г/л), веноны гематокрит 30—32%, түүнээс (багасах) цусны физиологийн хэмжээ ихээдэггүй. Харин эргэж байгаа цусны хэмжээ жирэмсэн биш эмэгтэйн ЭЦХ-ээс багасна. Тартган (II—III зэрэгтэй) ба зарим өвчинтэй жирэмсэн эмэгтэйн ЭЦХ хэвийн хэмжээнээс ихсэхгүй, харин багасах хандлагатай. Энэ байдлаас хамаарч эрх-

Түрүүч нь 1987 оны хоёрдугаарт бий.

тэн системийн хүнд хэлбэрийн явцтай өвчтэй, жирэмсний зарим эмгэгтэй (жирэмсний хордлого, ихэс түрүүлэх г.м.) төрөгчдийн цус алдахыг даах чадавх буурдагтай уялдаж геморрагийн шок үүсэх үндэстэй учраас тэднийг амархан өртөмтгийн бүлэгт хамааруулна.

Ийм учраас алдсан цусны хэмжээ, эргэж байгаа цусны хэмжээний зөрүүг нарийвчлэн тооцож гаргах шаардлагатай. Төрөх замаас гарч байгаа цусыг цуглуулан, цагаан хэрэглэл, хэрэглэсэн даавуунд шингээн цусыг жигнэн хэмжиж, алдсан цусны нийт хэмжээг иягтлан тооцож гаргана.

Геморратийн шокийг оношлоход түзвэгтэй биш атлаа түүний зэрэглэл буюу хүнд, хөнтэн, алдсан цусны хэмжээг тогтооход иэн бэрхшээлтэй байдаг. Өвчтөний биенийн байдлыг зөв үнэлж, зайлшгүй хийх эрчимтэй эмчилгээний хэмжээг нарийвчлэн тодорхойлох нь практикийн чухал ач холбогдолтой.

Алдаж байгаа цусны хэмжээг гравиметрийн аргаар нарийвчлэн тодорхойлж болно. Энэ аргыг хувилбарласан хөбэр арга байдаг. Тухайлбал өвчтөн, мэс заслын материалыг жигнэж тодорхойлж. Цус шингэснүүц болтын материал, цагаан хэрэглэлийг жигнэхдээ 1 мл цус 1 граммтай. Төрөх замаас гарч байгаа цусыг

Артерийн даралтын динамикт, судас ба амьсгалын давтамж, биенийн халуун, шээсний гары, бусад субъектив шинжүүдэд түшиглэн геморрагийн шокийн хүнд, хөнгөн үнэлгээ өгнө. Гэхдээ артерийн даралт, шингэн алддалтын хооронд харилцан уялдах, нөхцөлдөх шууд холбоо байдаггүйг санавал зохино.

Геморрагийн шокийн хүнд, хөнгөний явцыг 4 зэрэгт хувуанаа.

I ЗЭРЭГ. Эргэж байгаа цусны хэмжээ 15% хүртэл хомсдоно. Артерийн даралт 100 мм мө. усны баганын өндөрөөс дээш, төвийн венийн даралт хэвийн хэмжээнд (60—100 мм усны баганын өндөр) байна. Өвчтөний биенийн байдалд онцын өөрчлөлт гараахгүй. Арьс ялимтуй, цагаавтардуу өнгөтэй, судасны лугшилт нэг минутанд 80—90 удраа, гемоглобини концентрац 90 г/л, түүнээс дээш байна. Өвчтөний биенийн байдал эмчилгээнд амархан засарна.

II ЗЭРЭГ. Эргэж байгаа цусны хэмжээ 30% хүртэл хомсдоно. Өвчтөний биенийн даралт дунд зэрэг өвчтөн толгой эргээни, бие сулдана, нүдний урдуур бурэлзэнэ. Огидос хүрнэ гэсэн зовиуртай байна. Арьс нь хүйтэвтэр, цагаарсан байна. Артерийн даралт 80—90 мм мө. усны баганын өндөр, төвийн венийн даралт буурна (60 мм усны баганын өндөрөөс багас). судасны лугшилт нэг минутанд 110—120 удаа, шээсний гарц багасна. Гемоглобини концентрац 80 г/л ба түүнээс бага болно.

III ЗЭРЭГ. Эргэж байгаа цусны хэмжээ 30—40% хомсдоно. Өвчтөний биенийн байдал нэлээд хүндэрнэ. Өвчтөний ухаан сарниж, арьс нь нишлэхүйдээ цагаарч, хязгаарын мөчид хөхөлбүү өнгөтэй болно. Артерийн даралт 60—70 мм. мө усны баганын өндөрөөс багасч, төвийн венийн да-

ралт түргэн явцтай буурна. (20—30 мм. мө уснын өндөрөөс багасна). Судасны лугшилт нэг минутанд 130—140 удаа атлаа дүүрэлт султай болно. Шээсний гарц эрс багасна.

IV ЗЭРЭГ. Эргэж байгаа цусны хэмжээ 40%, түүнээс хомсдоно. Амьдралын үйл ажиллагаа ижн хүнд байдалд орж дарангуйлагдана. Ухаан алдана. Артерийн ба төвийн венийн даралт, хөл гарын судасны лугшилт мэдэгдэхгүй болно. Гагцхуу нойрны ба гуяны артерийн лугшилт зүрхний агшилтын тоогоор тэмтрэгдэх төдий байна. Амьсгал өнгөцхөн, олон болсон байна. Шээс отг ялгарахгүй, рефлексүүд сударна. Өвчтөн иэн хөдөлгөөнтэй, амьсгалын хэм алдагдаж эмгэг байдалд орно.

Өвчтөний биенийн хүнд, хөнгөний байдлыг зөв үзүүлэхэд шокийн индекс чухал зач холбогдолтой. Шокийн индексийн үзүүлэлт 0,5—0,54 байдаг. Өөрөөр хэлбэл биений байдал хэвийн байхад судасны лугшилтын тоо нэг минутанд 60 удаа, артерийн даралтын дээд хязгаар 120 мм. мө усны баганын өндөртэй байхад шокийн индекс 60:120=0,5 байна. Эргэж байгаа цусны хэмжээний 20%-ийг алдажад (судасны лугшилт 1 минутанд 100 удаа, артерийн дээд даралт 100 мм. мө усны баганын өндөр) шокийн индекс 1,5-тэй тэнцэнэ. ЭЦХ-ний 30%-ийг алдажад (судасны лугшилт 1 мин 120 удаа, артерийн дээд даралт 80 мм. мө усны баганын өндөр) шокийн индекс 1,5-тэй тэнцэнэ.

Бичил эргэлтийн өөрчлөлт ихсэх, шокийн явцын хүндрэлийг бодитойгоор үзүүлэх үзүүлэлтэй шалгуур бол цагт ялгарч гарах шээсний гарц юм. Шээсний гарц бээрөн дэх цусны эргэлтийн байдлаас шууд хамаарна. Бээрний цусны эргэлтийн нэг хэсэг учраас шээсний гарцаар бусад амин чухал эрхтэн дэх цусны бичил эргэлтийн байдлыг үнэлж болно. Хязгаарын цусны эргэлтийн шокийн гарц 40 мл/ц, түүнээс дээш 60—80 мл/ц (геморрагийн шоктой байхад шингэн эм сэлбээж шээсний гарц сайжирна) байна. Шокийн байдалд байгаа өвчтөний шээс нам нягтралтай, уурагтай, цилиндрүүд ба бээрний хучуур эстэй байна.

Судсуудад цус түгээмлээр бүлэгтэх хам шинжийн (СЦТБ) клиник явцын илрэл янз бүрээс гадна хэд хэдэн шаттай. Нэгдүгээр шатанд (булэгнэлт хэт ихсэх) клиникин илрэл байхгүй. Энэхүү шатын гагцхуу геморрагийн шокийн эхийн шинж тэмдгүүд илэрмэгц мэдэж болно. Хөөрдугаар шатанд (фибрин уусгалт тархмал болохгүйгээр бүлэгнэлт багасах) шархны гадаргуу, мэс заслын шархнаас цус нэзвийн гарна.

СЦТБ хам шинжийн III, IV шатанд цус огт бүлэгнэхтүйгээр фибрин уусах нь түгээмлэжин тромбоцит эрс багасна. Тарцаа хийсэн хэсэг, шархны талбайгаас цус их хэмжээтэй тоожино. Хатгасан тэр хэсэгт цусан булдуу үүснэ. Арьсанд цэгшиг цусан харвалтууд гарна. Мөн бөөл-

**Гемостазын өөрчлөлтийн экспресс
оношлэгсүү**

| Экспресс оношлэгсүүны сорилууд | Норм | Гемостазын өөрчлөлтүүд | | | | | |
|--|-------------|------------------------|-----------------|---------------------|------------------------|------------------------------------|-----------------------------|
| | | СЦТБ (шатууд) | | | | Коагулопа- тийн гемодилюц | Цусанд гепарин хэт ихсэх |
| | | 1 | 2 | 3 | 4 | | |
| Цусны бүлэгнэл- тийн хугацаа минутаар | 5—12 | 5-аас бага | 5—12 | 12-оос их | 60-аас их | 12-оос их | 12-оос их |
| Бүлэн аяндаа усах | ҮГҮЙ | ҮГҮЙ | ҮГҮЙ | түргэн | бүлэн ҮҮсэх- гҮЙ | ҮГҮЙ | бүлэн сэвс- гэр |
| Тромбин-тест секунтээр | 7—11 | 7—11 | 7—11 | 20—60 | 60-аас их | 7—60 | 60-аас их |
| Иммунопреципи- тацийн тест | — | — | + | ++ | + | — | — |
| Тромбоцитын тоо $10^9/\text{л}$ | 175— 425 | 175—425 | 120-оос бага | 100- аас бага | 60- аас бага | Цус ба- гадалт- тай дүйнэ | 175— 425 |
| Этанолын тест | — | ++ | + | — | — | — | — |
| Тромбины хугацаа сек | 24—34 | 24-өөс бага | 60-аас их | 100- аас их | 180- аас их | 24—34 | 60-аас их |
| Эритроцитын фрагментацийн сорил (тест) | — | — | + | + | — | — | — |

жистэй хамт цусны судал гарахаас гадна хамраас цус гоожино. СЦТБ хам шинжийн клиник явц 7—9 цаг ба түүнээс дээш хугацаанд ургэлжилнэ. Гемокоагуляшийн системд гарах өөрчлөлтууд нэлээд удаан хугацаанд явватдана. Энэхүү өөрчлөлтүүдийг лабораторийн шинжилгээний

аргаар тодорхойлжно. Клиник явцад гарсан нааштай өөрчлөлтийн харьцуулахад лабораторийн шинжилгээгээр илрэх өөрчлөлт нэлээд удаан хугацаанд ургэлжилнэ.

СЦТБ хам шинжийг оношлоход лабораторийн шинжилгээ чухал ач холбогдолтой байхын сацуу хам шинжийн

шатыг тогтоож, эмчилгээг зөв сонгож хийхэд нэн ашигтай. Фибриногены задаралын бүтээгдэхүүн, тромбины ба цусны бүлэгнэлтийн хугацаа, тромбин-тест, цусны нөхөрмөгийн аяндаа уусахыг тодорхойлох, тромбоцитыг тоолох сорилууд нь СЦТБийт оношлоход экспресс-оношлогоны арга болдог. Гемостазын өөрчлөлтийн экспресс-оношлогоны сорилуудыг хүснэгтэд харуулав.

Хүснэгт I-ээс үзэхэд гагцхүү хам шинжийн III—IV шатанд цусын бүлэгнэх хугацаа икссэн байна. Умайгаас, мэс заслын шархнаас гарч байгаа цусыг шинжилж, түүнд фибриноген задарсанас үүссэн бүтээгдэхүүн, фибриноген байгааг тодруулах нь чухал ашигтай. Ингээнээр хэсэг ормын фибринолиз байгааг тодруулна. Гарч байгаа цусанд фибриноген байхгүй байхад тромбин-тестийн хугацаа 60 секунт, түүнээс дээш болно.

СЦТБ-ийн хам шинжийн үед фибрин уусах идэвхжлийг тодорхойлох нь практикийн ач холбогдолтой байдаг. Цусны бүлэгнэх чадвар сайн, фабрин уусах нь

тархмал биш байгаа нөхцөлд цусны бүлэйн үүсч, ийлдээс тунгалааг байна. Фибрин уусгалт тархмал биш атлаа цусны бүлэгнэлт багассан байхад жижигхэн хэмжээтэй, сэвсгэр бүлэн аажим үүснэ. Ийлдсэн дотор цусны элементүүдийн хагас улдэнэ. Ийнхүү үүсэж байгаа бүлэн удаан хугацаанд байхын сацуу аяндаа уусахгүй. Фибрин уусах нь идэвхжсэн цусны бүлэгнэлт багасахад жижигхэн сэвсгэр бүлэн үүсч амархан уусна. Цусын срээсээ бүлэгнэхгүй болсон нөхцөлд бүлэйн отг үүсэхгүй.

СЦТБ хам шинжтэй өвчтөний биеийн байдлыг зөв үнэлэх, хам шинжийн шатыг тогтоох, алдсан цусны хэмжээг нягтлан хэмжих тодорхойлох, эмчилгээний хэмжээ, аргыг зөв сонгоход дээр дурдсан экспресс-оношлогоны сорилтуудыг эх багийн практикт нэвтрүүлэх явдал ихээхэн ашиг тустай болох нь тодорхой билээ.

Тегсгөл нь дараагийн дугаарт

Редакцид ирсэн 1987. 02. 27

Т. Дэлгэр (*Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг*)

Н. Жанцан, Б. Байгаль (*Анагаах ухааны дээд сургууль*)

ВИРУСТ ГЕПАТИТ

ЭМЧИЛГЭЭ: Вируст гепатитаар өвчилсөн хүнийг эмнэлэгт заавал хэвтүүлж эмчилнэ. Өвөрмөц эмчилгээ одоогоор байхгүй боловч эмгэг жамын эмчилгээг хийдэг.

Суурь эмчилгээ. Хэвтрэйн дэглэмийг клиник эдгэрэлтийн ўе эхэлж зөвиур арилж, шар буурч эхлэх хүртэлх бүх хугацаанд баримтлуулж цаашид хөдөлгөөнийг нь аажмаар нэмэгдүүлж улмаар хязгаарласан хэвийн дэглэмд оруулна. Суурь эмчилгээний нэг үндсэн зарчим бол хоол эмчилгээ юм.

Хоол эмчилгээ: Өвчтөний хоол нь өвчтэй эллэнд илүү дарамт болохгүй нөгөө талаар уураг, эрдэс бодис, витаминаар бие махбод, элгийг хангаж байх ёстой.

Чанар муу, уураг багатай хоол нь өвчийг ужиг хэлбэрт шилжүүлж эдгэрхэд муугаар нөлөөлнэ. Вируст гепатит өвчтэй хүмүүсийн хоол нь нүүрс ус, уургийн зүйлээс тогтсон 2500—3000 ккал-аас багагүй байх шаардлагатай. Уураг нь өвчийн эдгэрэлтэнд нөлөөлөн ухжиж өөрчлөгдсөн эд эсийг нохөн төлжүүлэхэд чухал бөгөөд тэр нь липотропт үйлчилгээ үзүүлдэг.

Өвчтөнд өдөрт 80—100 гр уураг өгнө. Хүүхдэд бол 1 кг биеийн жинд 1,5 гр уураг байхаар бодож өглөг. Үний 30—50% нь амьтны гаралтай байхаар бодож өгвөл зохино. Өвчийн эхний үед сүүний гаралтай уураг (эзэгий, тараг, буцалсан сүү) голчлон хэрэглэнэ.

Үхэр, тахиа, загасны махыг сайн чанаж өнжьеөд юмуу заримдаа өдөр бүр өгч болно. Ялангуяа архаг хэлбэрийн үед ямааны сүү нь өвчний явцад сайн нөлөө узуулна. Өвчтөнд өдөрт ямааны сүүг 200—800 мл хүртэл өгч болно. Нүүрс ус нь талх, төрөл бурийн будаа, гурил элдэв ногоонд их байдаг. Нүүрс ус нь уургийн синтезэд оролцдог тул хоногт 300—500 гр, хүүхдэд бол кг жинд 14—16 гр-аар бодож нүүрс ус өгдөг. Гепатит өвчтэй хүмүүсийн хоолны өөх тосны хэмжээг эрэс хорогдуулах шаардлагатай боловч, цэс ялгаралтанд үйлчлэх физиологийн цочруулагч болохын хувьд өөх тосыг бага хэмжээгээр өгч байвал зохино.

Түүнээс гадна бие махбодод тэр нь зарим төрлийн витаминуудын эх сурвалж болдгоор барагчийн нүүрс усны нэгэн адил энергийн чухал сурвалж болдог. Гол төлөв өвчтөнд хоногт 25—30 гр тос, цэцгийн тос өгнө.

Өвчтөний хоолонд давсны хэмжээг 3—5 гр хүртэл багасгах хэрэгтэй.

Өвчний хүнд үед ялангуяа ком, комын өмнөх байдалд байгаа өвчтөнд уураг, нэн ялангуяа өөх тосны зүйлийг бүр мөсөн хориглож, нүүрс ус голчилсон хоол өгч, шинжэн юм уулгах хэрэгтэй.

Өвчтөн их бөөлжсөн үед хямсуураар хооллох хэрэгтэй. Витамины шүүс, компот, чихэртэй цай бага багаар уулгаж байх нь чухал. Ялангуяа хүнд үед бие махбодод хорт бодис хуримтлагдахын зэ-

Түрүүч нь 1987 оны хоёрдугаарт бий.

рэгцээгээр ус шингэн дутагдах явдал их байдаг тул өвчтөнд хоногт 2—3 л-ээс доошгүй шингэн өгөх нь чухал.

Өвчтөний хүнд хөнгөнөөс шалтгаалах гүйзэр хоолыг дараах журам баримталж өгнө. Эмнэлэгт анх хэвтсэн өдөрт нь хоол сойж, зөвхөн ногоо жимсний шүүс, сахартай ус, алтм глюкозын уусмал зэргийг, өвчний эхийн 3—5 хоногт ураг өөх тосыг эрс хязгаарлаж, тарал, хүүхдийн будаа, сүү, хоногт 200—300 гр талх, темсний нухаш, луувангийн шүүс, жимс, жимсний шүүс, зэгийн бал, загасны чанасан мах зэргийг өгнө.

Өвчний эхийн 7—10 хоногт цагаан талх, хатсан талх мантуу, ухрийн туралхай махаар хийсэн хоол, цэцгий нэмж өгнө. 10—15-аас хойших хоногуудад масло 10 гр хүртэл, чанаж жигнэсэн махан хоол, ээдэм, ургамлын тос зэргийг нэмж өгч хоолны хэмжээг аажмаар нэмэгдүүлэн нэр төрлийг олшруулна.

18—20 хоногоос хойш хоол нь өөх тос багатай, хайр хуураагүй, хоолны амт оруулах хольцгүй шингэн сайн, ногоо, цагаан, идээ элбэг хоол өгнө. Энэ үед өвчтөнд уураг, өөх тос, нүурс усны дээд хэмжээг баримтлан өгнө.

Эмийн эмчилгээ. Гепатитын үед элэгний үйл ажиллагааг хэвийн болгох, урэвслийн процессыг зогсох, бие махбодын бодисын солилцоог зохицуулах хор тайлах эмүүдийг хэрэглэнэ. Элгийг хэвийн үйл ажиллагаанд оруулахад витамин сайн нөлөөтэй. Гепатитын үед С витаминыг хоногт (360—500 мг), В₁ (50 мг) В₂ (10—20 мг), В₆ (40—50 мг), В₁₂ (100—200 мкг) Р (0,1), А (10 мг), РР (50 мг) ба К зэрэг витамин хэрэглэнэ. Мөн фолиин хучил ба липохуцил зэргийг өгнө. Өвчний хурц үед легалон, катерген эссенциале зэрэг эмийг өгдөг.

Вируст гепатитын үед нүурс усны хямарсан солилцоог хэвийн болгох, элэгний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор биеийн энергийн эх үүсвэр болох глюкоз, фруктозыг өвчтөнд уулгах юмуу, эсвэл тариагаар хэрэглэнэ. Өвчтөний хөнгөн, дунд зэргийн хүнд хэлбэрийн үед глюкозын 5—10%-ын уусмыг уухаар өгч, хүнд үед тариагаар хэрэглэнэ. Глюкозыг тарьж хэрэглэхдээ өвчтөний насын байдал, хордлогын шинж зэргийг харгалзан түүний 5—10% уусмалаас 0,5—2,0—2,5 л хүртэл хэмжээгээр тарина.

Ургийн бодис. Вируст гепатитын үед бие махбодын уургийн солилцоо хямарч, зарим нэг чухал аминхүчлээр дутагддаг.

Ялангуяа өвчтөн бөөлжүүлэх, хоолонд дургуй болох шингэнээр суулгах зэрэг гэдэс ходоодны ажиллагаа хямарсан хоолны шингэц муу болсон үед ургийн бодисыг нэмж өгөх шаардлагатай. Аминхүчлүүдийг хооронд нь зөв нийтийн төлжилтийг сайжруулан, ухжлийн процессыг зогсоо сайн нөлөөтэй. Биеийн хордлогыг багасгах зорилгоор цус плазм ба альбуминыг хэрэглэнэ.

Түүнчлэн цус плазм нь онкотик дараалтыг ихэсгэх, цус бүлэгнэлтийн чанарыг

сайжруулах үйлчилгээтэй учраас хавантай, цус алдсан, хордлого ихтэй өвчтөнд тарих нь үр дүнтэй байна. Плазмыг том хүнд хоногт 100—125 мл, хүүхдэд кг жинд 5—10 мл бодож тарина. Донорын цусыг долоо хоногт 100—200 мл-ээр 2 удаа, альбуимины 10%—20% уусмалыг 200—250 мл, протеины 4,8% уусмал 100—150 мл хэрэглэхэд сайн үр дүнтэй байна.

Асцит үүссэн үед альбуимины тарьж болно. Комын үед альбуимины никотини хүчлийн амидын хамт хэрэглэхэд үр дүнтэй байна.

Глюокортостероид өмчилгээ. Кортикостероид нь элэгний уураг, нүурс усны солилцоонд нөлөөлж, мезенхимийн эдийн өсөлтийг саатуулан харин элэгний паренхимийн эс дээр анаболитик үйлчилгээ үзүүлнэ.

Ингээснээрээ элэгн дэх инфильтратив процессыг дарж, холбох эд-фибробласт, фиброцитын өсөлтийг багасган тэдгээрийн толжих процессыг зогсоноо. Глюокортостероид нь элэгн дэх үрэвслийн процессыг багасгах нөлөөтэй. Тэр нь эсийн мембрэн, хялгасан судасны ханын нэвчих чанарыг багасган элгэнд явагдаж байгаа ухжлийн процессыг намдаан, ретикулонидотели, антител үүсэхийг саатуулж, бөөрний дайврын үйл ажиллагааг зохицуулж байдаг. Түүнчлэн глюокортостероид нь элэгний эд эс болон цусан дахь үргийн хэмжээг багасгах үйлчилгээ үзүүлнэ. Бас элгийг гликогенжуулэх процессыг идэвхжүүлж, элэгийн нүурс усны солилцоог зохицуулна. Зарим глюокортостероид, тухайлбал триамсинолон нь бөөрний сувгандцаарх усны реабсорбжих процессыг удаашруулж бөөмцөр дэх фильтратыг сайжруулах замаар шээс хөөх үйлчилгээ үзүүлнэ. Глюокортостероидыг вируст гепатитын хурц хэлбэрийн үед хэрэглэхэд биеийн ерөнхий хордлого арилж билирүбини хэмжээ буурч, цусан дахь ферментийн идэвх багасдаг. Эдгээр нь зөвхөн үрэвслийн эсрэг ба иммун урвалж чанарт нөлөөлөх төдийгүй бодисын солилцоонд гүнзгий өөрчлөлт оруулна. Мөн элгийг бөхжүүлэх, элгэнд цус харвалтын голомгууд уүсгэн элэгний эд эсийг ухжүүлэх муу нөлөөтэй. Тэр ч байтугай гормон эмчилгээг буруу, эмх замбарагай хэрэглэснээс өвчин дахин сэдрэх, дахих зэрэг яз бүрийн дайвар харш үйлчилгээ үзүүлдгээс гадна бие махбодын систем эрхтэйн үйл ажиллагаанд өөрчлөлт үүсж болно. Ийм учраас глюокортостероидыг хурц гепатитын зөвхөн дараах тохиолдолд хэрэглэнэ.

1. Хордлого ихтэй, хүнд ба ужиг явцтай хэлбэр, эмчилгээнд шар буурахгүй тохилодол

2. Комд орох угтад дохио илэрсэн буюу комын урьтал үе, ком.

3. Хаван асцит хэлбэр, холестазтай явагдах хэлбэр.

4. Илрэхт архаг гепатит, гепатитын дараах цирроз.

Гормоны эмийн дотрос өргөн хорэглэгддэг нь преднизолон, гипрокортизон, дексаметазон зэрэг болно. Преднизолоныг том хүнд уухлаад өгвэл хоногт 40—60 мг, комын үед тарнигаар бол 300—500 мг,

хүүхдэд уухаар бол кг жинд 2 кг, комын үед тариагаар 5—10 мг, ийтдээ 2—3 доо хоног хэрэглэнэ. Гормоны эмийн тунг 3—4 хоног тутам эхлээд 5—10 мг, дараа нь 2,5—5 мг-аар багасгах журмаар өгнө. Преднизолонг тарьж хэрэглэвэл ууж хэрэглэх түүний тунгаас 4—5 дахин их байхаар тооцоолж өгөх журамтай. Калийн бэлдмэл, антибиотикийг энэ үед хавсран хэрэглэвэл зохиши. Цочмог гепатитын үед гормон хэрэглэх хугацааг өвчтөний би-еийн ерөнхий байдал шарын бууралт, хордлогын багасалт зэргийг харгалзан лабораторийн шинжилгээг үндэслэн тогтооно. Хэрэв шар хурдан буурч хордлого түргэн арилбал преднизолоны эхний хоногийн тунг 1/2-ээр багасгаж дараа нь 3—5 хоног тутам 0,25 мг-аар хородгуулна. Эмийн тунг хородгуулаадаа хамгийн түрүүнд гормон эмчилгээг цусны трансаминаизын идэвхийн буураалтын байдлыг харгалзан зогсох журам баримтална.

Хордлого тайлах шингэн. Үүний тоонд плазм нөхөгч гемодез, неокомпенсан, полидез, перистан, Рингерийн уусмал, глюкозын 5—10%-ын уусмал багтана. Эдээр шингэн нь бие махбодод үүссэн хорт бодисуудыг шингэлэн хоргуй болгох нэгдэл оруулах үйлчилгээтэйгээс гадна алдагсан давс-электролитын солицоог тэгшигтэхэд чухал үүрэгтэй.

Хордлого тайлах шингэнгээ өвчний хүнд хэлбэр, комын урьдал үе, комын үед өвчтөний зүрх судасны ажиллагаа, шээс ялгарах байдал зэргийг харгалзан том хүнд 1,5—3 л хүртэл, хүүхдэд кг жинд 75—120 мл, комын үед 150 мл хэрэглэнэ. Поливинил, гемодезийг том хүнд 200—400 мл, хүүхдэд кг жинд 10—20 мл бодож судсандаа дуслаар хийн.

Липотроп эмүүд. Холин, липокани, липовитан зэрэг нь липотроп үйлчилгээтэй элгэн дэх өөхөн инфильтрацийг багасгахад зориулагдсан эмүүд юм. Гэвч вируст гепатит өвчний үед элзгийн эд эсэд өөхөн дистрофи болдоггүй тул эдгээрийг хэрэглэх албагий. Харин архаг архичин, чихрийн диабеттэй хүн гепатитаар өвчлөх юмуу гепатитын архаг хэлбэрийн үед мөн глюкокортикоид хэрэглэсэн үед түүний 0,1-ээр хоногт 3 удаа 7—10 хоног уулгана.

Цэс хөөх эмүүд. Энэ нь дотроо давсан цэс хөөгч, цэсний хүчлийн найрлагатай цэс хөөгч гэж 2 янз байна. Цэс хөөх эмүүд нь цэсний замын эрхтэнд рефлекс үүсгэж, тэдгээрийн механик агшилтыг ихэсгэнэ. Зарим эм нь элэгний цэс ялгаралтыг ихэсгэнэ. Өвчний цочмог хэлбэрийн эхний үед давсан цэс хөөгчийг (сульфат магнезийн 5—10% уусмал, сорбитол), өвчний хожуу үед мөн архаг ба холестатик хэлбэрийн үед найрлагандаа цэсний хүчил агуулсан цэс хөөгчийг (аллохол, билихол) хэрэглэнэ.

Глютамины хүчил нь аммиакийг хоргуйжүүлэх үйлчилгээтэй тул түүнийг комын үед хэрэглэнэ. Глютамины хүчлийг циррозын комын үед 8—10 гр-аар хоногт 3—4 удаа уүж хэрэглэх буюу түүний 1% уусмалыг 50—150 мл тарина. Түүнчлэн глютамины хүчлийн натрийн давсны 20—30 гр авч глюкозын 5%-ын 500 мл уус-

малын хамт ариутгаж судсаар тарьж хэрэглэх нь аммиакийг саармагжуулах сайн нэлэөтэй.

Органинийг гол төлөв 5% ийн уусмалаар хэрэглэнэ. Аммиакийг хоргуйжүүлэх үйлчилгээтэй эмийн тоонд орнициетил (20—25 гр судсаар) моноаминооксид, аспарагины хүчил, Л—глютамин багтана. Фенилаланины солицоог зохицуулж, фенилаланин задрахад үүссэн Л—глютамин нь хортой бодисыг саармагжуулах үйлчилгээ үзүүлдэг тул вируст гепатитын хүнд хэлбэрийг эмчлэхэд нэлээд үр дунтгэй. Түүний хоногт 12—18 гр дунджаар 7—10 хоног хэрэглэнэ.

Кокарбоксилаз. Кокарбоксилаз нь пировиноград ба бусад кетохүчлүүдийг исэлдүүлэн декарбоксилжуулах процессыг идэвхжүүлэх кофермент юм. Кокарбоксилазын дутагдал болоход пировиноград хүчингийн махбодод хуримтлагдаж ацидоз үүсгэхэд хургэдэг. Ийм уираас гепатитын хүнд хэлбэр, комын үед кокарбоксилазыг хэрэглэнэ. Хоногт 50—100 мг, хүнд үед 300 мг хуртэл судсандаа тарьж хэрэглэнэ.

Пирамидины төрлийн эмүүд. Метилурацил, тимин, цитозин, пентоксилизэрэг нь бие махбодын эд эсэн дэх нуклеини хүчлийн нэгдэлжих процессыг идэвхжүүлж, эсийн уржлийг түргэсгэн, нөхөн төлжкуулэх процессыг хурдасгадаг үйлчилгээтэй. Түүнчлэн эдгээр эм нь цусны цагаан цогцсын фагоцитозын идэвхийг сайжруулан, цус төлжих процессыг ихэсгэнэ. Пентоксилизил ба метилурацилыг 0,5-аар хоногт 3 удаа, хүүхдэд бол 0,1—0,3-аар бодож 3 удаа өгнө. Эдгээр эмийг хэрэглэхэд өвчний шарлалтын үргэлжлэх хугацаа богиносож, эзлэгний хэмжээ багасч, биохимиийн шинжилгээ хурдан хэвийн байдалд ороход нөлөөлж цусан дахь уургийн глобулины альфа, гамма фракц ихсэж, глюкопротеидын хэмжээ нэмэгддэг.

Физик эмчилгээний аргууд. Элэгний тус газарт компресс буюу бүлээн жин тавих, солюкс тосон жин, днитерми, УВЧ шарлага хийх нь элэгний цусан хангамжийг сайжруулан үрэвслийн процессыг намдаахад нөлөөлж. Вируст гепатит, цэсний замын үрэвслээр хундэрсэн буюу эсвэл уг өвчний холестатик хэлбэрийн үед физик эмчилгээг хийхийн хамт цэс угаах, тубаж тавьж цэсийт зондоор авна.

Вируст гепатитын холестатик хэлбэрийн болон цэсний замын дискинези болсон үед гөлгөр булчингийн агшилтыг сууртуулах үйлчилгээтэй ношпа, папаверин спазмолитин, метицин зэрэг эмийг хэрэглэнэ.

Өвчтөнийг тайвшруулах зорилгоор димедрол, супрастин, пиполифен (антигистамины эмүүд), комын үед седуксин, дроперидол (2,5—5 мг), галоперидол (5—15 мг), нембулат зэргийг хэрэглэнэ. Шээс хөөх үйлчилгээтэй эмийг диурезийн байдлыг харгалзан хэрэглэнэ. Эдгээрийн тоонд манинтол, лазикс, спиронолактон, вероширон зэрэг эм багтана.

Вируст гепатитыг эмчлэх ерөнхий зарчим.

ХӨНГӨН ХЭЛБЭР. Өвчтөнд хийх суурь эмчилгээ бол хоол, нарийн дэглэм баримтлах явалж юм. Хөнгөн хэлбэрийн үед хэвтэрийн дэглэмийг 7—12 хоног, хагас хэвт-

рийн дэглэмийг 12—18 хоног, шилжилтийн дэглэмийг 18—30 хоног баримтална. Хоногт уух шингэн 1—1,5 л-ээс багагүй байна. Хоол сойхгүй. Өвчний эхний 3—5 хоногт уураг, өөх тос багатай, нүүрс ус голлосон хоол өгч сүүлийн өдруудэд сүү, ногоогоор элбэгт хоол өгнэ. Витамин «С»-г хоногт 300—500 мг, мөн бусад төрлийн витаминыг өгнэ. Глюкоз, сахартай цай уулгаж, компот, байцааны шүүс өгнэ.

ДҮНД ХЭЛБЭР. Эмчилгээний ерөнхий зарчмын хөнгөн хэлбэрийн үеийнхтэй адил. Энэ үед баримтлах дэглэм арай чанд байна. Хэвтриний дэглэмийг 12—15 хоног, хагас хэвтриний дэглэмийг 15—30 хоног, шилжилтийн дэглэмийг 40—50 хоног хуртэл баримтална. Хоногт хэрэглэх шингэн 2—2,5 л-ээс багагүй байна. Энэ үед витамин С 400—500 мг, витамин В₁, В₂, В₁₂ витамин РР, витамин Р зэргийг өгнэ. Өвчний эхний хоногт хоол сойж, өвчний 2—3 хоногт уураг, өөх, тосны хэмжээг эрс хязгаарлаж 5—7 хоногоос чанасан булчин мах, 7—10 хойших хоногуудад масло, ээдэм зэргийг өгч хоолны нэр төрлийг олшуулна.

ХҮНД ХЭЛБЭР. Эхний 3—7 хоногт өвчтөнг ороос нь огт босгохгүй байглана. Ер нь хэвтриний дэглэмийг 20—25 хоног, хагас хэвтриний дэглэмийг 25—30 хоног, шилжилтийн дэглэмийг 2 сар хуртэл хувацаа гар баримтална. Хоногт хэрэглэх шингэнг 3—3,5 л-ээс доошгүй, үүнээс 1,5—2 л хуртэл шингэнг (глюкозын 5—10% усмал, рингер, гемодез) тариагаар хийнэ. Хоолыг эхний хоногт сойж, дараа нь 3—5 хоногийн турш уураг, өөх тосны хэмжээг хязгаарлаж цагаан хоолоор хооллон. 7—10 дахь хоногоос хоолонд чанасан мах, уургийн хэмжээг ихэсгэж нэр төрлий нь олшуулна. Энэ үед бие машбодод дутагдаж байгаа уургийг нөхөж өгөх зорилгоор аминхүчлийн бэлдмэлээс өгч болно. Витамин С-г хоногт 400—600 мг, витамин В₁ 30 мг, кокарбоксилазыг 50—100 мг, витамин В₆—20 мг, никотины хувил 100 мг, В₆—50 мг хэмжээгээр өгч витамин К, Р зэргийт шаардлага харгалзан өгнэ. Өвчний хүнд үед хэрэв олон дахин бөөлжүүлэх, хордлогын шинж их, халуурах, элэгний хэмжээ бага, аминотрансферазын идэвх өндер, сулемагийн сорил 1,2-оос бага байвал глюокортикостерондыг хэрэглэнэ.

ГКС-ыг хоногт 40—60 мг- бугд 2—3 долоо хоног өгнэ. Тэгэхдээ 5—7 хоног тутамд урьдах хэмжээг 5—10 мг бууруулж өгнэ. Хүүхдэд бол 1 кг жинд 1,5—2 мг-р бодож өгнэ. Мөн цусны сийвен, альбумин тарьж болно. Хоёрдогч халдвэр хавсарсан бол антибиотик өгнэ. Шээс бага гарвал манинитолын 18—20% усмалаас 1 кг жинд 1—1,5 гр хуурай бодис байхаар бодож тарих, эсвэл лазикс өгнэ. Мөн хүчилтөрөгч өмчилгээ хийнэ.

КОМЫН УГТАЛ ҮЕ. КОМЫН ЭМЧИЛГЭЭ. Эмчилгээг сэхээн амьдруулах тасагт хийнэ. Энэ үед хийгдэх өмчилгээ нь:

1. Элгэнд үзүүлэх илүү ажиллагаа дарамтыг бүрэн зайлцуулах.

2. Элэгний эд эсийн үхжилтийг багасган зогсоох.

3. Хордлоготой тэмцэх

4. Ацидоозс гаргах, давс электролитын алдагдлыг тэгшигтгэх, гипокситэй тэмцэх.

5. Комын үед хоёрдогч хүндрэл үүсэхээс сэргийлэх, хүндрэлийг эмчлэх зэрэгт чиглэгдэх ёстой.

Комд орох гэж байгаа буюу комд орсон өвчтөнд уураг, өөх тостой хоол өгөхийг бүрэн хориглоно. Комд байгаа өвчтөнг жимс ногооны шүүс, глюкозын 10—20% усмал, тарааг зэргээр зонд тавьж хооллоно. Хоногт 1500—2000 ккал (6,3—8,4 кдж) хангах хоол өгнэ.

Гэдээс ходоодноос хорт зүйл шимэгдэж цусанд орохыг багасгахын тулд бургуй тавин, 12-хуруу гэдэн дээ зүйлсийг зондоор соруулан авч, ходоод угаанаа. Нарийн будуун гэдэсний орчинт хүчилжүүлж, лактобацийл нянг өсөж уржихэд нь нийллэг замаар гаргаж авсан дисахарид-лактулозийн нөлөөтэй. Ийм учраас комтой өвчтөнд лактулозыг зондоор хоногт 60—100 гр өгнэ.

Элэгний үхжилт үрэвслийн процесс, элэгний өөрийн эд эсийн зэрэг үүссэн бодисын нөлөөг багасгах зорилгоор преднизолоныг хоногт 300—450 мг тарьж хэргэлэнэ. Хүүхдэд бол 5—12 мг/кг бодож тарина.

Өвчтөн комоос гарсны дараа энэ тунг 2—3 дахь хоног дээр нь 1/3-ээр шууд бууруулж болно. Харин цаашид хэрэглэх тунг аажмаар багасгана. Преднизолон нь энэ үед уухаар сольж өгнэ.

ХОРДЛОГОТОЙ ТЭМЦЭХ. Үүний тулд гемодез 400—800 мл (неокомпенсан—100 мл, поливинилийн усмал—200—400 мл) судсан дуслаар хийнэ. Хүүхдэд эдгээр шингэнг 1 кг жинд 10—20 мл бодож тооцоюлоно. Мөн рингер, глюкозын усмалыг нэмж тарина. Амиакийт саармагжуулах зорилгоор глютамины бэллмэлүүдийг хэрэглэнэ. Хоногт хийх шингэний хэмжээ том хүнд 2,5—4,0 л, хүүхдэд 1 кг жинд 120—150 мл байна.

Хүчилтөрөгчийг хамрын зондоор өгч майханд оруулах, содын 2—4% усмалаас 100—300 мл хийх, электролитийн (калийн давст) шингэнг тарих мөн кокарбоксилиз (хоногт 200—400 мг), витамин С (600—800 мг) өгнэ. Цус ба цусны бэллмэлүүд (альбумин, сийвен, шинэ цус) юулнэ. Цуваархаг шинж илэрсэн үед судсаар нь гепариниг 500—1000 нэгжээр 2—3 удаа глюкозын усмалын хамт хэрэглэнэ. Протеолиз үйлчилгээтэй (уураг задлах) ферментийг идэвхгүйжүүлах зорилгоор энэ ферментийн ингибиторуудыг (трасилол, тзалол, контрикал) хэрэглэх нь зохиц үр дун өгнэ. Трасилолыг 75000—100000 нэгж, контрикалыг 300000—500000 нэгжээр тарина.

Шээсний ялгаралтыг байнга анхаарч шээс ховордох үед шээс хөөгч лазикс, манинитол зэргийг тарина. Мөн зурх суласны системийн ажиллагааг дэмжих эм өгнэ. Хэрэв бөөлжөөд байвал түүний бөөлжийг байнга соруулан авч ходоодыг угаанаа.

Жирэмсэн хүн комд орсон байвал ур зулбах, дутуу төрөх, цус алдах зэрэг хүндрэл өгч болно. Комын үед жирэмслэл-

тийг зогсох ямар нэгэн оролдлого нь
өвчнийг улам хүндүүлдэг.

**Комтой өвчтөн үзүүлэх сэхээн
амьдруулах тусламж**

Өвчтөн тайван бус хөөрлийн байдал-
тай бол юуны урьд тайвшруулна. Үүний
тулд седуксин (2—4 мл), ОМК (100
мг/кг), дроперидол, фентанил (2,5—3 мл),
талаанол (2—3 мл) тарина.

Ходоот угааж, цэвэрлэх бургуй та-
вина.

Өвчтөнг ортой нь зөвлөн бэхлэнэ.

Толгой дээр нь баруун сувээгэр нь
хүйтэн жин, давсганд нь байнгын катетер
тавина.

Гемодез, 10% глюкозын уусмал,
рингериин уусмал зэрэг тариаг дуслаар
залгах завсраар нь витамин кокарбокси-
лаз, контрикал, (трасилол), инсулин, ге-
париний тарина. Шингэнг 2—4 мл лазик-
сийн хамт хийнэ.

Хүчилтөргийг хамрын зондоор 1
минутанд 2—4 л байхаар 20—30 мин зай-
тай хоногт 5—6 удаагаас цөөнгүй өгнө.

Содын 2—4% уусмалыг 200—300 мл
хийнэ. Бага насны хүүхдэд зөвхөн 2%
уусмалыг 50—100 мл тарина.

Преднизолоныг хоногт 300—450 мг
зөвхөн тарьж хэрэглэнэ. Тэгэхдээ энэ тун-
гaa 4—5 хувааж хэрэглэнэ.

10—20% албумины уусмал 200—
400 мл, донорын даршилсан шинэ цус
200—500 мл, сийвэн 100—200 мл зэргийг
сольж юуинэ.

Хлорлиг калийн давсан уусмалыг
1 л глюкозын уусмалд 3 гр (хүүрай
бодис) байхаар тооцож тарина.

Антибиотикийг (неомицины хоногт
4—6 гр уулгах, пенициллинг 2—3 сая
нэгжээр тарих) өндөр тунгаар уулгаж 4
цаг тутам хэрэглэнэ. Түүнчилн тариануу-
длыг хүйсний венд (портын вен) катетер
тавиж, гемодиализ ба перитонийн диализ
хийх, өндөр дараалт барокамерт оруулж
эмчилгээ хийх, плазмофорез болон ге-
мосорбцийн аргаар цусыг хорт бодисоос
цэвэрлэх, цус орлон юулэх, өвчтөнийн
цусыг шинэ шусаар бүрэн солих зэрэг арга,
лактулоза, Л—глютамин, интерферон, фибринолиз
идэвхжүүлэгч стрептокиназ, лево-
допа зэрэг эмийг хэрэглэх нь эрчимт эм-
чилгээний үр дүнг эрс нэмэгдүүлнэ.

Холестатик хэлбэрийн гепатиттэй өвч-
төнд цэс хөөгч өм өгөх, зондоор цэс авч
тобаж тавина. Энэ үед ношпа, папаве-

рин зэрэг булчингийн агшилт сүлруулах
эмийг хэрэглэнэ. Хэрэв шар буурахгүй
болон биений байдал засрахгүй үед ГКС-
ийг өгч болно. Мөн новокаины хориг хийх,
зэрэг арга хэмжээ авна.

**Эдгэрэгсдийг диспансерийн хяналтанд
авах журам.**

Вируст гепатитаар өвчлөөд эдгэрсэн
хумус диспансерийн хяналтанд бүрэн
хамрагдсан байна. Аймгийн төвд бол гэ-
дэсний кабинет, халдвартын эмчийн шууд
хяналтанд, сум нэгдэл бол тэндхийн эм-
чийн шууд хяналтанд байна.

Гепатитаар өвчлөөд эдгэрэгсэд өвчинөс
бүрэн эдгэрлээ гэж узтал диспансерийн
хяналтанд байх ёстой. Хяналтанд байх
хугацаандаа эхний жилд 3 сар тутам
нэг удаа, 2 дахь жилд 6 сард нэг удаа
узүүлж шинжилгээ хийлгэнэ. Диспансерийн
хяналтанд байх хугацаанд өвчтөнийн ра-
шаан сувилалд явуулах, группд оруулах,
хүнд хүчир ажлаас чөлөөлөх буюу ажил
өөрчлөх зэрэг арга хэмжээг авна.

Архаг гепатит буюу циррозтой мөн
цесний хүүдийн үрзэсэлтэй өвчтөн тус-
гай бүртгэн, тэдгээр өвчтөнийг шаардла-
гатай үед эмнэлэгт хэвтүүлэх, зохих эм-
чилгээг гэрээр хийх хэрэгтэй. Хяналтанд
байгаа архаг өвчтэй хүн өөр өвчинөөр
өвчилвэл зохих мэргэжлийн эмчид үзүүлж
зөвлөгөө авна. Гепатитаар өвчлөөд эд-
гэрэгсэд хоолны гам, хөдөлмөрийн дэглэм
сахина.

Үрьдчилан сэргийлэх өрөнхий зарчим

А гепатит. Энэ өвчинөс үрьдчилан сэрг-
ийлэхэд хүн амын усан хангамж, ундааны
болон ахуйн усны цэвэрлэгээг сайж-
руулах, цээрлэг, сургууль, хүнсний үйлд-
вэр, худалдааны байгууллагуудын ариун
цэвэр; эрүүл ахуйн болон хүн амын соёлын
түвшинг дээшлүүлэх явдал онцгой аж хол-
богдолтой. Мөн хүн ам, ялангуяа хүүхдийг
нийтээр нь гаммаглобулин тарилганд хам-
руулахад үр дүнтэй байна. Гаммаглобу-
линжуулалтыг зуны дунд сараас эхлэх нь
тохиомжтой.

В гепатит. Донорыг зөв сонгох, эмнэ-
лэг үрьдчилан сэргийлэх байгууллагуудад
янз бурийн тарина, мэс засал, эмчилгээ-
ний ажилбаруудыг цэвэр ариун хийж,
цусны бэлдмэлүүдийг зайлшгүй шаард-
лагаар онц болгоомжтой хэрэглэх явдал
ВГВ-ээс үрьдчилан сэргийлэх үндэс бол-
но.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. A. Ф. Блюгер—Вирусный гепатит.
Рига, 1978.
2. З. А. Бондарь—Клиническая гепато-
логия. М. Медицина. 1970.
3. А. Ф. Блюгер—Практическая гепато-
логия. Рига, 1984.
4. И. В. Гользанд—Заболевания печени
и желчного пузыря у детей. Л. Медицина,
1975.
5. И. Р. Дробинский—Острые вирусные
гепатиты. Киприев. 1972.
6. Д. М. Злыдников, А. П. Казанцев,
П. Д. Старшов—Терапия вирусных болез-
ней. Л. Медицина, 1979.
7. И. Нисевич, В. Ф. Учайкин—Тяжё-
лые и злокачественные формы вирусного
гепатита у детей. М. Медицина, 1982.
8. Д. Подымова—Болезни печени. М.
Медицина, 1984.

9. И. Тодоров—Клинические и лабораторные исследования в педиатрии. София. 1968.
10. Е. М. Тареев, Е. Л. Назеретян, М. Е. Семёнова, И. Е. Тареева—Эпидемический гепатит. М. Медицина, 1970.
11. Н. А. Фарбер—Болезнь Боткина и беременность. М. Медицина, 1970.
12. Руководство по кишечным инфекциям (под ред. И. К. Мусабаева) Ташкент. Медицина, 1980.

Редакций ирсэн 1986. 05. 31

Ш. Бат-Эрдэнэ (*Октябрьин районы нэгдсэн эмнэлэг*)

ЗҮРХНИЙ ЦУС ТАСАЛДАХ ӨВЧНИЙГ ЭМИЙН СОРИЛООР ОНОШЛОХ

Сүүлийн жилүүдэд зүрхний цус тасалдах өвчин ихсэж байгаатай холбоотойгоор уг өвчнийг оношлох боловсронгуй аргыг өргөнөөр эрж хайх боллоо. Хийхэд хялбар, цаг хугацаа бага шаардагддаг үр дүн сайтай оношлогооны нэг арга бол эмийн тусламжтайгаар оношлох арга юм. Бүр 1939 онд Д. Шерф, Веиссверг нар сахарын сорилыг хэрэглэж эхэлжээ. Зүрхний судас нь хатуурсан хүний хураагуур судсанд сахарын өтгөрүүлсэн уусмал юулээд зүрхний цахилгаан бичлэг хийхэд ST гол шугамаас доош бууж өвчүүний ард өвдөх шинж илэрч байлаа гэж мэдээлж байв.

1956 онд зүрх судасны өвчтэй хүмүүст 100—150 г глюкоз уулгаад электрокардиограмм хийхэд ST доош бууж Т шүд татагдан намссан байна.

Үүнийг зүрхний булчинд глюкоз хуримтлагдсанас хүчилтөрөгчийн шаардлага нэмэгдэж титэм судасны далд дутагдлыг илрүүлж байна гэж үзжээ.

Гэвч сахарын сорил төгс хариу ёгч чадахгүй, өөрөөр хэлбэл судасны хатуурал түүний дунд гарах цус тасалдах шинжийг тэр болгон илрүүлж чаддаггүй байна.

Гэвч жил ирэх тутам оношлогооны боловсронгуй аргыг олсоор байна. Тухайлбал индерал, кали, атропин, нитроглецрин зэрэг бэлдмэлээр сорил тавьж оношлож байна.

В—блокатор (хориг) бэлдмэлүүд нь цус тасалдах өвчин юмуу эсвэл мэдрэл зохицолдооны үйл ажиллагааны алдагдлаас болж уу гэдгийг ялгахад дөхөмтэй байна.

40 мг индерал хэрэглэхэд титэм судасны дутагдал, үйл ажиллагааны түр алдагдлын аль аль нь илэрнэ. Ялангуяа симпатик мэдрэлийн нөлөөлөл давамгайлсан уед илүү сайн илэрдэг.

Калийн сорилыг 4—10 г тавиад зүрхний цахилгаан бичлэг хийхэд мэдрэл-тэжээллэгийн улмаас болсон ST ба Т шүдний өөрчлөлг арилсан байдаг.

Энэ сорилоор даавар-мэдрэлийн тогтолцооны хямралаас үүссэн миокардиодистрофийн 74%, титэм судасны цус тасалдах өвчний 18%-д нь баттай хариу гарна.

Уг бэлдмэлээр сорил тавихад гаж нөлөө бараг илрэхгүй боловч хааяа хэвлэй орчмоор өвдөж болно.

Зүрхний гаралтай, зүрхний бус гаралтай өвдөлт хоёрыг ялган оношлохын тулд нитроглецрин уулгаж уг сорилыг тавина. Нитроглецрин нь хураагуур судасны хөвчрөлтөнд илүү нөлөөлж сулруулах бөгөөд тараагуур судсанд шуд бишээр зүрхэнд ирэх, гарах хэсгийн ачааллыг бууруулж үйлчилнэ. Мөн зүрхний дотор давхаргын дорхийн

судсаар цус тархалтын хүчдэл зүрхний булчингийн давхаргын хүчдлийг багасгаж өгдөг.

Титэм судсанд шууд үйлчилж эзлэхүүнийг нэмэгдүүлнэ. Судалгаанаас үзэхэд судасны эзлэхүүнийг 63,7% хүртэл нэмэгдүүлдэг байна. Судасны хатуурал хэт үүссэн уед үйлчилгээ нь сүл байдаг учир сорилыг 0,5 мг-аар уулгаж зүрхний цахилгаан бичлэг хийнэ. Захын мэдрэлийн үйл ажиллагааны зохицолдооны өөрчлөлт хүзүүний ясны мөгөөрс яс мөгөөржих зэрэг өвчний уед зүрхээр өвддөг нь уг бэлдмэлийг хэрэглэхэд намдахгүй. Энэ сорилыг эрүүл хүмүүст хийж зүрхний цус тасалдах өвчнийг оношлох арга болгож хэрэглэвэл үр дүн сайтай.

Судасны ханын хатуурал хэдий чинээ бага байх тутам сорил төдий чинээ үнэн зөв гарах бөгөөд хатуурал ихсэх тутам сорил төгс үнэн байж чадахгүй.

Үйл ажиллагааны түр хямрал, органик өөрчлөлтийг ялгах зорилтоор 0,1% 1—2 мл атропиныг арьсан дор тарихад экстросистол, ховдол тосгуурын дамжих замын хориг арилж байвал үйл ажиллагааны хямрал, дээрх шинж тэмдэг хэвийн юмуу уг өөрчлөлт нэмэгдэж байвал органик өөрчлөлт гэж узне.

Энэ сорилыг хийж байхад экстросистол, пароксизиаль, тахикарди, парасистол илэрч болохыг анхаарах хэрэгтэй.

Хэрэв энэ байдал илэрвэл сорилыг давтах хэрэггүй.

1976 оноос дипиридамол (персантин, курантил) бэлдмэлүүдээр сорил тавьж зүрхний цус тасалдах өвчнийг оношлоход ашиглаж эхэллээ.

Дипиридамол нь титэм судасны цусны эргэлтийг нэмэгдүүлж уг судсыг өргөгчөхдөө судасны хананд өөрчлөлт үүсээгүй хэсэгт нь давамгайлан үйлчилдэг онцлогтой. Эмийн нөлөөгөөр судасны ханын эсэргүүцэл тавигдан өргөсөж, харин өөрчлөлт орсон судсууд улам нарийсан цусан хангамжийн дутагдалд орно. Уг сорилыг хийхдээ 20 г-ын шприцэнд 0,5%-ийн дипиридамолын уусмалыг соруулаад биеийн нэг килограмм жинд 0,75 мг-аар тохируулан эхний 3 минутанд 0,25 мг-ыг кг жинд нь ногдохоор тооцоолно. Өвчтөнийг дээш нь харуулан хэвтүүлж 8 минутын турш аажмаар тараагуур судсаар юулнэ. Энэ тун бүх хэрэглэх ёстой тунгийн турав хуваасны нэг нь байна. Хэрэв клиник болон зүрхний цахилгаан бичлэг хийхэд цус тасалдах өвчний шинж тэмдэг илрэхгүй бол үлдсэн гуравны хоёр тун буюу 0,5 мг-ыг килограмм жинд нь тооцон 5 минутын турш хийнэ. Зүрхний цахилгаан бичлэгийг 12 холболтоор холбож сорилын өмнө, сорилын үед нэг минутын завсарлагатайгаар 15 минутын турш бичнэ. Сорилыг зогсоосноо хойш зүрхний өвдөлт 2 минутаас дээш хугацаагаар үргэлжилвэл 2,4 хувийн 10 мл эуфиллинийг өвдөлт намдаах, зүрхний цахилгаан бичлэгийн өөрчлөлтийг хэвийн болгох зорилгоор тарина.

Цус тасалдах өвчнийг оношлохын түлд хийж байгаа сорилын уед гаж илрэл ховдол тосгуурын экстросистол, толгой өвдөх, бие халуун оргих шинж илэрвэл эуфиллин судсаар тарина. Дээрх сорилыг хийсний дараа зүрхний булчингийн сцинтаграмм хийхэд сорил баттай болсныг нотолдог байна. Зүрхний бах өвчнийг энэ сорилоор 78,8% зөв оношлоно.

Олон судсанд өөрчлөлттэй уед велоэргометрийн сорилоос ч илүү 94,1% хүртэл оношилдог. Дунджаар 0,45—0,75 мг-ыг килограмм жинд бодож тарихад зүрхний цахилгаан бичлэгт гарсан өөрчлөлт мэдэгдэнэ.

1971 онд Вехлер анх изопреналин (изадрин, изопротеронол)-аар сорьж эхэлснээс хойш энэ бэлдмэлүүдээр оношлох нь олширлоо. Изадрич нь V_1 , V_2 адренореценторуудад сонгомол байдлаар үйлчилдэг бөгөөд зүрхний нэгж агшилтаар гарах цусны хэмжээ, агших чадвар нэмэгдэж зүрхний цохилт хурдасна. V_2 рецептор цочирсноос за-

хын судасны агшилт тавигдаж, артерийн даралт буурч, титэм судсаар эргэх цусны эргэлт нэмэгдэнэ. Үлмаар зүрхний цохилт нэмэгдэхийн зэрэгцээ зүрхний нэгж агшилтаар өнгөрөх цусны хэмжээ ихэсэнээс булчингийн хүчилтөрөгчийн шаардлага ихэснэ. Хэрэглэх аргань 0,5 мг изопреналин хлорид (нэг ампул)-ыг 150 мл хлорт натрийн 5 хувийн глюкозын аль нэгэнд найруулаад тараагуур судсанд эхлээд нэг минутанд 2—3 мкг (15—20 дусал)-аар тохируулан, 2—3 минутын дараагаар дуслаа 4—6-гаар хурдасан зүрхний цохилтын тоог нэг минутад 130 болтол хийнэ. Зүрхний цахилгаан бичлэг болон клиникиэр ишеми илрэхгүй бол хугацааг 3 минутаар сунгаад артерийн дараалт, зүрхний цахилгаан бичлэгийг бичиж биеийн байдлыг тогтмол хянана.

Үр дүн нь зүрхний цахилгаан бичлэгт ишеми, өвчүүний ард өвдөх, ST-ийн өөрчлөлт хэлбэрээр илрэх бөгөөд уг өөрчлөлтүүд хураагуур судсаар 2—5 мг обзиданыг 2—4 минут юулэхэд хэвийн болно.

Энэ үед царай улайх юмуу цайрах, зүрх дэлсэх, чамархайн судасны лугшилт ихсэх, ховдол-тосгуурын экстрасистол, толгой эргэх шинжүүд илэрнэ. Велоэргометрийн сорилтой харьцуулахад $69,5 + 62,3$ хувийн үнэн гарах ба зүрхний цус тасалдах өвчний үед 96,9 хувийн үнэн гарна.

Дээрх бэлдмэлийн сорилуудыг эмчилгээнд хэрэглэх бүрэн бололцоотой юм.

Редакцид ирсэн 1986—03—25.

Х. Рагчаасүрэн, Г. Тогтох (Улсын клиникийн төв эмнэлэг)

ТУЙЛШРУУЛАГЧ ХОЛИМГИЙГ ЗҮРХ СУДЛАЛЫН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ НЬ

Өнөө үед клиникийн практикт глюкоз, инсулин, калийн давсаас (Гик) бүрдсэн туйлшууллагч холимгийг өргөн хэрэглэдэг боллоо. Энэ нь зүрхний булчингийн бодисын солилцоог сайжруулах электролитийн тэнцвэржилтийг хангадаг.

1962 онд Д. Sodi-Pallares зүрхний булчингийн үхэжмэлийн голломт дахь электролитийн солилцоог хэвийн болгохын тулд Гик-холимгийг хэрэглэх санааг анх дэвшүүлжээ. Судлаачид Гик-холимгийн эмчилгээний үр дүн сайн болохыг ном хэвлэлд мэдээлж байна (1—8). Эхний үед зүрхний булчингийн шигдээсийн үед хэрэглэж байсан бол одоо хэм алдагдалтай өвчтөнийг эмчлэхэд өргөнөөр хэрэглэдэг боллоо.

Гик-холимгийн гол үйлчилгээ нь зөвхөн зүрхний хэмнэлийг зорхицуулах төдийгүй хэм алдагдал гарахаас урьдчилан сэргийлж зүрхний шигдээсээр нас барагыг багасгадаг (5). Зүрхний булчингийн эсийн мемброн дээр инсулинтай глюкоз эсийн дотор калийг оруулах процессыг ихэсгэдэг ба инсулин нь эсийн мембранаар глюкоз нэвтрэх процессийг ихэсгэдэг ба инсулин нь эсийн мембронаар глюкоз нэвтрэх явдлыг хурдасан, улмаар эсийн дотор глюкоз калийн хуримтлалыг нэмэгдуулж, фосфорын исэлдэх процессыг дээшлүүлэхэд дөхөм узүүлдэг туйлшрах үзэгдлээр үйлчилгээний механизм тайлбарлагдаж байна.

Гик-холимгийг практикт хэрэглэснээс хойш түүний чанарын бүтцийд өөрчлөлт гарсангүй, харин найрлага дахь тооны харьцаа янз бүрээр өөрчлөгдэж иржээ. Өнөө үед туйлшууллагч холимог нь 2—3 рээр өөрчлөгдэж иржээ. Өнөө үед туйлшууллагч холимог нь 2—3 рээр өөрчлөгдэж иржээ. Өнөө үед туйлшууллагч холимог нь 2—3 рээр өөрчлөгдэж иржээ. Өнөө үед туйлшууллагч холимог нь 2—3 рээр өөрчлөгдэж иржээ. Өнөө үед туйлшууллагч холимог нь 2—3 рээр өөрчлөгдэж иржээ. Өнөө үед туйлшууллагч холимог нь 2—3 рээр өөрчлөгдэж иржээ.

Гик-холимгийг клиникийн практикт зүрхний булчингийн хурц шигдээс, түүний хүндэрлээс (хэм алдагдал) урьдчилан сэргийлэх зорилгоор;

— Гипокалиеми, ялангуяа кали дутагдлын хэм алдагдал ээлжийн бус гадна агшилт (экстрасистоли), ховдлын тахикарди

— Кали дутагдалтай холбоогүй болон зүрхний булчингийн органик өөрчлөлтөөс болсон хэм алдагдлын үед хэрэглэж байна.

— Түгшээ цохилт нь бусад эмийн бэлдмэлээр эмчлээд засрахгүй үед Гик-холимогт 10 мл 25%-ийн магни сульфатын уусмал нэмэхэд эмчилгээ сайн болдог. Сульфат магний нөлөөгөөр зүрхний булчингийн сэрэл дамжуулах, сэрэх чадвартай буурдаг байна. Хэрвээ кали тосгуурын түгшээ цохилтын үед нөлөөлдөг бол магни сульфат ховдлын түгшээ цохилтын үед голлон үйлчилдэг. Харин энэ үед артерийн дараалтыг харгалзаж үзэх нь зүйтэй.

Зүрхний булчингийн шигдээс бүхий өвчтөнг Гик-холимгоор эмчлэхэд ховдлын фибрillяци гэнэт болохоос урьдчилан сэргийлэх үр дүнтэй эмийн бэлдмэл юм. Ялангуяа фибринолизин-гепарин Гик-эс бурдсан холимог нь зүрхний шигдээсийн эмчилгээнд маш сайн нөлөөлдгийг судлаачид тэмдэглэж байна (1. 5—6).

Улсын клиникийн төв эмнэлгийн кардиоревматологийн тасагт Гик-холимгийг доорхи найрлагаар хэрэглэж байна. Үүнд:

500 мл 5%-ийн глюкозын уусмал. Инсулин 8—10 нэгж (0,2—0,25)
30 мл—4%-ийн кали хлор.

Шаардлагатай үед энэ холимогт:

— Зүрхний гликозидууд (строфантин, коргликон, догиксин)

— Хэм алдагдлын эсрэг эмүүд (новоканиамид, ксилин, ксикийн, лидокайн, изоптин)

— магни сульфат, кокорбоксилаза

— гепарин, витамин В₁; В₆

— шээс хөөх бэлдмэлүүд (лазикс)

— фибринолизин зэргийг нэмж болно.

УКТЭ-ийн кардиоревматологийн тасагт 1983—1986 онд зүрхний булчингийн хурц шигдээс бүхий 50 өвчтөнд туйлшуулагч холимгийн орчинд зүрхний гликозидоор эмчлэхэд хэм алдагдлын хүндрэл бараг гарсангүй, эмчилгээний сайн үр дүнтэй болох нь харагдлаа. Кали дутагдлын шалтгаантай хэм алдагдлын үед Гик холимгийн орчинд кокорбоксилаза, зүрхний гликозид, новоканиамидыг хамт хийхэд эмчилгээний үр дунгээр сайн болохыг манай клиникийн туршлага харуулж байна. Харин шалтгаан нь гипокалеми биш тогтвортой хэм алдагдал илэрсэн, мөн зүрхний гликозид удаан хугацаагаар хэрэглэснээс болсон хордлогын үед гик-холимог эмчилгээний үр дунгээр сүл байдаг. Гик-холимгийг эмчилгээнд хэрэглэх үед цусан дахь калийг үе тодорхойлж байх шаардлагатай.

Шээс хөөх эмийг хэрэглэж буй үед Гик-холимогт калийн хэмжээг бага зэрэг нэмж өгч болно. Гик-холимгийг венийн судсанд дуслаар хийнэ. Гик-холимгийг зүрхний сэрэл дамжуулалт удааширч алдагдан зурхний цахилгаан бичлэгээр бүтэн хориг илэрсэн өвчтөнд болон бөөрний дутагдлын үед хэрэглэж болохгүй.

АШИГЛАСАН ХЭВЛЭД

1. Г. П. Матвеев и др—Поляризирующие и смеси в неотложной кардиологии. Тер. арх. 1976. 10. 32.
2. М. Я. Руда, А. П. Зыско—Инфаркт миокарда М. 1981. 207.
3. А. В. Сумараков, В. С. Моисеев—Клиническая кардиология М. 1986. 319.
4. Н. К. Фуркало, И. М. Ганджа—Клинические лекции по важнейшим внутренним болезням К. «Здоровье» 1975. 161
5. Е. И. Чазов—Очерки неотложной кардиологии М. 1973. 137.
6. Е. И. Чазов—«Кардиология» 1974. 3. 5.
7. А. З. Чернов, Т. Н. Герчиков—Тер. арх. 1969. 11. 8.
8. З. И. Янушкевичус, И. Н. Блужас—«Кардиология» 1966. 48.

Редакцийд ирсэн 1987. 03. 25.

О. Батсүх, Г. Пүрэвсүрэн (Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн)

ХЭРЛЭГИЙН ГАРАЛТАЙ ЗҮРХНИЙ ГАЖИГТАЙ ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХООЛ

Орчин үед зүрх судасны төрөлхийн ба олдмол гажгийг мэс заслын аргаар амжилттай эмчилж, хэрлэг өвчнийг эрт илрүүлэн, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээний найдвартай аргууд эмнэлгийн практикт амжилттай нэвтэрч байна.

Нөгөө талаар зүрх судасны өвчнийг оношлох оношлогооны орчин үеийн аргууд эмнэлгийн практикт өргөн нэвтэрснээр зүрхний өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх боломжтой болж байна.

Эрдэмтдийн судалгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдийн 0,5—7% ийг зүрхний өвчтэй, үүний дотор хэрлэгийн гаралтай өвчин 70—90% тохиолддог байна. Гэвч зүрхний хэрлэг өвчин сэдрэх, дахих, цусны их бага эргэлтийн алдагдалтай хавсарсан гол судасны болон хоёр хавтаст хавхлагын нарийсал, цусны дараалт ихдэх өвчиний 2, 3 дугаар үе зэрэг зүрхний хүнд өвчиний үед төрөх нь амь насанд аюултай байж болзошгүй юм. Эхийн эндэгдлийн шалтгааны дотор зүрх судасны өвчин нэгдүгээрт байна. Энэ бүхнээс үзэхэд зүрхний өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг эмчлэх, жирэмслэх, төрөхийн үйл ажиллагаатай холбоотой гарах элдэв хүндрэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зөв зохион байгуулах хэрэгтэй байна.

Жирэмсний явцад зүрхний үйл ажиллагааг хэвийн байдалд байлан, эхийн хэвлүй дэх ургийн есөлт хөгжилтийн тохиромжтой нөхцлийг хангахад өвчиний онцлог, үе шат, эмгэг жам, өвчиний явцад тохирсон эмчилгээний хоолыг хэрэглэх нь бие махбодын дасан зохицож чадварыг сайжруулж улмаар зүрх судасны ихэнх өвчиний үед тохиолддог хүчилтөрөгчийн архаг дутагдлыг даван туулах нөхцлийг бүрүүлдэг.

Хэрлэг өвчиний үед бодисын солилцоо, бие махбодын исэлдэх үйл явц дархлал хамгааллын чадвар болон эрхтэн системүүдийн үйл ажиллагаа хямарч, судасны хананы нэвчих чадвар ихэссэн байдаг. Энэ онцлогтой холбоотойгоор жирэмсэн үед хийх бурдмэл эмчилгээний дотор эмчилгээний хоол чухал байр эзэлдэг. Е. М. Тареев (1952), В. Х. Вашленко (1966) нар хэрлэг өвчиний үед тохирсон хоол хэрэглээгүйгээс өвчиний явц идэвхжин дахиснаас бусад хүндрэлд хүргэж болдгийг тогтоожээ.

Хэрлэг өвчиний үед тохирсон эмчилгээний хоолыг хэрэглэх нь хэрлэг өвчиний эмчлэх антибиотик, салицилат, гормон, бодисын солилцооны, витамины зэрэг бусад эмчилгээний үр дүнг сайжруулахад нөлөөлнө.

Хэрлэгийн гаралтай зүрхний өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн хоол нь бие махбодын эсэргүүцэл, дархлал хамгааллын чадвар, бодисын солилцоог сайжруулж улмаар зүрх судасны систем, бөөр, хоол боловсруулах системийн үйл ажиллагааг хөнгөвчилж, бие махбодоос азотын үлдэгдэл бодис ба дутуу исэлдсэн бүтээгдэхүүнийг бүрэн ялтарах нөхцлийг хангасан байх шаардлагатай.

Хэрлэг өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн хоолонд уураг, кали, төмөр, С болон В-гийн төрлийн витаминуудаар баялаг, харин нүүрс үс болон хоолны давсгыг бага агуулсан хоол хэрэглэх хэрэгтэй. Үүний тулд ээдэм, өндөг, загас, алимны шүүс, үзмийг нэмж өгөх буюу талх печень зэрэг хуурай идэх юмны төрлийг багасгана. Ер нь жирэмсэн эмэгтэйчүүдийн хоолонд хоногт хэрэглэх уургийг 120—130 гр-д ялангуяа төгөлдөр уургийн хэмжээг 60%-д хүргэх нь өсөн бойжиж байгаа ургийн хэрэгцээг хангаад зогсохгүй жирэмсэн эхчүүдийн уургийн хэрэгцээг бүрэн хангана.

Судалгаанаас үзэхэд хэрлэгийн гаралтай зүрхний гажигтай жирэмсэн эмэгтэйчүүдэд уургийн солилцоо хямарч цусанд уургийн хэмжээ багасаж ургийн өсөлтөнд зохих хэмжээгээр нөлөөлснөөс төрж байгаа хүүхдийн 25 хүртэл хувь нь тураалтай төрж байгаа тухай судлаачид тэмдэглэсэн байна.

С. И. Крюзловын тогтоосноор хоолны уургийн хэмжээ бага, харин нүурс усны хэмжээг хэвийн хэмжээнд хэрэглэх үед цусан дахь альбуимины хэмжээ багасаж α_2 ба γ глобулины хэмжээ ихэссэнээс хэрлэг өвчний явц идэвхжин сэдэрч байжээ. Харин хэрэглэж байгаа хоолны уургийг нэмж, нүурс усыг тодорхой хэмжээгээр багасгавал биеийн байдал мэдэгдэхүйц сайжирч цусны сийвэнгийн нийт уураг болон альбуимины хэмжээ ихэсч, улаан бөөмийн тунах урвал удааширдаг нь тогтоогджээ.

Мөн жирэмсэн эхийн хэрэглэж буй хоолны бодит байдлыг судалж үзэхэд ургийн жин хэрэглэж байгаа нүурс усны хэмжээтэй шууд хамааралтай байсан бөгөөд хоолондоо нүурс ус, чихэрлэгийн зүйл ихээр хэрэглэдэг эхчүүдээс ихэвчлэн том хүүхэд төрдөг нь тодорхой болсон байна.

Хэрлэгийн гаралтай зүрхний гажигтай жирэмсэн эмэгтэйчүүдийн өөх тосны солилцоо хямралд орж цусанд α —липопротейдын хэмжээ багасаж, липидийн бусад бүлгүүдийн харьцаа алдагддаг ажээ. Иймд хоолны найрлаганд өөх тосыг ялангуяа өөхний ханасан хүчил ихтэй амьтны гаралтай өөх хэрэглэхийг хязгаарлахын хамт ханаагүй тосны хүчил ихээр агуулдаг ургамлын тосыг нийт хэрэглэж байгаа өөх тосны 40 хувьтай тэнцэх хэмжээгээр хэрэглэн, цөцгийн тосыг 20—30 граас хэтрүүлэхгүй байх шаардлагатай юм.

Хэрлэгийн гаралтай зүрхний гажигтай хүмүүсийн калийн зарцуулалт ихэссэнтэй холбоотой түүний хэмжээ эд эсэд багассан байдаг. Ялангуяа шээс хөөх болон дааврын (гормон) эмчилгээ хийсэн үед шээсээр их хэмжээний кали ялгаран гардаг тул бие маҳбод калийн дутагдалд орно. Ийм учраас хоолонд кали элбэгтэй байцаа, төмс, тараг, бяслаг, үзэм зэрэг бүтээгдэхүүнийг өргөнөөр хэрэглэх нь зүйтэй.

Жирэмсний 2-р хагаст хоолны давсыг 3—4 гр хүртэл багасгана. Гэвч давсыг удаан хугацаагаар хэт хязгаарласнаас эхийн биед натрийн давс хуримтлагдан хаван уусч бие маҳбодод хлор дутагдсан шинж илэрнэ.

Жирэмсний сүүлийн гурван сард хоолны давсны оронд саносол хэрэглэх нь илүү ашигтай. Саносолын найрлагад кали хлорид 60%, лимон хүчлийн кали 10%, глюконат кальци 10%, магни аспаригинат 5%, аммони хлорид 10%, глютамины хүчил 5% тус тус ордог. Саносол нь шээс хөөх эмийн үйлчилгээг сайжруулахын зэрэгцээ шусанд кали багасах үйл явцыг saatuuulna. Саносолыг 2-р хоолонд 1,5—2 гр хийж хэрэглэнэ.

Зүрхний гажигтай эмэгтэйчүүдэд витамины солилцоо хямардаг тул ялангуяа С болон В-гийн төрлийн витаминуудыг ердийнхөөс арай илүү хэрэглэх шаардлагатай байдаг. В-гийн төрлийн витаминууд бодисын солилцооны исэлдэн ангижрах процесс, төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг хэвийн болгоод зогсохгүй бие маҳбодын эсэргүүцлийг сайжруулахад идэвхтэй оролцож цусны улаан бөөм болон гемоглобин үүсэх үйл явцыг хурдасгана. С витамин биеийн эсэргүүцлийг сайжруулахын хамт эд эсийн нөхөн төлжих явдлыг түргэсгэж беөрний дээд булчирхайн үйл ажиллагааг идэвхжүүлнэ. Ийм учраас хоногт 200—250 мг аскорбины хүчлийг өгөх нь зүйтэй.

Мөн элэгний үйл ажиллагаа хямарсан байдаг тул хоолонд липотрофны үйлчилгээтэй ээдмийг заавал хэрэглэх нь ашигтай. Ер нь хоолны цэсийг зохиохдоо юуны өмнө хэрлэг өвчний идэвхжлийг харгалзаж үзэх нь чухал.

Хэрлэгийн гаралтай зүрхний гажигтай, дунд хэрийн нуруутай (155—165 см), 55—60 кг жинтэй жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний эхний хагаст хоногт хэрэглэх хоолны найрлагыг дараах байдлаар сонгон авах нь зүйтэй. Үүнд: уураг (110—120 гр), өөх тос (70—80 гр) нүүрс ус (250—300 гр) нийт илчлэг нь 2400—2700 ккал.

Жирэмсний 2-р хагаст хоолонд хоногт 120—130 гр уураг, 80—90 гр өөх тос, 300—350 гр нүүрс усыг хэрэглэх бөгөөд хоолны илчлэг нь 2800—3000 ккал байна.

Эхчүүдийн хорлонд өөх багатай мах, сүү, тараг, ээдэм, шинэ ноогоо, жимс зэргийг өргөнөөр хэрэглэх ба тарган мах, давсалсан, утсан бүтээгдэхүүн, өтгөн цай, кофе архины зүйлийг хориглоно.

Өдөрт 5—6 удаа хооллоно.

Редакцид ирсэн 1986—03—28.

Г. Навчсан, Г. Оросоо, Д. Энэбиш (*Эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн*)

ТӨМӨР, ЗЭСИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Одоогоор хүний бие махбодод 70 орчим бичил язгуур элемент агуулагдаж байгааг Э. Андервуд үл орлогдох (төмөр, иод, зэс, цайр, марганец, кобальт) орлогдох (фтор, бром, мөнгө), физиологийн идэвхит үйлчилгээ нь одоогоор тодорхойгүй (рубидий, мышьяк гэх мэт) гэж З ангилж байна.

Бичил язгуур элементийн идэвх нь витамин, даавар, эсэг зэргийн найрлага бүтцэнд оролцдог төдийгүй өсөх хөгжих, үржих, цус төлжих зэрэг амьдралын чухал үйлдлийн нөхцлийг бүрдүүлнэ (1, 10).

Бие махбодод бага хэмжээгээр агуулагдах амьдралын чухал шаардлага бүхий 10^{-3} — 10^{-12} химийн язгуур элементийг бичил язгуур элемент гэнэ. Бичил язгуур элементийн биологийн үүргийг сүүлийн үед их судлах боллоо. (6). Эдгээр бичил язгуур элементээс төмөр, зэсийн уурэг, биологийн ач холбогдлыг нэлээд судалж байна. Хүний бие махбодод ойролцоогоор 4—5 г төмөр агуулагддаг. Бие махбодод зайлшгүй хэрэгтэй төмрийн ихэнхийг амьтны ба ургамлын гаралтай хоол тэжээлийн хамт, үлэмж бага хэсгийг устай хамт авдаг. Хүний бие махбодын төмрийн 60—70% гемоглобинд, 3—5% булчингийн миоглобулинд, 16% ферритин ба гемосидеринд агуулагдах ба үлдсэн хэсэг нь төмөр агуулдаг каталаза, пероксидаза, цитохром гэх мэт 13 эсэгийн найрлаганд ордог (3). Хүний цусны сийвэнд 0,1% орчим төмөр трансферрин байдлаар агуулагдана. Цусны гемоглобин бол глобин хэмээх уураг, төмөр агуулсан гем 2-оос тогтсон нийлмэл уураг юм. Гем нь протопорфирийн төмөртэй нэгдсэн нэгдэл мөн. Орчин үед гемийн нийлэгжих зам нь тодорхой судлагдажээ. Гемийн био нийлэгжлийн үе шат нь тодорхой бүлэг эсэгүүдийн тусламжаар явагддаг. Гемийн нийлэгжил алдагдах гол шалтгаан нь эритробластад агуулагдах төмрийн дутагдал юм.

Бие махбодод тодорхой хэмжээгээр агуулагддаг нөөц төмөр нь маш их «гамтай» зарцуулагддаг байна. Гемоглобины задралын үед чөлөөлөгдсөн төмөр нь ферритин байдлаар хадгалагдаж гемоглобин дахин нийлэгжихэд оролцоно. Хөлс ба шээсээр төмөр бага ялгарна. Ясны чөмгөнд хоногт хэрэглэгдэх төмрийн хэрэгцээг 5 дахин хангах хэмжээний «хэлбэрийн төмөр нь» цусны сийвэнгийн төмөртэй богино хугацаанд солилцоонд орох чадвартай байдаг. Элэг, дэлүүнд нэлээд хэмжээний төмөр агуулагдана. Бие махбодын хэрэгцээтэй зохицож төмөр шимэгдэж байдаг учраас хэрэгцээ шаардлагагүй үед хоолтой хамт орсон төмөр бараг тэр хэвээрээ өтгөнөөр гардаг.

Төмөр нь ходоод, 12 хуруу гэдэс, нарийн гэдэсний эхний хэсэгт шимэгдэх бөгөөд органик биш төмөр органикаасаа илүү шимэгдэнэ. Ходоодны шүүсний хүчиллэг чанараас хамаарч хоол хүнсний төмөр ионжсон хэлбэрт шилждэг. Ингэж ионжсон төмөр органик төмрийг бодвол амархан шимэгдэнэ.

Зарим бодисууд, тухайлбал: аскорбины болон давсны хучил төмрийн шимэгдэлтийг сайжруулдаг бол фосфат, фитин зэрэг бодис саатуулдаг. Жирэмслэх, цус алдах, хүүхэд хөхүүлэх, биений хүчний хүнд хөдөлмөрийн уед бие маходод төмрийн хэрэгцээ нэмэгдэнэ. Уураг багатай хоол хүнс хэрэглэх уед төмөр шимэгдэх нь удааширна. Мэн өөх төс ихтэй хоолны төмөр муу шимэгдэнэ (5, 7).

Шимэгдсэн төмөр нь элгэнд үүсдэг цусны сийвэнгийн уураг трансферрины тусламжаар чөмгөнд зөөгдөн очиж гемоглобины гемийн нийлэгжилтэнд оролцох буюу элгэнд ферритин, гемосидерин байдлаар нөөцлөгдөнө. Төмрийн солилцоо дараах байдлаар явагдана.



Хүүхэд төрөхдөө төмрийн зохих нөөцтэй байдаг ба 4—5 сар болтлоо төмрийг гаднаас авахгүй байсан ч төмөр дутагдахгүй. Харип ихэр, дутуу төрсөн хүүхдийн нь төмрийн нөөц 2—3 сартайд дуусна. Энэ үеэс хүүхдийг нэмэгдэл хоолонд оруулахгүй бол төмөр дутал болно.

Төмөр нь цусанд өглөөгүүр арай их, өдөр тийшээ буурч оройд бага байдаг нь ажиглагджээ. Төмрийн дутлын уед эхлээд нөөц төмрийн хэмжээ, дараа нь зөөврийн төмөр багасч төмөр агуулсан тодорхой энзимиин тогтолцооны идэвх алдагдаж эцэст нь гемоглобини нийлэгжилт saatdag байна. Төмөр түүний солилцоо алдагдал нь бие маходод төмөр дутлын цус багадалт үүсгэнэ. Төмрийн дутал үүсэх шалтгаан олон янз байдаг. Төмөр дутлыг туйлын ба харьцангуй гэж хоёр хуваана. Туйлын дутал нь төмөр шингэх, шимэгдэх явц саатах, төмөр багатай хоол хүнс хэрэглэх, архаг цус алдалт зэрэг тохиолдолд үүснэ. Энэ нь төмрийн нөөц үнэхээр багассаныг гэрчлэх цусны ийлдэсний төмөр, гемоглобини багасалт, эритроцитын эритрофоририны хэмжээ ихсэх байдлаар илрэнэ.

Чөмөгний эритробластуудад агуулагдах төмөр багасахад порфирийн үүсэх нь үргэлжлэн ихсэж гем үүсэхэд хэрэглэгдэх хэмжээнээс илүү гарах тул эритроцитын протопорфирийн ихэсдэг байна. Чөмгөнд сидеробластуудын хэмжээ багасч, заримдаа эритроцитын амьдрах хугацаа богиносдог (2).

Төмрийн харьцангуй дутал нь халдварт, үрэвслийн гаралтай өвчнүүд, хавдрын хордлогын уед илрэнэ. Цус багадалтын шинжгүй төмрийн дутлыг далд дутал гэж нэрлэж байна. Хэвлэлд тэмдэглэснээр төмрийн далд дутал төмөр дутлын цус багадалтаас 2—3 дахин элбэг байдаг байна (9).

Төмөр нь металл агуулсан олон тооны эсэгүүдийн нийлэгжилтэнд оролцон хүүхдийн өсөлт хөгжилт, эд эрхтний нөхөн телжилт, цус

төлжилт, эдийн амьсгал, дархлаа, урвалж чанар болон физиологийн бусад үйл ажиллагаанд оролцдог.

Төмөр дутлын өвчнөөр төрөх насын эмэгтэйчүүд, хүүхэд өвчлөх нь илүү байна. Судалгаанаас үзэхэд 2 хүртэлх насын хүүхдийн 40%, бэлгийн бойжилтын насын хүүхдийн гуравны нэгд төмөр дутал илэрчээ. Төмөр дутсанаас хүүхдийн фагоцитозын микробыг боловсруулах шатанд өөрчлөлт гарч, иммуноглоблин M ихсэж, иммуноглобулин A ба T лимфоцит багасаж байжээ.

Зэс нь хүний бие махбодод зайлшгүй шаардлагатай солигдошгүй, физиологийн олон үйл ажиллагаанд оролцдог биологийн өндөр идэвх бүхий бичил язгуур элемент болох нь батлагджээ. Зэс нь органик биш төмөр органикжих явцыг нөхцөлдүүлж гемоглобини нийлэгжилт, төмөр цус төлжүүлэгч эрхтэн чөмөг рүү тээвэрлэгдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ (4, 6).

Зэс супероксиддисмутаза, цитохромоксидаза зэрэг олон эсэгийн найрлаганд оролцож эд эсийн амьсгал, цус төлжилт, эластен, коллаген, фосфолипидийн нийлэгжил, төмрийн солилцоонд идэвхтэй оролцно. Сүүлийн жилүүдэд хийсэн судалгаа нь зэс агуулдаг болон зэсээс хамааралтай эсэгүүд нь төмрийн солилцоонд оролцдог болохыг баталж: энэ 2 бичил язгуур махбодын чухам аль нь дутагдаад цус багадалт үүсэхийг тайлбарлахыг орлдож байна.

Цусанд зэс хүрэлцэхүйц хэмжээтэй байхад гемоглобини нийлэгжилт, улаан цогцосны торнилт боловсролт, төмөр органикжих, тээвэрлэгдэх явц түргэсэж, зэс дутагдаад фероксидаза эсэгийн идэвх суларч цусны гемоглобин ба төмрийн хэмжээ багасаж, эритроцитын амьдрах хугацаа богиносож нөхөн торнилт удааширдаг байна.

Зэс шууд буюу дам замаар ясжилтанд нөлөөлдөг болох нь батлагдаж (А. Ф. Тур, Я. Фриден, А. Р. Вальдман) ясны гэмтэл бэртлийн үед явагдах биохимиийн нийлмэл урвалууд, ясны нөхөн төлжилтэд оролцдог байна.

Өсөн торниж буй бие махбодын хоол тэжээлд зэс дутагдаад сульдаа өвчинтэй тестэй өвчин үүсэхийг Аррингтон, Давис нар мэдээлжээ. Хоолны зэс нэмэгдэхэд кальций, фосфорын солилцоо сайжирч өвчний эдгэрэлт түргэссэн байна.

Бие махбодод шаардагдах зэс хоол хүнсний хамт, өчүүхэн хэсэг нь ўстай хамт биед орно. Ой хүртэлх насын хүүхдийг зөв хооллосон үед биений 1 кг жиндээ 65 мкг зэс авч байвал хоол ундны зэсийн 27—88% шингэж хүүхэд зэсийн дуталд ордоггүй ажээ.

Бие махбодын зэсийн 50% нь эритроцитод тэр тусмаа супероксиддисмутаза ферментэнд, бусад нь цусны сийвэнгийн церулоплазмийн холбоотой байдаг.

Бичил язгуур махбод зэс дутагдаад хүүхдийн мэдрэл, сэтгэхүйн хөгжил saatаж, булчингийн чалх (тонус) суларч, арьсны нөлөөжилт, ясжилт муудаха, дэлүү томрох, цус багадах зэрэг шинж илэрнэ. Бодисын солилцооны төрөлхийн болон удамшлын гаж дутал, эмгэг явцтай жирэмслэлт, хүүхдийг угжих, насанд нь тохируулалгүй хооллох зэрэг олон хүчин зүйл зэсийн дуталд хүргэнэ. Туршлагын амьтдыг зэс багатай хоолоор хооллоход ясны зэс, 8%, тархины зэс 31%, зурхний зэс 42%, улаан цогцсын зэс 76%, цусны сийвэнгийн зэс 96% багасаж байжээ.

Хүүхдэд хоногт шаардагдах төмрийн хэмжээ 0—4 сартайд 0,5 мг, 5—12 сартайд 0,7 мг, 1—12 настайд 1,0 мг, 13—16 настай хөвгүүдэд, 1,8; 13—16 настай охидод 2,4 мг байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. М. Ф. Дешекина, В. Ф. Демин, М. В. Колтунов, С. О. Ключников—Педиатрия, 1985, 4, 73—75.
2. Л. М. Казакова—Педиатрия 1982, 11, 31—33.
3. Т. И. Лукичева, И. М. Прудник—Лабораторное дело, 1983, 5, 24—26.
4. В. В. Насолодин—Вопросы питания 1984, 4, 12—16.
5. В. В. Насолодин—Вопросы питания, 1983, 3, 12—18.
6. Л. П. Рощеткина—Микроэлементы в педиатрии. ВОМД, 1966, 1, 53—58.
7. И. А. Седискверазде, Е. Н. Стafeева, Т. Б. Кочергина—Вопр. охр. мат. и дет. 1983, 11, 17—18.
8. А. Ф. Тур—Гематология детского возраста. М. 1963,
9. Н. Г. Шевченко, Р. П. Марцищевская—Лабораторное дело 1983, № 1, 52—56.
10. Вопр. охр. мат. и дет. 1984, 4, 11.

Ш. Баяртогтох (*Anagaah ухааны хүрээлэн*)

ХЭРЛЭГ ӨВЧИН ДАХИХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Хэрлэг өвчин нь цус задлах А бүлгийн стрептококкоор үүсдэг халдварт харшлын архаг өвчин бөгөөд үе үе хурцдаж даихих, хүндрэх хандлагатай байдаг. Иймд хэрлэг өвчин дахихаас урьдчилан сэргийлэх нь чухал аж холбогдолтой ба үүнийг хоёрдогч урьдчилан сэргийлэлт гэнэ.

Хэрлэгийн хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг бициллин-аспириннаар өргөн хийж байна. Энэ нь улирлын ба бүтэн жилээр хийх гэж хоёр янз байдаг. Урьдчилан сэргийлэлтийг насанд хүрэгчдэд ба хүүхдэд үйлчилдэг амбулатори-поликлиник, хэсэг, бригад, сумын эмч, үйлдвэр-цехийн ба кардиоревматолог кабинетын эмч нар гардан явуулна.

Бициллиний урьдчилан сэргийлэлт гэдэг нь урт хугацаагаар цусанд хадгалагдан үйлчилдэг пенициллины бэлдмэл (бициллин)-ийг тарьж аспириныг хавсран уулгана. Үнд:

Бициллин-3 нь 60000 нэгж тунгаар байх ба түүнийг зургаан хоногт 1 удаа булчинд тарина. Харин Бициллин 5 нь 1500000 нэгж тунгаар байдаг ба түүнийг 4 долоо хоног буюу сард нэг удаа тарих заавартай байдаг.

Бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийг хийхэд Бициллин-5-ыг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл түүнийг сард 1 удаа тарина гэж бодоход жилдээ 12 удаа, 2 жилд 24 удаа гэх мэтчилэн тарина. Үүнийг бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийн 1 дүгээр арга гэж нэрлэв. Бициллин-5-ыг сургуулийн өмнөх насны хүүхдэд 750000 нэгжээр 3 долоо хоногт 1 удаа, 8-аас дээш насны хүүхдэд 1200000 нэгжээр 4 долоо хоногт 1 удаа тус тус тарьдаг. Хэрлэг өвчин дахихаас сэргийлэх улирлын урьдчилан сэргийлэлтийг хийхдээ Бициллин-3 буюу 5-ын алиныг нь ч хэрэглэж болно.

Аль ч урьдчилан сэргийлэлтийн үед аспириныг хавар, намарт зохих зааврын дагуу хавсран хэрэглэх шаардлагатай.

Бициллины улирлын урьдчилан сэргийлэлтийг хэрлэгийн хөнгөвтөр явцтай, өвчин нь идэвхжил багатай хүмүүст хэрэглэж, бүтэн урьдчилан сэргийлэлтийг хэрлэгийн өндөр идэвхжилтэй зүрхний гажигтай хүмүүст хэрэглэнэ. Үүнээс гадна хэрлэгийн хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн үр дүнг сайжруулахын тулд бүтэн жилээр хийдэг. Бициллин-5 тарилгыг сард нэг удаа тарьдаг аргыг өөрчлөн хэрлэгийн хүнд хэлбэрийн гажигтай, тасралтгүй дахилт бүхий явцтай өвчтөнүүдэд Бициллин 5 тарилгыг 3 долоо хоног буюу 21 хоног давтан тарьж байх шинэ аргыг хэрэглэх нь зүй-

тэй. Үүнийг бид бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийн 2 дугаар арга гэж нэрлэв.

Энэ аргаар урьдчилан сэргийлэлтийг 1—1,5 жил явуулсны дараа 1 дүгээр аргаар хийх бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтэд шилжүүлж, 3,5—4 жил урьдчилан сэргийлэлтийг тасралтгүй үргэлжлүүлэн хийж болно. Зүрхний гажгийн хэлбэр, зүрхний томролт, цусны эргэлтийн дутагдал, өвчилсөн жил, насын байдлыг харгалзан ямар аргаар хэдий хугацааар урьдчилан сэргийлэлтийг хийх тухай зааврыг хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт I

Хэрлэг ба түүний гаралтай зүрхний гажиг өвчний үед хяналтын үзлэг ба Урьдчилан сэргийлэлт хийх

| Өвчний онцгай | Өвчтөний ангилал | Давтан Үзэх хугацаа | | Урьдчилан сэргийлэлтийг хийх арга, хугацаа |
|---|---|-------------------------|--------------------------|--|
| | | Хэсэг, бригад сумын эмч | Аймаг, хотын зүрхний эмч | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Зүрхний гажиг-гүй ревмокардит, хэрлэгийн полиартрит, хореи зэргээр өвчилсөн байх. | A. Өвчний сүүлчийн дахилтаас хойш 3 буюу түүнээс цөөн жил болсон, 20 хүртэл настай. Б. Сүүлчийн дахилтаас хойш 4 буюу 5 жил болсон, 20—29 настай. В. Сүүлчийн дахилтаас хойш 6 буюу дээш жил болсон, 30 буюу түүнээс дээш-настай. | 3 сар тутамд | Жил бүрд 1 удаа | Улирлын УС-ийг 5-аас доошгүй жил |
| Митраль хавхлагын дутмагшил | 1. А. ЗТ байхгүй, сүүлчийн дахилтаас хойш 3 буюу түүнээс цөөн жил болсон, 29 буюу түүнээс доош настай. 1. Б. ЗТ байхгүй, сүүлчийн дахилтаас хойш 4 буюу түүнээс дээш жил болсон, 30 буюу дээш настай | 2 сар тутамд | Хагас жилд 1 удаа | Улирлын УС-ийг 5-аас доошгүй жил |
| | | 3 сар тутамд | 2 жил бүрд | Улирлын УС-ийг 5-аас доошгүй жил |

Хүснэгтэн дэх товчилсон үгийн тайлбар:

УС—урьдчилан сэргийлэлт

ЗТ—рентген ба бусад бодит үзлэг шинжилгээнд зүрх томрох шинж тэмдэг байх.

ЦЭД—Цусны эргэлтийн дутагдал

ЦД—Цусны даралт

ПД—пульсын даралт

ЗЦБ—зүрхний цахилгаан бичлэг

Хэрлэгийн хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг доорхи 3 хэлбэрээр хийж болно. Үүнд:

| | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|--------------|-------------------|---|
| | 2. А. ЗТ байх, ЦЭД байхгүй, сүүлчийн дахилтаас хойш 3 буюу цөөн жил болсон, 29 буюу доош настай. | 2 сар тутамд | хагас жилд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 1-р аргаар 3 жил хийж, өвчиний дахилт даамжрах шинж гарагчийг байвал улирлын УС-д шилжүүлэн 2-оос доошгүй жил |
| | 2. Б. ЗТ байх ЦЭД байхгүй, сүүлчийн дахилтаас хойш 4 буюу түүнээс дээш жил болсон, 30 буюу дээш настай. | 2 сар тутамд | жил бүр 1 удаа | Бүтэн жил УС-ийг 1-р аргаар 2 жил хийж, дараа нь улирлын УС-д шилжүүлэн 3-аас доошгүй жил |
| | 3. ЗТ ба ЦЭД хоёулаа байх. | 1 сар тутамд | улиралд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 1 дүгээр аргаар 3 жил хийж, өвчин нь даамжрахгүй байвал улирлын УС-д шилжүүлэн 2-оос доошгүй жил |
| Митраль хавхлагын нарийсалт, тэр нь дутмагшилтай хавсарсан байх гажгийн тохиолдлууд | 1. А. ЗТ байхгүй, сүүлчийн дахилтаас хойш 3 жил буюу түүнээс цөөн жил болсон, 29 буюу түүнээс доош настай | 2 сар тутамд | хагас жилд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар аргаар 1,5 жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 3—5-аас доошгүй жил |
| | 1. Б. ЭТ байхгүй. Сүүлчийн дахилтаас хойш 4 буюу дээш жил болсон, 30 буюу дээш настай | 3 сар тутамд | жил бүр 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар аргаар 1 жил, дараа нь 1-р аргаар 4-өөс доошгүй жил |
| | 2. А. ЗТ байх. ЦЭД байхгүй, сүүлчийн дахилтаас хойш 3 буюу цөөн жил болсон, 29 буюу доош настай | 1 сар тутамд | улиралд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар аргаар 1,5 жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 3,5-аас доошгүй жил |
| | 2. Б. ЗТ байх. ЦЭД байхгүй. Сүүлчийн дахилтаас хойш 4 буюу дээш жил болсон, 30 буюу дээш настай | 2 сар тутамд | жил бүрд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар аргаар 1 жил, дараа нь 1 дүгээр аргаар 4-өөс доошгүй жил |
| | 3. ЗТ ба ЦЭД хоёулаа байх | 1 сар тутамд | улиралд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар аргаар 1,5 жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 4-өөс доошгүй жил |
| Гол судасны дутмагшил | 1. А. ЗТ байхгүй. ЦД ихдээгүй сүүлчийн да- | 2 сар тутамд | хагас жилд | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|--|---|----------------------|-------------------|---|
| | хилтаас хойш 3 оюу түүнээс цөөн жил болсон. 29 буюу түүнээс доош настай. | | 1 удаа | аргаар 1 жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 4-өөс доoshгүй жил Бүтэн жилийн УС-ийг 1 дүгээр аргаар 5-аас доошгүй жил |
| | 1. Б. ЗТ байхгүй. ЦД хэвийн сүүлчийн дахилтаас хойш 4 буюу дээш жил бэлсон, 30 буюу дээш настай. 2. А. ПД ихтэй, сүүлчийн дахилтаас хойш 3 буюу доош жил болсон, 29 буюу доош настай. | 3 сар тутамд | жилд 1 удаа | Бүтэн жилийн УС-ийг 2 дугаар аргаар 1,5 жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 4-өөс доошгүй жил Бүтэн жилийн УС-ийг 5-аас доошгүй жил |
| | 2. Б. ПД ихтэй, ЗТ-той, эсвэл үгүй, сүүлчийн дахилтаас хойш 6 буюу дээш жил болсон. 3. ЦЭД-тай, ЗТ байх, зүрх хүчтэй өвддөг ба түр ухаан алддаг, унадаг. | 2 сар тутамд | хагас жилд 1 удаа | Бүтэн жилийн УС-г 2 дугаар аргаар 1,5 жил, 1 дүгээр аргаар 4-өөс доошгүй жил Бүтэн жилийн УС-г 5-аас доошгүй жил |
| Гол судасны нарийсалт | 1. Өвчний хам шинж тэмдэггүй. Рентген ба ЗЦБ хэвийн. 2. Өвчний хам шинж тэмдэггүй, рентген буюу ЗЦБ-т өөрчлөлттэй. 3. Зүрх хүчтэй өвддөг. ЦЭД-тэй буюу түр ухаан алдаж унадаг. | 3 сар тутамд | жил бүр 1 удаа | Бүтэн жилийн УС-г 2 дугаар аргаар нэг жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 4-өөс доошгүй жил Бүтэн жилийн УС-г 5-аас доошгүй жил |
| Хоёр ба түүнээс олон хавхлагын хамтарсан гажиг | Ямар хавхлаг их гэмтэж давамгайлсан байдлыг харгалzan тэр хавхлагын гэмтэлд мөрдвэл зохих үзлэг, УС-ийн дэглэмийг баримтлах хэрэгтэй. Жич: митрээ хавхлагын дутмагшил давамгайлсан байвал, митраль хавхлагын нарийсалт дутмагшилтай хавсарсан тохи лдлын үед баримтлах УС-ийн дэглэмийг мөрдвэл зохино. | 3 долоо хоног тутамд | Улиралд 1 удаа | Бүтэн жилийн УС-г 2 дугаар аргаар 1,5 жил хийж, дараа нь 1 дүгээр аргаар 4-өөс доошгүй жил |

1. Зүрхний хүнд хэлбэрийн гажигтай, хэрлэгийн явц нь идэвхжлийн 2 буюу 3 зэрэгтэйгээр явагдсан, удааширсан буюу тасралтгүй дахилт бүхий явцтай ревмокардиттай өвчтөнүүдэд бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийг 2 дугаар аргаар эхлэн хийж, дараа нь 1 дүгээр аргаар үргэлжлүүлэн хийх.

2. Хэрлэгийн үе мөчний хэлбэрийн өвчинтэй буюу зүрхний гажиггүй ревмокардит бүхий, өөрөөр хэлбэл хөнгөн хэлбэрийн хэрлэг өвчинтэй хүмүүст улирлын урьдчилан сэргийлэлт явуулах

3. Зүрхний хөнгөн хэлбэрийн гажигтай хоёр хаваст хавхлагын дутмагшил, хоолойн гүйлсэн булчирхайн архаг идээт үрэвслийн өвчлөл цөөнтэй буюу хоолойн гүйлсэн булчирхайд мэс засал хийлгэсэн өвчтөнд бүтэн жилний урьдчилан сэргийлэлтийг 1 дүгээр аргаар эхний 2—3 жил хийж, дараа нь улирлын урьдчилан сэргийлэлтэд шилжүүлэн оруулах буюу эсвэл бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийг 1 дүгээр аргаар 5-аас доошгүй жил хийх.

Хэрлэгийн хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг үргэлжлүүлэн явуулах хугацааг ерөнхийдөө таваас доошгүй жил гэж тооцвол зохих ба харин зүрхний хүнд хэлбэрийн гажигтай, зүрх даамжран гэмтэх хандлагатай, хоолойн гүйлсэн булчирхайн архаг идээт үрэвсэлд мэс заслын эмчилгээ хийлгээгүй, мөн өвчтөний насын байдал 29 буюу доош настай байх зэрэг нөхцөлд урьдчилан сэргийлэлтийг 5-аас доошгүй жил хийсний дараа цаашид үргэлжлүүлэх асуудлыг эмч нарын зөвлөлгөөнөөр шийдвэрлэж байвал зохино.

Бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийн 2 дугаар аргыг дор дурдсан тохиолдуудад хэрэглэнэ. Үүнд:

1. Зүрхний хэрлэгийн хүнд хэлбэрийн гажиг, тухайлбал 2 хаваст хавхлагын нарийсалт, энэ гажиг уг хавхлагын дутмагшилтай хавсран давамгайлсаа байх, эсвэл зүрхний тосгуурын жирвэлзэх хэм алдагдлаар хүндэrsэн тохиолдол, уг гажгийн үед хэрлэгийн дахилт 2 буюу 3 дугаар зэргийн идэвхжилтэйгээр явагдсаны дараа:

2. Гол судасны нарийсалт ба дутмагшил гажигтай өвчтөн аль ч хэлбэр байсан, тэр үед хэрлэгийн дахилт II буюу III зэргийн идэвхжилтэйгээр явагдсаны дараа

3. Зүрхний анхдагч хэрлэг нь идэвхжлийн 3 зэрэгтэйгээр илэрсэн тохиолдолд эсвэл панкардит байх, идэвхжлийн ийм зэрэгтэй ревмокардит нь перикардиттai буюу полисерозиттai хамт байх. Ревмокардитын үед зүрх даамжран гэмтэх, өвчин нь удааширсан эсвэл тасралтгүй дахилт бүхий явцтай байх.

4. Дээр дурдсан зүрхний гажиг ба идэвхжил ихтэй ревмокардит нь уг өвчтөнд тохиолдсон төрөлт ба үр хөндөлтийн үед анхдагчаар буюу дахилтаар өвчилсөн байх

5. Мөн дурдсан гажиг ба идэвхжил ихтэй ревмокардигаар өвчилсөн өвчтөн нь уг өвчнөөр өвчлөхөөс өмнө сүүлийн 2—3 жилийн хугацаанд хоолойн гүйлсэн булчирхайн архаг идээт үрэвслээр олон удаа өвчилж, уг хоолойн өвчинд мэс заслын эмчилгээ хийлгээгүй байх зэрэг тохиолдолд дээрх аргаар урьдчилан сэргийлнэ

Хэрлэгийн дахилтаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар аргаар, хэдий хугацаагаар хийх асуудлыг шийдэхдээ 1 дүгээр хүснэгтийн оношийн ба өвчтөний ангиллыг гол болгон баримтлах ба өвчтөний насын байдал, сүүлчийн дахилтын дараах эхний жилүүд (1-ээс 3 жилийн дотор), мөн зүрхний томролт ба цусны эргэлтийн дутагдлын байдал, сүүлчийн дахилтын үед хэр зэрэг өндөр идэвхжилтэй өвчилсөн, тэр үед өвчний явц ямар байсан болон хоолойн гүйлсэн булчирхайн үрэвсэл байгаа эсэхийг харгалзан үзэх нь чухал. Тухайлбал: өвчин дахих үедээ ялангуяа хүүхэд, залуу насын хүмүүст, сүүлчийн дахилт дээрээ өндөр - идэвхжилтэй өвчлөх,

хэрлэгийн явц удааширсан буюу тасралтгүй дахилттай явагдах тохиолдолд бүтэн жилийн урьдчилан сэргийлэлтийг 2 дугаар аргаар 1—1,5 жилийн хугацаагаар эхлэн хийхийг ашигтай гэж үзнэ.

Дээрх аргуудаар бициллиныг тогтмол тарьж хэрэглэхээс гадна насанд хүрэгчдэд аспириныг хоногт 2,0-оор, хүүхдэд 1,5 граммаас хэтрүүлэхгүйгээр тунг тохируулан сар хагас буюу 45 хоногийн турш жилд 2 удаа хавар (3 сарын дундаас 4 сард), намар 10, 11 дүгээр саруудад) уулгаж байх хэрэгтэй.

Аспирин зохимж муутай өвчтөнд түүнийг орлуулан дээр дурдсан хугацаагаар пирамидон буюу аналгиныг насанд хүрэгчдэд хоногт 1,5 грамм, хүүхдэд 1 нас бүрд нь 0,1-ээр бодож, хоногт 1,0 орчим тунгаар тус тус хэрэглэнэ.

Бициллин-эмийн хавсарсан урьдчилан сэргийлэлтэд нэмэлт болгож поливитамин, ялангуяа витамин С-г хавар, намар тогтмол хэрэглэж байх нь ашигтай.

Урьдчилан сэргийлэлтийн арга хэлбэрийг зөв сонгон авч хэрэглэх, түүний үргэлжлэх хугацааг тогтоох зэрэг олон чухал асуудлыг зохих цаг хугацаанд нь шийдэж байхын тулд хэрлэг өвчтэй ялангуяа зүрхний гажигтай өвчтөнг эмч нар тодорхой хугацаанд давтан үзэж байх шаардлагатай бөгөөд үүнийг харгалзан хэсэг буюу бригад сумын эмч, зүрхний мэргэжлийн эмчийн үзлэгийн хугацааг тогтоон хүснэгт 1-д չаруулав.

Хүснэгтээс үзвэл хяналтын өвчтөнг эмч нарын давтан үзэх хугацаа нь зүрхний гажгийн хэлбэр, өвчний сүүлчийн дахилтын хугацаа, өвчтөний насын байдал, зүрхний өөрчлөлт, цусны эргэлтийн дутагдал зэрэг олон зүйлээс хамаарч янз бүр байж болох ба цаашид энэхүү хүснэгтийн заалтыг баримтлах нь зүйтэй юм.

Редакцид ирсэн 1986.04.01

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР В. И. ЛЕНИНИЙ
ҮЗЭЛ САНАА

В. И. Ленин нам, улсын олон талт онцгой хариуцлагатай ажлуудад цаг хүчээ зориулж, суут бүтээлүүдээ туурвихын зэрэгцээ анагаах ухааны зохиол бүтээлүүдийг судалж, эрүүлийг хамгаалах үйлс бол бүх нийтийн хэрэг болохыг сургаж, анагаах ухааныг шинжлэх ухааны бусад салбаруудтай нягт холбохын чухлыг зааж, социалист эрүүлийг хамгаалахын онолын үндсийг тавьсан суут хүн юм.

В. И. Ленин бүр 90-ээд оны эцэст бичсэн «Орос дахь капитализмын хөгжил», гэдэг зохиолдоо, хөдөлмөрчин олны эрүүл мэндийн байдал нь тэр орны нийгмийн байгуулалт, эрүүлийг хамгаалахын урьдчилан сэргийлэх чиглэлийн хөгжлийн түвшингээс шууд хамаарна гэж дурджаэ.

Зөвлөлт засаг тогтсон эхний жилүүдэд империалист орнуудын түрэмгийлэл, иргэний дайн, эдийн засгийн бэрхшээл, хямрал, өлслөг лөн зэрэгээс болж ариун цэвэр, халдварт судлалын албыг үүсгэн байгуулахад саад бэрхшээлтэй байнга тулгарч байсан боловч зөвлөлт засаг тогтсон чухамхуу тэр үеэс эхлэн халдварт өвчинтэй тэмцэх ажлыг В. И. Ленин нэн чухалд үзэж энэхүү ажлыг залуу зөвлөлт орны социалист байгуулалттай салшгүй холбоотой эхэлсэн юм.

В. И. Ленин хөдөлмөрчин олны эрүүл мэндийг сахин хамгаалах ажлыг хэрэгжүүлэн биелүүлэх, халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх болон ариун цэвэр эрүүл ахуйн асуудлуудаар 100 гаруй хууль дүрэм, баримт бичигт гарын үсэг зурж, энэ ажлыг зохион байгуулахад өргөн олны түмний хүчийг дайчлан өрнүүлэх үнэт сургамжуудыг өгч байлаа.

Иргэний дайны тэр бэрх жилүүдэд В. И. Ленин бөөсний хижигтэй тэмцэх ажлыг улсын эн тэргүүнээ шийдвэрлэвэл зохих зүйл гэж үзэж байв.

Бидэнд мөд дуусахгүй их дайн эхэллээ. Энэ бол харанхуй бүдүү лэг байдал, эвдрэл, сүйрэл, өлсгөлөн гүйранчлал, тэсгэм хүйтэн ба бөөсний хижгийн эсрэг хийх цус урсгахгүй тэмцэл юм. Бид цуст дайнаар олж хатуужсан тэр бүр туршлага, хүчээ энэ дайнд хэрэглэж, ялалтаар төгсгөнө.

Өвчин тахал дэлгэрэх нь бидэнд ихээхэн гай гамшиг авчирч социалист байгуулалтын зорилтыг хэрэгжүүлэх боломжийг ч алдагдуулж болох юм гэж анхааруулж байлаа.

Халдварт өвчинтэй тэмцэх нь соёлжилтийн төлөө бидний хийх тэмцлийн анхны алхам, оршин тогтонохи төлөө тэмцэл мөн гэж уриалж байлаа. Халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний тухай Лениний гарын үсэг бүхий ардын комиссариатуудын шийдвэр 1919 оны 1-р сарын 19-нд гарч сонин хэвлэлд нийтлэгдсэн юм. В. И. Ленин энэ өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд анхааралтай хандаж, уг өвчиний гаралтын байдал, ариутгал, устгалын явц, эмийн санд чухам ямар эм байгаа, тэр ч байтугай хичнээн хүн усанд орж, цэвэрлэгээ үйлчилгээ хэрхэн хийгдсэнийг холбогдох хүмүүсээс лавлаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч байв. Улаан армийн дайчдыг ариун цэврийн бараа, саван, дотуур хувцас, цагаан хэрэглэлээр хангаж, ариутгалын багажуудыг нэмж үйлдвэрлэх, сэлбэн засах ажлыг хийж, энэ ажилд өргөн олон түмнийг идэвхтэй оролцуулсны үр дүнд бөөсний хижиг өвчинийг дөрвөн жилийн дотор

бурэн устгаж чадсан байна. Мөн ардын комиссариатуудын шийдвэрээр тахал (эпидеми) дээр ажиллаж байгаа эмч, ажилчдыг ямар чээлж дугааргүй хүнсний зүйлээр хангаж байв.

В. И. Ленин хөдөлмөрчин олонд эрүүл ахуйн анхны мэдэгдэхүүнийг эзэмшиүүлэхэд ариун цэвэр гэгээрлийн ажлын чухлыг тэмдэглэж байсан ба түүний итгэлт шавь, нэрт хувьсгалч Н. А. Семашко «Эрүүлийг хамгаалахын урьдчилан сэргийлэх явдал бол ариун цэвэр гэгээрлийн ажлаар эхэлж түүгээр дуусдаг» гэж сургаж байжээ.

Орон байрыг эрүүл ахуйн шаардлагын дагуу тохижуулах, орчин тойрныг эрүүлжүүлэх, усач хамгамжийг сайжруулах, хотыг хэтийн төлөвлөгөөтэй байгуулах, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний тухай болон цагаан цэцэг өвчинөөс урьдчилан сэргийлэх тарилгыг бүх нийтэд тарих зэрэг анхны хууль дүрэм, зааврууд боловсрогдон гарч мөрдөгдөн хэрэгжсэнээр энэ аюулт өвчин тархах явдлыг бүрэн зогсоож чаджээ.

В. И. Ленин ариун цэврийн хууль дүрмийг уг дуугүй биелүүлэхийг уриалж, түүнийг биелүүлэх талаар ямарч «өршөөлгүй» байхыг шаардаж, орон сууцны эрүүл ахуйн асуудлыг онцгой ач холбогдолтойд үзэж байв.

В. И. Лениний үндэслэсэн социалист нийгмийн аугаа их ололтын нэг бол эрүүлийг хамгаалах социалист систем бүрэлдэн тогтсон явдал мөн бөгөөд социалист эрүүлийг хамгаалахад урьдчилан сэргийлэх чиглэл гол рольтой гэсэн Лениний үзэл санаа биеллээ олж, эмчлэн сэргийлэх, ариун цэвэр урьдчилан сэргийлэх байгууллагууд олноор байгуулагдаж, тэдгээр нь гадаад орчны хортой нөлөөнөөс хүний эрүүл мэндийг хамгаалах, элдэв халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй авч явуулж байна. Эрүүлийг хамгаалах байгууллагууд эх орны дайны жилүүдэд зөвлөлтийн хүн ардад учирсан хэцүү бэрх сорилтуудын үед гоц аюулт халдварт өвчинтэй тэмцэхэд ямар бэлтгэлтэй байгаагаа харуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дайчин шуурхай авч явуулснаар хаант засгийн үед гарч байсан өвчлөлөөс энэ хүнд бэрх үеийн өвчлөл үлэмж бага байв.

Зөвлөлт засгийн жилүүдэд ариун цэвэр, урьдчилан сэргийлэх байгууллагууд өргөжин есч, 1940 он гэхэд АЦХС-ын 2000-аад байгууллагад 12500 орчим эрүүл ахуйн эмч нар ажиллаж байснаа одоо АЦХС-ын 4500 байгууллагад ажиллаж байгаа эмч мэргэжилтэн нь өмнөх үеийнхээс 65 дахин ессөн байна.

Зөвлөлт оронд хүн ардын эрүүл энхийн төлөө ариун цэвэр, урьдчилан сэргийлэх чиглэлд 33 мянга гаруй эрүүл ахуйн эмч ажиллаж байгаагаас 7 мянга гаруй халдварт судлагч, 6 мянга гаруй бактериолог эмч нар ажиллаж байгаа нь дэлхийн бүх эрүүл ахуйч эмч нарын тал хувь нь ЗХУ-д ажиллаж байна гэсэн хэрэг юм. Халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, ариун цэврийн улсын хяналтын ажлыг эрчимтэй сайн зохион байгуулснаар зөвлөлт засаг өнгөрсөн 70 жилийн дотор халдварт өвчнийг бууруулах, устгах ажилд их амжилт олж, цагаан цэцэг, тахал, бөөсний хижиг, булчин задрах тахал, эргэх хижиг зэрэг өвчнийг бүрэн устгаж, халдварт саа, сахуу, галзуу, татран зэрэг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн шийдвэрлэж, эдгээр өвчнийг үндсэнд нь устгаж байна. Мөн цусан суулга, хөхүүл ханиад, шимэгч үүсгэгчтэй өвчинүүдийг эрс багасгах үр дүнтэй арга хэмжээ авснаар энэ өвчинүүд тохиолдлын чанартай гарах болжээ. Харин вируст гепатит, улаан бурхан, томуу, менингококсын халдварт зэрэг өвчнийг багасгах, эдгээр өвчинүүдээс урьдчилан сэргийлэх өвөрмөц үр дүнтэй аргыг эрж хайх, шинжилгээ суналгааны ажлыг явуулж амжилтанд хүрч байна.

Зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын урьдчилан сэргийлэх чиглэл нь элдэв өвчинтэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд социалист нийгмийн давуу чанарыг ашигласнаар хүний эрүүл энхийн төлөө тэмцэлд ам-

жилт олохын уг сурвалж, дэлхийн эрүүлийг хамгаалах системд цоо шинэ чиглэл болж байгаа ба бүтээлч хөгжлийнхөө замд шинжлэх ухааны ололтоос хамгийн шилдэг бүхнийг тусгасан эрүүлийг хамгаалахын хөгжлийн оргил нь болж байна.

Зөвлөлт Холбоот Улсын эрүүлийг хамгаалахын 70 жилийн түүхэн туршлага бол нийгмийн дэвшилт систем, үндэсний тусгаар тогтолцоо олохоор тэмцэж яваа дэлхийн олон оронд бахдам жишээ болж, зөвлөлтийн олон мянган шилдэг нарийн мэргэжлийн эмч нар хөгжиж байгаа орнуудад болон олон улсын байгууллагад ажиллаж, өөрийн орны эрүүлийг хамгаалахын баялаг туршлагыг түгээж байгаа явдал бол Лениний сургаал, үзэл санаа хэрэгжин биелж байгаагийн нэг тод илрэл юм.

Анагаах ухааны дэд эрдэмтэн Н. Цэнд

ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ, ЗӨВЛӨЛТИЙН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАРТ

Сүүлийн жилүүдэд зөвлөлтийн эрүүлийг хамгаалах салбарт гарч буй дутагдал, доголдлыг сонин хэвлэлд олонтоо шүүмжлэх болсны шалтгааныг тодруулах, салбарын түлгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын талаар ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны сайд, академич Е. Чазовтой энэ оны 4-р сард «Правда» сонины газраас хийсэн ярилцлага, мөн «Известия» сонины гурав, дөрөвдүгээр сарын нэлээд дугааруудад эрүүлийг хамгаалах байгууллагад байгаа бэрхшээл, түүнийг даван туулах боловжийн тухай бичсэнд түүвэрлэн орчуулж сэтгүүлийнхээ энэ дугаарт нийтлж байна.

Академич Е. Чазов «Эрүүлийг хамгаалахад шударга, өндөр шаардлага тавихын хамт нийгэм түүнд зохих анхаарлаа хандуулах ёстой» гэж тэмдэглээд улс ардын аж ахуйн чухал салбаруудын хэрэгцээ шаардлагыг хангасны дараа үлдэгдлээр эрүүлийг хамгаалахыг санхүүжүүлдэг «Төлөвлөлтийн үлдэгдлийн зарчим»ыг баримталж ирсэн, удаан хугацаанд тооны хойноос хөөцөлдөж чанарыг орхигдуулсан, удирдах, аж ахуйг хөтлөхөд хүнд суртал гаргаж байгууллагын бие даасан ажиллагааг саатуулах, доод байгууллагын санаачилгыг боогдуулах, хөдөлмөрийг материаллаг урамшууллаар үнэлэхийг үгүйсгэсэн дутагдал байсан нь сүүлийн 15—20 жилд эрүүлийг хамгаалахын хөгжлийн явцыг бууруулаад зогсоогүй шийдвэрлэвэл зохих нэлээд ярвигтай байдал бий болгож, тухайн үед нь залруулж болох байсан дутагдлыг зуршил болсон «амжилтаар» халхалж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудал эмч нарын хүрээнээс хальж чадахгүй, зөвлөлтийн үйлдвэр аж ахуйн газрын олонхи удирдах ажилтнууд урьдчилан сэргийлэх асуудлаар улсын цогцолбор программ байдгийг ч мартаж байгаа тухай дурдсан байна.

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах талаар нам, засгийн тогтоолд дурдсан 196 заалтаас дөнгөж 47 нь биелэгдэж, 104 хотод агаарын бохирдол тогтоосон нормативаас 10, нийтийн аж ахуйн дөрөвний нэг, бусад харьяа байгууллагын гуравны нэгийн усан систем бүрэн цэвэрлэгдээгүй байхад эмч нар хурц халдварт өвчний гаралтын шалтгааныг олох гэж толгойгоо гашилгаж суугаа тухай... асуудлыг хөндөж тавьсан байна.

Эмнэлгийн ажилчид сувилал, эрүүл аж төрөх ёсны талаар бага анхаарч байна. Ийм асуудалд идэвх гаргаагүйгээс эмнэлгийг өвөрмэц засварын албаны хэмжээнд тавихад хүргэв.

Сүүлийн 10 жилд зөвлөлт оронд уушгины хавдраар, өөрөөр хэлбэл тамхинаас болж сая орчим хүн нас баржээ.

Хэдийгээр тамхи татах зуршилтай тэмцэл явуулсаар байгаа боловч тамхины гүйлгээ багасаагүй, харин ч нэмэгдсэн байна.

Энэ бол тэмцэл амжилтгүй байгаагийн гэрч. Тамхичид зөвхөн өөрийгээ тэдийгүй, орчин тойрноо, үр хүүхдээ хордуулж байгааг тэдэнд ухамсарлуулах хэрэгтэй.

Эрүүл аж төрөх ёсыг хүүхэд ахуй цагаас нь хэвшүүлэх хэрэгтэй бөгөөд энэ зайлшгүй шаардлагыг бид муу ашиглаж байна.

Эрүүл аж төрөх ёсыг өөрөөсөө эхлэх ёстай.

Эмнэлгийн бүх ажилчид хорт зуршилаас өөрсдөө ангижирч эрүүл аж төрөх ёсны сурталчилгааг угзэр биш биеэрээ үзүүлбэл зохион гэж Эрүүлийг хамгаалах Яамны сайд үзсэн байна.

«Известия» сонини тусгай сурвалжлагчид Горький, Архангельск мужаар эмнэлгийн байгууллагын ажлыг сурвалжлахад зарим эмнэлгийн байгууллагыг захиргаа, үйлчлэх хүрээний үйлдвэр, албан байгууллагууд их анхаарч хөрөнгө зарж, үлгэр жишиг тохижуулж эмнэлэг үйлчилгээг явуулах дээд зэргийн бололцоогоор хангасан байхад зарим газарт нэлээд дутагдал байгааг тэмдэглэсэн нь бидэнд ч сургамжтай санагдаа.

Тухайлбал: Амбулатори-поликлиник 5 км дотор байхгүй, лабораторийн шинжилгээ өгөх гэж өглөө б цагт ирдэг, хурц өвчтэй хүн З цаг хүртэл эмнэлэгт үзүүлэхээр хүлээдэг, эмч яаруу сандруу «юу хэрэгтэй», «хооол, нойр ямар», «хувцсаа тайл, өмс» гэх мэтээр хүйтэн хөндий харьцааг, поликлиник жилд 2 тонн цаас хэрэглэдэг, эмнэлэгт 400 маягт хөтөлдгийн зөвхөн «явцын дүгнэлт»-ийг 200 хүнд бичнээг тэхэд 11 өдрийн ажил зарцуулдаг, дотрын эмчийн цагийн тавны нэг нь өвчтөн үзэх, бусад нь бичиг цаасны ажилд зориулагддаг, өглөөний таван минутаар хүнд өвчтөний эмчилгээ, оношлогооны тухай ярихын оронд ямар юм олох, төлөвлөгөөг яаж биелүүлэх тухай ярьдаг, амбулаторийн үзлэгийн биелэлтээр эрүүлийг хамгаалахын ажлын чанарыг дүгнэх, шагнал урамшил олгох асуудлыг ч хүртэл шийддэг, эрүүл мэндийн төлөө хариуцлагатай, үнэнч шударга ажиллаж байгааг хэмжих хэмжүүргүй, ерөнхий эмч нь эмнэлгийн багаж төхөөрөмжөөс гадна сантехникийн багаж, түгжээ, индуу, хулдаас хүртэл олох гэж хөөцөлддөг тухай бичжээ.

Мөн эмнэлгийн зураг төсвийг шинээр нэг оронд ногдох тоног тэхеөрөмжийн БНАГУ-аас 2 дахин, Чехословакаас 5 дахин бага төлөвлөж байгаа, ЭЗХТЗ-ийн орнуудад больнициын бүх хөрөнгийн 40 хувь нь эмнэлгийн тоног төхөөрөмж байхад зөвхөн 15 хувь нь, эрүүл ахуйн нормоор нэг хүнд 7 квм талбай ногдох ёстай атал 4 квм ногдох байгаа, жил бүр квм талбайг засахад 6 копеек, нэг тасаг жилд 14 литр спирт зарцуулна гээд төлөвлөхийд нь амьдралд нийцэхгүй байгаа тухай олон асуудлыг ил, тод гарган тавжээ.

Дээрх дутагдлуудыг арилгах арга зам нь зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын өөрчлөн байгуулалтын бодлогын үндэс болж байна.

Иймээс дараах өөрчлөн байгуулалт хийнэ гэж Эрүүлийг хамгаалах Яамны сайд мэдэгджээ.

— ЗХУ-д нэг сая 200 мяанган эмч байгаагийн олонхийн мэдлэгийн төвшин хангалтгүй байгаатай холбогдуулан сургууль төгсөгчдөд сурлагын байдлаар нь их эмчийн, бага эмчийн диплом олгодог болгох,

Шинэ ч бай, хуучин ч бай бүх эмнэлгийг эм, өвчтөнийг асрахад зориулагдсан техник хэрэгслэл, эмнэлгийн багаж төхөөрөмжөөр бүрэн хангах, техник хэрэгслэлд үйлчлэх мэргэжилтэй инженер техничийн ажилчдыг ажиллуулах,

— Амбулатори-поликлиникийг ихээхэн бэхжүүлж зөвлөгөө өгөх, оношлох тасгуудыг өргөтгөх, «оношлогооны төв» нэртэй шинэ байгууллага байгуулж хүртээмж мутай байгаа оношлогооны багаж төхөөрөмжийг нэгтгэх, эмчилгээний ихэнх шинжилгээний үндсэн хэсэг, хүнд биш мэс ажилбаруудыг амбулатори-поликлиникт хийх замаар

больнициын ачааллыг багасгаж больницод эмчилгээ, оношлогооны хүнд хэцүү хэсгийг хариуцуулах,

— Хэсгийн эмчийн ажлын үр дүнг үзсэн, дуудсан хүний тоогоор биш, хариуцуулж өгсөн хүний эрүүл мэндийн байдлаар үнэлэх, өвчтөн эмчээ өөрөө сонгох эрх эдлүүлэх,

— Эмч нарыг бичиг цаасны ажлаас бүрэн чөлөөлж, үзлэгийн цагийн нормативыг дахин хянах,

— Эмнэлгийн магадлагаагаар эмчийн чөлөө авч буй өвчтөн эмнэлэгт олон дахин ирж үзүүлж байгаагаас өвчний явцыг муутгах, амбулатори-поликлиникийн ачааллыг ихэсгэж байгааг харгалзан. Үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлтэй хамтарч нэлээд муж, Москвагийн районд эмнэлгийн чөлөөг 10 хоногоор нэгмөсөн өгч буй туршилтыг амжилттай болболж бүх нийтээр нэвтрүүлэх,

— Хүн амыг бүх нийтээр диспансерчлах ажлыг аажмаар, нөхцөл бурдүүлэх замаар 1995 онд бүрэн шийдэх,

— Нөхцөл бурдэхэд хэсгийн эмч, Ариун цэвэр халдвár судлалын станц, ариун цэврийн суртал нэвтрүүлгийн байгууллага (АЦГО), эмчилгээ-биений тамирын диспансерууд зэрэг урьдчилан сэргийлэх бүх байгууллагууд нэгдэн бичил районы хүн амын эруул мэндийг хамгаалах иж бүрэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх юм.

Үүний үр хөврөл болох байгууллага Эрүүлийг хамгаалах Яаманд «Урьдчилан сэргийлэх хэлтэс» нэртэй байгуулагдав.

Баталгаатай, үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж нь зөвлөлтийн ард түмний байлдан олсон онц чухал ололт юм. Гэхдээ 1995 он гэхэд аж ахуйн тооцоотой поликлиник 2 дахин нэмэгдэнэ.

Эрүүл мэндийн фондын асуудал хөндөгдж нэмэлт хуримтлал бий болгох учиртай. Ийм эх үүсвэрийн нэг нь завод, фабрик, хамтраг, сангийн аж ахуйн хөрөнгө байж болно.

Энэ талаар олон чухал алхмууд хийгдсэн байна.

Тухайлбал Бүх Холбоотын Үйлдвэрчний Эвлэлийн зөвлөлтэй хамтарч 5 мянгаас дээш ажилчинтай үйлдвэр, аж ахуйн газар өдрийн эмчилгээ-сувилал ажиллуулахаар болж байна.

Мөн хөдөлмөрийн чадвар түр алдах өвчнийг багасгаснаас арвилан хэмнэсэн хөрөнгийг эрүүлийг хамгаалахын хэрэгцээнд зориулах тухай санал гарч байна.

Үйлдвэрчний эвлэлийн ҳарьяа амралт сувиллаас 20 мянган орыг эрүүлийг хамгаалах салбарт гарган өвчтэй хүмүүсийг нөхөн сэргээх эмчилгээнд оруулахыг зөвшөөрөв.

Тэрчлэн тухайн байгууллага өөрийн ажилчны эмчилгээний хагасыг боловч төлдөг байж болно гэж үзэж байна.

Үнд Зөвлөлтийн Улаан Загалмай Нийгэмлэг туслахаар амлаж байгаа.

Мөн тамхи татагчдаас өвөрмөц татвар болгож тамхины үнэчд 3—5 мөнгийг нэмж борлуулаад түүнийг тамхинаас үүссэн өвчний эмчилгээнд зориулбал улсаас гарах зайлшгүй зардал хэмнэгдэнэ.

Эрүүл мэндийн фондод ард иргэдээс сайн дураараа бэлэглэсэн зүйл ч орж болно гэж үзэж байгаа саналаа илэрхийлжээ.

Е. Чазов эдгээр асуудлыг давшүүлэхдээ «Манай нийгмийн гол баялаг болсон эрүүл мэндэд зориулах хөрөнгийг нэг иргэнд ногдох хамгийн ашигтай, үр дүнтэй зардлаар тооцох ёстой» гээд энэ чухал асуудалд Эрүүлийг хамгаалах Яамны аппарат урьдын адил айн бэмбэгнэх, хулчганах үзэгдэл гаргаж болохгүй гэж цохон тэмдэглэв.

Орчуулсан А. Дамдинсүрэн

Ж. Тумбааш, Ж. Баасанхүү (Улсын клиникийн төв эмнэлэг)

**ХӨДӨЛМӨРИЙГ БРИГАДААР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГЫГ
ЭМНЭЛЭГТ НЭВТРҮҮЛСЭН НЬ**

Эрүүлийг хамгаалах салбаруудад хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй, зүй зохицтой зохион байгуулах явдал чухал ач холбогдолтой юм.

Манай орны улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбарт бригадын арга нэвтрээр үр дунгээ өгч байна. Харин эрүүлийг хамгаалах салбарын ажлын онцлог, үйлчилгээний өвөрмөц зохион байгуулалтын улмаас бригадын аргыг нэвтрүүлэхэд нэлээд бэрхшээлтэй бөгтөөд хийж туршсан ажил маш ховор юм.

ЗХУ-ын Москва, Донецк зэрэг олон хотын нүдний клиникуудад бригадын арга 1970-аад оноос нэвтрэч Москва хотын нүдний бичил мэс заслын эрдэм шинжилгээний институт энэ аргыг өөрийн үйл ажиллагаанд ашиглалтадаа бүрэн нэвтрүүлжээ.

Бригадын арга нь бригадын бүх тишигүүдийн ажлын амжилтаас шалтгаалдаг үйлдвэрлэлийн бяцхан хэсэг юм.

Бригадынхны дотор хөдөлмөр зохион байгуулалтын хамтын хэлбэр давамгайлан гишүүн бүр бие биедээ өндөр шаардлага, хяналт тавих, хамт олны үүрэг хариуцлагыг жигд сайжруулах үндсэн дээр идэвхтэй хөдөлмөрлөх боломжийг бүрэлдүүлдэг байна. Хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зөв зохион байгуулснаар дотоод нөөцийг илрүүлэн бүрэн ашиглах, шинжлэх ухаан техникийн ололт, түүний үр дүнг практикт нэвтрүүлэхийн заагийг багасгаж, эмч нарын ажлын ачааллыг жигдүүлэн, дадлага мэргэжлээ байнга дээшлүүлэх боломж олгон, ажлын чанар, эмчилгээ үйлчилгээ хэр зэрэг цаг хугацаандаа явагдаж байгаад хяналт тавихад ихээхэн ач холбогдолтой юм.

ЗХУ-ын Москва хотын нүдний бичил мэс заслын эрдэм шинжил-

гээний институтийн туршлагаар Улсын клиникийн төв эмнэлгийн нүдний тасгийн эмч нар бригадын аргыг 1982 оноос эхлэн ажилдаа нэвтрүүлж нүдний тасаг, поликлиникийн нүдний кабинетийн б эмчийн бүрэлдэхүүнтэйгээр эмч нарын бригад байгуулсан юм.

Манай бригадын эмчилгээ, үйлчилгээний ажлын гол зарчим нь стационарын тасаг, поликлиникийн үзлэгийн кабинетын эмч нар бүх төрлийн ажилд жигд оролцдогт оршино. Бригадын ахлагчаар тасгийн эрхлэгч, поликлиникийн нүдний кабинетыг нэг эмч хариуцан ажилладаг.

Бригадын ахлагч нь эмч нарт тасагт шинээр хэвтэж байгаа өвчтөнг хуваарилах, мэс засал хийх ба туслах эмч нарыг томилох, хөдөө орон нутгийн яаралтай дуудлаганд явах эмч нарын хуваарийг гаргах зэргээр ажлаа зохион байгуулна.

Бригадын эмч бүр тасагт 10 гаруй өвчтөнг хариуцан эмчлэх ба поликлиникийн кабинетад долоо хоног бүр батлагдсан графикаар тогтмол үзлэг, мэс засал хийдэг учраас хэвтэх өвчтөн бүрийг тодорхой мэддэг. Онош, эмчилгээний асуудал шийдвэрлэгдээгүй, хэвтүүлж эмчлэх шаардлагатай өвчтөнийн зөвлөх эмчид цаг тухайд нь үзүүлэх, онош тодорхойгүй буюу яаралтай тусламж үзүүлэх тохиолдолд бригадын эмч нарын зөвлөгөөнөөр оруулан шийдвэрлэж ажилласнаар үйлчилгээ хөнгөн шуурхай болж өвчтөн хүлээгдэх нь багаслаа.

Тасагт зөвлөх эмчийн үзлэг, зөвлөгөөнийг хоногт 2 удаа хийж өвчтөний эмчилгээнд тавих хяналтыг тогтмолжуулан, мэс засал хийх өвчтөнд хагалгаа хийх тактик, арга техникийг сонгон авч

урьдчилан бэлтгэх, гарах өвчтөн бүрийг үзэж зөвлөдөг.

Бригадын эмч нарын мэргэжил дээшлүүлэх ажлыг Аанааах ухааны дээд сургуулийн нүдний өвчин судлалын тэнхимийн удирдлагаар төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

Эмч бүр эмчилж гаргасан, ялангуяа нүдний алимийн мэс засал хийлгэсэн, нүдний хүнд гэмтэлтэй өвчтөнөө поликлиникоор үргэлжлүүлэн эмчлэх, хяналт тавих бололцоотой болсон юм.

Бригадын аргыг нэвтрүүлснээр поликлиникт эмч цар дагнан ажиллаж мэс засал хийх ажлаас удаан хугацаагаар хөндийрч байсныг арилгаж бичил мэс заслын арга техникийг хугацаа алдалгүй жигдэээмших болж эмч нарын ажлын ачаалал ч жигдэрч мэргэжлээ байнга дээшлүүлэх боломжтой боллоо.

Эмчилгээ, үйлчилгээний ажлын чанарт өөрчлөлт гарч тасаг, кабинетын ажлын уялдаа холбоо ч сайжирлаа. Нүдний тасаг, кабинетийн сүүлийн таван (1981—1985) жилийн үйл ажиллагааны үндсэн

үзүүлэлтийг өмнөх таван (1975—1980) жилийнхтэй харьцуулахад орны фонд ашиглалт 3,6% хэвтэж эмчлүүлэгсийн тоо 20,2%, мэс засал хийлгэсэн хүний тоо 3,6%-иар тус тус нэмэгдэж поликлиникийн нүдний кабинетад мэс засал, тариа хийлгэсэн хүний тоо 3,6 дахин өсөж орны эргэлт 16,0 байсан бол 19,2 болж 20%-иар нэмэгдэж, ор хоногийн дундаж 23 байснаас 19,7 болон 14,4%-иар буурснаас 7804 төгрөгийн хэмнэлт гарлаа.

Поликлиникийн нүдний кабинетийн үзлэг 10 хувиар нэмэгдсэн байна.

Бригадын арга нь эрүүлийг хамгаалах салбарт хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэр бөгөөд тасаг, поликлиникийн кабинетын эмч нарын анхаарлыг нэг чиглэл зорилгод хандуулж эмчилгээ үйлчилгээний сайн нөлөөтэй байгаа учир тухайн эмнэлгийн ажлын онцлогт тохиуулан нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Редакцийд ирсэн 1987—05—06.

ХОВОР ТОХИОЛДОЛ

Б. Чүлтэмсүрэн (*Anagaah ухааны дээд сургууль*)

БӨӨРНИЙ БЭТЭГ

Бөөрний бэтэг бусад эрхтний бэтгийн адил бага насандaa бэггийн халдвар авч 25—30 насанд бэтэг нь илрдэг гэж И. М. Энштейн, М. Д. Джавадзаде нар үзжээ. Манай оронд ажиллаж байсан ЗХУ-ын эмч эрдэмтэд манай улсын клиникийн материал дээр тулгуурлан бэтэг өвчний талаар эрдэм шинжилгээний чиглэлтэй нэлээд бүтээл хэвлүүлсний дотор С. Н. Анфилогов (1938—1944) Улсын клиникийн төв эмнэлгийн задлан шинжилгээний материалыар бэтэг өвчний 214 тохиолдлыг судалсны дотор, түрүү булчирхайн бэтэг 2, уураг тархины бэтэг 1, умайн бэтэг 1, Г. А. Дудкевич (1938—1954) мөн төв эмнэлгийн материалыар 912 уушги элэг, өрц, дэлүү зэрэг эрхтний бэтэгний элбэг тохиолдоос гадна, булчингийн бэтэг 13, ясны бэтэг 5, зүрхний бэтэг 2, бөөрний бэтэг 2, бамбай булчирхайн бэтэг 1-ийг тус тус илрүүлсэн байна.

Бөөрний бэтэг үүсгэгч нь экинококус гранулёзис гэдэг тууз хорхой юм. Бэтэг үүсгэгч жинхэнэ ба завсрлын хоёр эзэн байдаг. Бэтэгний жинхэнэ эзэнд нохой, муур, чоно, үнэг, хярс зэрэг махчин амьтад орно. Эдгэрээс нохой, муур хоёр хүнд ойр байдаг учир өвчнийг халдаадаг.

Завсрлын эзэнд хүн, сүүн тэжээлтэн амьтад багтана. Гол халдвар тараагч нь ухэр, хонь, ямаа, тэмээ, адуу, буга зэрэг болно. Үүнээс гадна анчин хүмүүсийн агнасан үнэг, чоно зэрэг бэтэг тээгч амьтдын арьс, үс, ноосоор дамжин халдварлана. Бэтэгний өндөг нь өвсногоогоор дамжин, өвсөн тэжээлт амьтанд халдварлаж, улмаар бэтэг завсрлын эзэн хүнд халдварлаж болно.

Бөөрний бэтгийн шинж тэмдэг.

Бөөрний бэтгийг клиникийн шинж илрэх байдлаар нь ил, далд хоёр хэлбэрт хуваана. Бөөрний бэтэг нь 25% орчимд далд хэлбэртэй байх ба бэтэг нь яваандаа томорч бөөрний эд эсийг дарж ажиллагаагүй болгох, бөөрний аяганпар, тэвшинцэрийг дарж шахан хэлбэр дурсийг нь өөрчлөх буюу бэтэг нь бөөрний тэвшинцэрлүүгээ хагарч ил хэлбэрийн бэтгийг үүсгэнэ. Бөөрний бэтэг нь томрохдоо ойр орчныхоо эд эрхтнийг дарах, хэвлийн хөндийн цусны эргэлтийн ажиллагааг хүндрүүлэх, гэдэс ходоодны үйл ажиллагааг өөрчлөх улмаар ходоод гэдэсний үйл ажиллагааны хямралын шинж илэрч болно. Бөөр нь бэтэгний улмаас томорч өрцийг дээш шахаж, үүний улмаас амьсгаадах, цээж бачуурах, цээжээр үе үе хатгаж болно. Бөөрний далд хэлбэрийн бэтэгний үед илрэх шинж тэмдэг нь тодорхойгүй. Үүц нуруу орчмоор тогтмол нургин өвдөх бөгөөд оношилоход төвөгтэй.

К. С. Керопианы судалгаагаар бөөрний бэтэгтэй 600 өвчтөний 34-д; В. А. Боголюбовын 116 өвчтөний 10-д нь бөөрний далд хэлбэрийн бэтэг тохислдсон байна.

А. Н. Цулукидзе бөөрний бэтэгний далд хэлбэрийн үед бэтэг, хавдартай төстэй тэмтрэгдэх, бөөрний зураг авахад бөөрний тэвшний хэлбэр өөрчлөгдсөн байдгаараа бөөрний хавдрын шинж тэмдэгтэй ихэвчлэн андуурагдах талтай гэжээ. Далд хэлбэрийн бэтэгний үед шээс ба цусны шинжилгээнд онцын өөрчлөлт гардаггүй.

Дээр дурдсан байдалтай холбож далд хэлбэрийн бөөрний бэтгийн тохиолдлын тухай дурдъя.

Өвчтөн А. 79 настай, бие сурлах, толгой өвдөх, амьсгаадах гэсэн зовиуртай эмнэлэгт хэвтсэн. Өвчин хэдийд эхэлсэн нь тодорхой-

гүй, бодит узлэгээр биеийн хөгжил зөв мах марса дунд зэрэг, арьс хуурайтар үе мөч, яс булчингийн талаар өөрчлөлтгүй, уушгинд тогшил тоор дулий чимээтэй, амьсгал нь сулхан зарим хэсэгтээ хуурай хэрчигнүүр сонсогдоно. Зүрхний хязгаар зүүн тийшээ өргөссөн, авиа ль будгэрсэн, гол судасны цэгт 2 дугаар авиа тодорсон, цусны даралт 160/110 мм, судасны цохилт 70, дэлүү томроогүй, хэвлийн эрхтний талаас өөрчлөлтгүй байв. Харин элэгний баруун хэсэгт хавдартай төсөөтэй зүйл олджээ.

Зүрхний зүүн тосгуур томорч цохилт нь суларсан байв. Цусны шинжилгээнд будагч бодис 75%, улаан бөөм 5,900000, цагаан бөөм 4050, УЦТУ 1 цагт 31 мм, савхан эс 1, сегмент 71, лимфоцит 20, моноцит 8, цусны холестрин 255 мг%, сахар 112 мг%, билирубин 0,32 мг%, Вессерманы урвал илрээгүй. Шээсний хувийн жин 1013, уураг 0,06%, цагаан бөөм 10—13, улаан бөөм 5—10 байв.

Урьдчилсан онош нь тархины судасны хатуурал, цусны даралт ихдэх өвчин, уушгины хатуурал гэсэн оноштой дотрын тасагт эмчлүүлсэн. Бөөрний мэс засалчдын узлэгээр баруун бөөрний дээд хэсгийн хавдар гэж үзэв. Иймээс бөөр шээсний замын эрхтэнийг шинжлэхээр бөөрний тасагт шилжүүлсэн болно. Бөөрний тойм зурагт нурууны булчингийн зах тод бус, нурууны ясанд өөрчлөлттэй, 10 см диаметр бүхий зах хязгаар нь тодорхойгүй сүүдэр биеийн баруун хэсэгт тодорчээ. Зүүн бөөрний орчим эмгэг өөрчлөлтийн сүүдэргүй байв. Хураагуур судсанд 40% сергозины уусмал 20 мл хийснээс хойш 10 минутын дараа бөөрний зураг авахад зурагт бөөрний орчим байсан сүүдэр нь улам тодорсон.

Эцсийн онош нь: Нурууны үеийн хэлбэр эвдэрч спондилоартроз, баруун бөөрний шохойжсон далд хэлбэрийн бэтэг гэж оношлов. Ер нь бөөрний сөнөж шохойжсон бэтэг нь далд хэлбэртэй бөгөөд их томроогүй бол өвчтөн ямарч зовиур шалалгаагүй байдаг.

Бөөрний ил хэлбэрийн бэтэгний уед тохиолдох үндсэн шинж бол бэтэг нь бөөрний тэвшруү хагарч, шээстэй хамт бэтгийн шингэн ба бэтгийн уйланхай гардаг. Үүнийг эхинококурия гэнэ. Бэтэг томрох үедээ цусны судсыг гэмтэхээс гадна, бөөрний бэтэг хагараадаа бөөрний судсыг гэмтээж богино хугацаанд цустай шээнэ. Бөөрний бэтэг нь томорч бөөрний бүрхүүл хальсаа тэлж томрох уед бөөр орчим байнга унжиж өвдөх ба зарим үед бэтэгний уйланхай титэм бүрхүүлийн хэсэг нь бөөрнөөс шээс дамжуулах суваг, шээлэнцэрт тээглэж болно. Энэ үед бөөрний орчим хурц хатгаж өвдөнө.

Бөөрний бэтэгт 2 дахь замаар кокийн халдвэр орж идээлүүлэх үед бөөр орчим лугшин өвдөх, шөнө нойргүй хонох, халуурах, бие сулрах, толгой өвдөх, ам цангах, турж эцэх зэрэг хордлогын шинж илэрнэ.

Идээлсэн бэтэгний үед цусны цагаан бөөмийн тоо олшрон, улаан бөөмийн тунах урвал хурдасна. Бэтэг өвчний үед бие махбодод бэтэгний хорхой, ондгөвч байх нь хэлестрины солилцоонд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлж болох талтай гэж зарим судлаачид үздэг. Бэтэгтэй өвчтөний цусны ийлдсийн холестрины too голдуу ихдэх маягаар 225—600 мг% хүртэл өөрчлөгднө. Ийнхүү холестрины хэмжээ ихсэх нь аливаа эрхтний бэтгийн байрлал их, бага, олон ёөнтэй холбоотой байдаг. Бэтгийг авах хагалгаа хийсний дараа холестрины хэмжээ аажмаар буурч зохих хэмжээндээ хүрнэ.

Ийм учир бөөрний бэтэг өвчний үед цусны ийлдсийн дотор холестрин ихсэж болох юм.

Бидний ажигласнаар бэтэгтэй нэг өвчтөний цусанд холестрин 285 мг% хүртэл ихэссэн байв. Шээсэнд цагаан бөөм их хэмжээгээр илрэх, мөн шээсэнд уураг үл мэдэг хэмжээгээр үзэгдэх шинжүүдээрээ бөөрний сурьеэтэй төстэй байна. Бөөрний бэтэгний үед бөөрний тойм зурагт дугуй буюу хагас дугуй хэлбэртэй зах хязгаар нь тодорхой сүүдэр үзэгдэнэ. Зарим үед бэтэгний уйланхайн дүрс ч тод үзэгдэж болно.

Ц. Содномпил (Эрүүлийг хамгаалах Яам)

**БИМБАУЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН УДИРДАХ
БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ АРГА ЗАМ**

ДҮГНЭЛТ: 1. Шинжлэх ухаан техникийн дэвшил эрчимжиж салбарын дотоод болон салбар хооронд шинэ төрлийн хэлхээ холбоо бий болж байгаа ёнөө үед хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн цар хүрээ өсч, түүнд тавих шаардлага эрс нэмэгдэж байгаатай уялдуулж эрүүлийг хамгаалахын удирдлагын системийг боловсронгүй болгох явдал нэн чухал байна.

2. Эрүүлийг хамгаалахын удирдлагын системийн зорилт, бүтэц, зохион байгуулалтын схем, бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоог шинжлэх ухааны ундэслэлтэй тогтоож удирдлагын үйл ажиллагааны (функци) ангиллыг боловсруулав.

3. Эрүүлийг хамгаалахын удирдлагын системийн мэдээллийн хангамжийг судалж, дараах онцлогтой болохыг тогтоов. Үүнд:

— Эрүүлийг хамгаалах Яаманд орж, гарч байгаа мэдээллийн ихэнх хэсгийг (орж байгаа мэдээллийн 58,4%, гарч байгаа мэдээллийг 60,4%) харьяа эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудтай холбогдсон мэдээлэл эзэлж, дараа нь яам тусгай газруутай харилцаж байгаа мэдээлэл (23,1% ба 24,5%) орж байна.

— Мэдээллийн хэмжээг сар улирлаар судалж үзэхэд II улиралд нэлээд ихсэж (орж байгаа мэдээллийн 30,7% гарч байгаа мэдээллийн 33,5%) байна.

4. Яамны газар, хэлтэс, тасгуудын дотроос хамгийн их мэдээлэлтэй ажиллаж байгаа нь боловсоян хүчин захиргааны газар (орж байгаа мэдээллийн 24,5%, гарч байгаа мэдээллийн 23,7%, дараа нь улсын ариун цэвэр халдварт судлалийн байцаан шалгах газар (16,1 ба 11,6%) орж байна. Харин аж ахуйн тасагт мэдээлэл хамгийн бага байна.

5. Эрүүлийг хамгаалах Яамнаас болозсруулан гаргаж байгаа шийдвэрийн ихэнх нь тушаал (62,2%), коллегийн шийдвэр (26,9%) гарч байна. Агуулын хувьд 31,2% нь боловсон хүчний, 21,2% нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн асуудлаар гарч, үлдсэн хэсгийг салбарын бусад асуудал эзэлж байна. Гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажилд дутагдал их байгаа бөгөөд түүнийг боловсронгүй болгоход автоматжуулсан систем нэвтрүүлэх шаардлагатай байна.

6. Энэ судалгаагаар эрүүлийг хамгаалахын удирдлагыг боловсронгүй болгох иж бүрэн арга хэмжээг боловсруулав. Үүнд:

— Эрүүлийг хамгаалахын удирдлагын системд тооцоолох техник хэрэглэх, удирдлагын автоматжуулсан систем (УАС) нэвтрүүлэх үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх үе шатыг боловсруулав.

— Тооцоолон бодох техник, удирдлагын автоматжуулсан систем нэвтрүүлэх үеийн эрүүлийг хамгаалахын удирдлагын зохион байгуулалт-мэдээллийн загвар, яамны аппаратад баримт материалтай ажиллах дэс дарааллыг тогтоох математик загвар болон эрүүлийг хамгаалах системд тооцоолох техник нэвтрүүлэх үед яамны аппаратын бүтцийг боловсронгүй болгох саналыг тус тус боловсруулав.

7. Эрүүлийг хамгаалахын удирдлагын системд хяналтын автоматжуулсан систем нэвтрүүлэх үндэслэл, техникийн даалгавар, ажиллагааны журам боловсруулсан болно.

ЗӨВЛӨМЖ: Эрүүлийг хамгаалахын удирдлагын системийг доорхи үндсэн чиглэлээр боловсронгүй болгох нь зүйтэй.

1. Эрүүлийг хамгаалахын удирдлагын системийн үйл ажиллагаанд тооцоолон бодох техник удирдла-

гын автоматжуулсан систем нэвтрүүлэх:

Үүнд а) Эрүүлийг хамгаалах салбарын удирдлагын автоматжуулсан систем (ЭХСУАС) боловсруулж нэвтрүүлэх

б) Эмнэлгийн байгууллагуудын амбулаторийн үзлэг, онош эмчилгээ, лабораторийн шинжилгээ болон бусад үйл ажиллагааг боловсронгуй болгоход тооцоолох электрон машин (ТЭМ) ашиглах

в) Эмч, эрдэмтдэд зориулан анагаах ухааны эрдэм шинжилгээний холбогдолтой мэдээллийн автоматжуулсан систем (МАС) байгуулах, ТЭМ, эдийн засаг математикийн аргыг анагаах ухааны судалгааны ажил, анагаах ухааны дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг боловсронгуй болгоход ашиглах.

2. Эрүүлийг хамгаалахын удирдлагын системийн зорилт үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг доорхи байдлаар боловсронгуй болтох:

а) Нэг сэдэвт бүтээлд боловсруулсан эрүүлийг хамгаалахын үндсэн зорилт, дэд зорилтыг Эрүүлийг хамгаалах Яамны дүрэм, аппаратын газар хэлтэс, тасгийн дүрэм, ажлын ерөнхий хуваарийг боловсруулахад тусгах

б) Мөн диссертацид боловсруулсан эрүүлийг хамгаалахын удирдлагын үйл ажиллагааны ерөнхий ба нарийвчилсан ангиллыг яамны аппарат, аймаг хотын Эрүүлийг хамгаалах газар харьяа байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх

в) Диссертацид боловсруулсан удирдлагын автоматжуулсан систем, тооцоолох техник нэвтрүүлэх үеийн эрүүлийг хамгаалахын удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалтын загварыг цаашид эрүүлийг хамгаалах системд нэвтрүүлэх шаардлагатай байна.

Редакцид ирсэн 1987. 05. 16.

М. Сүхбаатар (*Анагаах ухааны дээд сургууль*)

ХҮҮХДИЙН УУШГИНЫ ЦОЧМОГ ҮРЭВСЛИЙН ЯНЗ БҮРИЙН ХЭЛБЭРИЙН ҮЕ ДЭХ ЦУС БҮЛЭГНЭЛТ, ЯЛTSAN ЭСИЙН БАЙДАЛ

Хүүхдийн уушгины цочмог үрэвслийн эмгэг жамыг гүнзгийрүүлэн судалж, эмнэл зүйн шинж тэмдгийг тодорхойлох, эмчилгээний оновчтой арга боловсруулахын тулд эрүүл 60 (хяналтын), өвчтэй 224 хүүхдэд цус бүлэгнэлтийг үе шатаар нь тодорхойлох 26 үзүүлэлт, ялtsan эсийн тоо, үйл ажиллагаа, бүтцийг тодорхойлох 18 үзүүлэлт нийтиж бүрдэл 44 аргаар өвчний динамиктын 4375 шинжилгээ, 370 электрокоатулограммын бичлэг хийв.

Судалгаанд хамрагдсан өвчтөнг эмнэл зүйн хэлбэрээр нь ангилбал: уушгины хүндрэлгүй хэлбэрийн үрэвсэлтэй 67 (I бүлэг), хүндэрсэн хэлбэрийн хордлогот хам

шинжтэй 72 (II бүлэг), өнгөрт үрэвсэлтэй 38 (III бүлэг), идээрлэлт үрэвсэлтэй 47 (IV бүлэг) өвчтөн байсан болно. Өвчтөний 77,7% нь нэг сараас 7 настай байлаа. Судалгааны ажлын явцаас үндэслэн дараах дүгнэлт, практик зөвлөмжийг гарган эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд мөрдэн ашиглах боломжтой болсон юм.

ДҮГНЭЛТ: 1. Уушгины цочмог үрэвслийн янз бүрийн хэлбэрийн үеийн цус бүлэгнэлт, ялtsan эсийн үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлж, зарим тохиолдолд судсан цус нэлэнхүй бүлэгнэх байдлаар илэрч байна.

2. Цус бүлэгнэх болон ялтсан эсийн үйл ажиллагааны өөрчлөлт нь урэвслийн идэвх, өвчний хэлбэр, үе шатаас хамаарч байна.

3. Цус бүлэгнэх нь ихсэж, ялтсан эсийн үйл ажиллагаа идэвхжиж фибрин уусгах үйлдэл судрах нь уушгины цочмог үрэвслийн хүндрээгүй хэлбэр, өнгөрт үрэвслийн үед харьцангуй зохицсон байдалтай, цусархаг хамшинж илрэхгүй явагдаж байна.

4. Хүндэрсэн хэлбэрийн хордлогот хамшижтэй бүх өвчтөнд судсанд цус нэлэнхүй бүлэгнэх (булэгнэлт хэт ихсэх буюу нэгдүгээр шат) ажиглагдаж байсан бөгөөд, өвчин даамжрахын хэрээр нэгдүгээр шат нь хоёрдугаар шатанд шилжих байдлаар буюу цус бүлэгнэлт багасах байдлаар илэрч, цусархаг хамшинж гарч байгаа нь (20 өвчтөн буюу 16,8%) үл зохицсон байдлыг илтгэж байна.

5. Цус бүлэгнэх, ялтсан эсийн үйл ажиллагаа, бүтцийн хамгийн их өөрчлөлт нь уушгины идээрлэлт хэлбэрийн үед ажиглагдаж байна.

6. Уушгины цочмог үрэвслийн янз бүрийн хэлбэрийн үед эмчилгээний бүрдэл цус тогтонгишил, бичил эргэлтийн хямралыг харгалзан адгез-агрегацийн эсрэг аспирин (0,1—0,3 граар тооцон хоногт 3 удаа) цус бүлэгнэлт ихсэхийн эсрэг гепарин (биеийн кг тутамд 50—300 нэгжээр тооцон хоногт 4 удаа) хэрэглэхэд судсанд цус нэлэнхүй бүлэгнэх хамшинжээс сэргийлэх төдийгүй, өвчний явц, тавиланд үлэмж сайнаар нөлөөлж байна.

7. Уушгины цочмог үрэвслийн янз бүрийн хэлбэрийн үеийн цус бүлэгнэлт ялтсан эсийн тоо, үйл ажиллагаа, бүтцийг өвчний динамикт судлах нь үрэвслийн идэвхжил, өвчний хүнд хөнгөн, бүрдэл

эмчилгээний үр дун, өвчний тавиланг тодорхойлох бодитой шалгуур болно.

ЗӨВЛӨМЖ: 1. Уушгины цочмог үрэвслийн янз бүрийн хэлбэрийн үед өвчний динамикт нь цус бүлэгнэлт, ялтсан эсийн тоо, үйл ажиллагаа, бүтцийг судлах нь тэдгээрийн өөрчлөлтийг цаг алдалгүй оношлох, өвчний явц тавиланг тодорхойлох, бүлэгнэлт ихсэх, адгез-агрегацийн эсрэг эмчилгээний үр дунг хянахад чухал ач холбогдолтой.

2. Уушгины цочмог үрэвслийн үед цус бүлэгнэх, ялтсан эсийн үйл ажиллагаа, бүтцийг судлах, судсанд цус нэлэнхүй бүлэгнэх хамшинж, түүний үе шатыг тогтооход ний бүрдэл үзүүлэлт тухайлбал: ялтсан эсийн тоо, үйл ажиллагаа, бүтцийг судлах, цус бүлэгнэлтийг үе шатаар нь тооцох, фибрин уусгах идэвхижлийг тодорхойлох, электрокоагулограммын шинжилгэхийх шаардлагатай.

3. Цус бүлэгнэлт, ялтсан эсийн үйл ажиллагааны өөрчлөлтийг заасахын тулд уушгины цочмог үрэвслийн үед эмчилгээний бүрдэлд антиагрегант антикоагулянт хэрэглэх нь зүйтэй. Үүнд: өвчний ид үе, судсанд цус нэлэнхүй бүлэгнэх хамшинжийн нэгдүгээр шатанд гепариниыг хүүхдийн кг тутамд 150—300 нэгжээр тооцон хоногт 4 удаа хэрэглэнэ. Харин өвчний хоёрдугаар шатанд (булэгнэлтэнд оролцох хүчин зарцуулагдсан үед) гепариниыг кг тутамд 50—100 нэгжээр тооцон сийвэнгийн (кг тутамд 10—15 мл) хамгаалалтын дор тарьж хэрэглэнэ. Өвчтөний насыг харгалзан аспириныг хоногт 0,1—0,25 граар 3 удаа хэрэглэнэ.

Редакцид ирсэн 1978. 05. 18.

ГАДААДЫН СЭТГҮҮЛД МАНАЙ ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН ТУХАЙ

ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах Яам, бүх холбоотын лаборант эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн сар тутмын «Лабораторное дело» сэтгүүлийн 1987 оны 5 дугаарт тус сэтгүүлийн ерөнхий редактор, ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны лабораторийн эрдэм шинжилгээ-арга зүй, хяналтын төвийн удирдагч, анагаах ухааны доктор, профессор В. В. Меньшиков «Социалист орнууд дахь лабораторийн оношлогооны хөгжлийн туршлага» өгүүлэл нийтлүүлжээ.

Энэ өгүүлэлд 1986 оны IV сард Прага хотод болсон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын экспертуудийн зөвлөгөөн дээр «Лабораторийн оношлогоо» шийдвэрлэх асуудлаар хамтран хийж гүйцэтгэсэн ажлаа хэлэлцэхийн сацуу улс бүхэн өөрийн оронд лабораторийн албыг хөгжүүлж байгаа туршлагаа харилцан солилицсон тухай бичжээ.

БНМАУ-ын мэргэжилтнүүд «ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын клиник лабораторийн тусламжийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах» сэдвийн хүрээнд тус улсын клиник оношлогооны бүх төрлийн лабораторийг хэд хэдэн зэрэглэлд хувааж хийх шинжилгээний жагсаалт боловсруулан баталсан тухай, «Лабораторийн дээд, дунд мэргэжилтний бэлтгэх, мэргэжил олгох, дээшлүүлэх ажлыг боловсронгуй болгох» сэдвийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тухай бичээд энэ нь ойрын жилүүдэд шинжилгээний нэр төрлийг олшируулах шаардлагатай багаж хэрэгс-

лэл, урвалж бодисыг захиалж хангах мэргэжилтнийг төлөвлөгөөтэй бэлтгэхэд үр дүнгээ өгч байна гэжээ.

Тус улсын лаборант эмч нарын үндэсний семинар зохисж, уг семинар дээр клиник лабораторийн шинжилгээний аргуудыг ижилтгэнжигдруулэхэд баримтлах үндэс болсон ЭЗХТЗ-ийн гишүүн орны мэргэжилтнүүдийн боловсруулж баталсан шинжлэгдэхүүний жагсаалт, арга зүйн зарчим, лабораторийн шинжилгээний аргыг стандартчилах, ижилтгэн жигдруулэхэд баримтлах дүрэм, эмчлэн сэргийлэх байгууллагын мэргэжлийн онцлоогоос хамаарч клиник лабораторийн эмчийн тусгай мэргэжлийн бэлтгэлд тавих шаардлага зэрэг асуудал хэлэлцэж лабораторийн практикт нэвтрүүлэх зөвлөмж гарган ажиллаж байна гэжээ.

Гэвч хамтын ажиллагааны зарим сэдэвт ажилд оролцохын тулд тус улсын клиник-лабораторийн материал техникийн баазыг бэхжүүлэх, атом-сорууцын спектрофотометр, хийн хромотограф болон орчин үеийн бусад багаж, тоног төхөөрөмж нэвтрүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэсэн байна.

Монголын мэргэжилтнүүд БНМАУ-ын лабораторийн албыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой «Лабораторийн оношлогоо» шийдвэрлэх асуудлаар ЭЗХТЗ-ийн хамтын ажиллагаанд өргөн хүрээтэй, идэвхтэй оролцох зориг эрмэлзлэл дүүрэн байна гэжээ.

ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын шинжлэх ухаантехникийн дэвшлийн 2000 он хүртэлх цогцолбор программын тэргүүлэх 5 чиглэлийн анагаах ухааны биотехнологийн

салбарт хамтран ажиллах төлөвлөгөөний «Шинэ үеийн биоинженерийн вакцин гарган авах арга, үйлдвэрлэх технологи боловсруулах» даалгаврын хүрээнд мэргэ-

ажилтнүүдийн ажлын анхдугаар зөвлөлгөөн Москва хотноо болов. Энэ даалгаврын хүрээнд томуу, гепатит, хумхаа ба дархлалын олдмол хомсдолын хамшинжийн халдварын эсрэг вакцин бүтээх талаар олон талын гэрээ байгуулж хамтран ажиллаж байгаа юм.

Зөвлөлгөөнөөр хамтын ажиллагааны 1986 оны үр дунг хэлэлцэж ажлын төлөвлөгөөнд зохицуулалт хийв. ЗХУ-д томуугийн В хүрээний вирусийн амьд рекомбинант вакцин бүтээсэн бөгөөд 1988 оноос үйлдвэрлэж эхэлнэ. Хөрөнгөний омог ашиглан гепатитын В вирусийн генийн инженерзүйн ба цагаан цэцэг—В гепатитын рекомбинант амьд вакцин бүтээхээр эрчимтэй ажиллаж байна. Цагаан цэцгийн вакцины рекомбинант омгийг ашиглан хүний дархлалын хомсдолын вирусийн өвөрмөц уургийг нийлэгжүүлж чаджээ.

Зөвлөлгөөний үеэр гепатитын В вирусийн вацкин бүтээх судалгаанд оролцож байгаа манай улсын Эрүүлийг хамгаалах яамны Эрүүл ахуй, халдварт, нянц судлалын улсын институт, ШУА-ийн Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн судалгааны хүрээг өргөжүүлэн ажлын төлөвлөгөөнд зохицуулалт хийв. Гишүүн орнууд хумхаа өвчиний эсрэг нийлэг ба генийн инженерзүйн вакцин бүтээх талаар хамтын гэрээ байгуулах асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх нь зүйтэй гэж узэв. Мөн ин виво хэрэглэх иммунобиологийн шинэ бэлдмэлийг хянах нэгдсэн аргазүй боловсруулах ажлын түр группыг байгуулах талаар хэлэлцэн тохиролцов.

Ж. Оюунбилэг

СЭТГҮҮЛИЙН ДАРААГИЙН ДУГААРТ НИЙТЛЭГДЭХ ЗАРИМ ӨГҮҮЛЭЛ

- Д. Нээчин, Д. Амгаланбаатар, Б. Дагданбазар — Дүрс судлал ба анагаах ухаан
- Г. Цагаанхүү, И. Пүрэвдорж, Н. Төмөрбаатар, З. Бэгэzsүрэн — Нэг удамд илэрсэн паркинсоны өвчин
- Ж. Базардарьяа — Релапортоми хийх заалт
- М. Чүлтэмсүрэн, Г. Чойжамц — Гашуун бандоогийн (Saussured amara L) фитохимиийн ба фармакологийн судалгааны урьдчилсан дүн
-

ШИНЭ ЭМ

КСИКАЙН (ЛИДОКАИН)



Фармакологийн үйлдэл: Ксикайн хэсгийг мэдээгүйжүүлэх хугацаа нь новокаинаас хоёр дахин илүү юм. Энэ бэлдмэл нь сульфаниламидын бэлдмэлүүдийн бактерийн эсрэг үйлдлийг сургуулдаггүй бөгөөд түүний хоруу чанар уусмалын концентрацис шалтгаална. Концентраци ихсэх тутам (1—2%) хоруу чанар нь 50% хүртэл нэмэгдэнэ. Ксикайн нь өвчтөний амьсгал, артерийн даралтад нөлөөлдөггүйгээс гадна цочроох үйлдэл үзүүлэхгүй.

Хэрэглэх заалт: Нүдэнд хийх жижиг хагалгаа, хамар хоолойн ур, самалдаг чихэнд хийх хагалгаа, хэвлэйн ба цээжний хөндий, шүд, шээсний замын болон эмэгтэйчүүдийн өвчинүүдэд хөнгөн хагалгаа хийхэд хэсгийг мэдээгүйжүүлэх зорилгоор тус тус хэрэглэнэ.

Хэрэглэх арга түү: Хөнгөн хагалгааны үед голдуу 0,5% уусмалыг, 500 мл-ээс дээш хэмжээний уусмалыг хэрэглэх хагалгааны үед 0,25%-ийн уусмалыг хэрэглэнэ. Ксикайныг адреналины гидрохлоридын уусмалтай хамт хэрэглэж болно.


Цээрлэх үед: Ксикайнд хэт мэдрэг хүмүүс, зүрх судасны системийн дутагдал, эзлэг бөөрний өвчтэй хүмүүст хэрэглэж болохгүй.

Гаж нелөө: Толгой эргэх, бие сурлах, цусны даралт буурах, муужрах, арьс үрэвсэх зэрэг гаж нелөө ажиглагдаж болно.

Эмийн хэлбэр: Нунтгаар бэлтгэн гаргана. Бас 0,25, 0,5, 2%-ийн уусмалыг 2 мл-ээр ампултай үйлдвэрлэнэ.

Хадгалах: Амьг нь сайтар тагласан саванд хийж гэрэлгүй газар хадгална.

УЛСЫН ЭМ ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГАЗАР



Ж. Чимэдцэрэн—ХҮН ЭМНЭЛГИЙН ЭНТИМИОЛОГИ

Энэ номд хүний эруул мэндэд хортой хорхой шавьжийн биологи, экологийн онцлог, хорхой шавьжаар дамжин хүнд халдварладаг зарим өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой өгүүлсэн байна.

Номыг эмч, биологич наарт зориулжээ.

Ч. Дамдинсүрэн—НЯНГИЙН УГ ШИНЖ

Нян судлалын анхны алхмууд, нян судлалын арга, нянгийн шинж, ангилал, метаболизм, бичил махбодын өсөлтийг орчин үеийн молекуляр биологийн түвшинд тулгуурлан бичсэн байна.

Энэ ном нь манай орны биологич, микро биологич, ургамал судлагч, малын эмч, хөнгөн ба эмийн үйлдвэрийн нян судлэгч, хөдөө орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүдэд гарын авлагы болох юм.

ШИНЭ НОМ